

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-89
1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	8-36
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	36-61
3.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан	61-63
4.Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонсох.	63-89

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Ж.Бүжинханд, Б.Ариунжаргал, М.Пагмадулам, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, шинжээч Б.Цагаанцэцэг, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ,

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Э.Мөнхсүх, мөн яамны ерөнхий нягтлан бодогч С.Цогзолмаа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Оюун, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гулзат, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Б.Баасандолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, Б.Бат-Эрдэнэ, О.Саранчулуун, Д.Үүрийнтуяа, Б.Бейсен, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Э.Мөнхсүх, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Саранчулуун, Д.Үүрийнтуяа, Б.Бейсен нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Ж.Бүжинханд, Б.Ариунжаргал, М.Пагмадулам, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, шинжээч Б.Цагаанцэцэг, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Э.Мөнхсүх, мөн яамны ерөнхий нягтлан бодогч С.Цогзолмаа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Оюун, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гулзат, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Б.Баасандолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Ц.Баатархүү, Д.Үүрийнтуяа, Д.Ганмаа, Б.Бейсен, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн

санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нэр дэвшигч Г.Адъяа, Хараат бус шинжээч Д.Далхжав, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдаанд Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Энхнасан: Цэндийн Сүхбаатарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, С.Зулпхар, Д.Үүрийнтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Энхнасан: Гончигсүрэнгийн Адъяаг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	5
Бүгд:	17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Макро зохистой бодлогын хэлтсийн захирал Н.Батболд, Хууль, эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, мөн Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референт Э.Сансар, Санхүүгийн зохицуулах хорооны банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, ахлах шинжээч Г.Тэмүүжин, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, иргэн Ц.Алтанзул, Э.Ганбаатар, Д.Гантөмөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Э.Батшугар, Ц.Баатархүү, Б.Бэт-Эрдэнэ, Д.Ганмаа, Э.Болормаа, Л.Энхнасан, иргэн Ц.Алтанзул нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван хариулж, тайлбар хийв.

Иргэн Ц.Алтанзул, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Ц.Идэрбат, С.Зулпхар, С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, О.Саранчулуун, Д.Үүрийнтуяа, Э.Болормаа, Л.Энхнасан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаарх Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайвангийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 20 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0хувийн ирцтэйгээр 20 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 45 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр өглөө 9-өөс эхлүүлээд манай Байнгын хороо маш идэвхтэй хуралдаж байгаа. Өглөөний хуралд суусан, сууж байгаа гишүүддээ баярлалаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирж, Байнгын хорооны ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн үдээс хойших хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь дараалан танилцуулна.

Аюушийн Ариунзаяа гишүүн 10 дугаар тойрог, Цэндийн Баатархүү гишүүн 4 дүгээр тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн 10 дугаар тойрог, Хөххүүгийн Болормаа гишүүн, Сардахын Зулпхар гишүүн 6 дугаар тойрог, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Мягмардашид Сарнай гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нар иржээ. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Гуравдугаарт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан.

Дөрөвдүгээрт, Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна. Тийм учраас хэлэлцэх асуудалдаа орёё.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ярилцах хэлэлцэнэ.

Энэ төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулна уу. Ажлын хэсэг орж ирж байна. Ажлын хэсэг орж ирж байгаа. Ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ орж ирээгүй байна. Жавхлан сайд ороод ирчихсэн учраас Жавхлан сайд танилцуулгаа хийж байх уу.

Нэгдсэн нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Нийгмийн даатгалын сан, Соёл, спорт, аялал, жуулчлалын залуучуудын сайд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн сайдын багцын нийт 303 байгууллагын 39 төсөл, сан, төрийн өмчийн 4 аж ахуйн нэгж, 260 төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 10 их наяд 934 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардал 12 их наяд 529.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 415.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн 312 төсөл, арга хэмжээнд 415 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл нь 72.3 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа сайдад. Ажлын хэсгийг танилцуулъя. Жавхлан Сангийн сайд, Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Чинбүрэн сайдыг дуудъя. Ундрам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд. Аубакир сайдыг дуудъя. Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Очирбат даргыг дуудъя. Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Оюунбилиг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга дуудъя. Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Наранчимэг Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Энхболд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Цогбаяр Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцог Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцэцэг Санхүү, нийцлийн аудитын аудитын менежер, Бүжинханд Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ариунжаргал Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Пагмадулам Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Энхтуяа Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Оюунхүү Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Идэрбалжинням Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгдлийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Цацрал Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цагаанцэцэг Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Гантогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөлтийн хэлтсийн дарга, Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга, Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Баярсайхан Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Оюунчимэг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар Мэдээлэл технологийн хяналтын шинжилгээ, үнэлгээний газрын дарга. Энхболд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Оюун Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Гулзат Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний ерөнхий газар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн, Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Алтанцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гэрэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын дарга, Шинэчимэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын туслах, Баасандолгор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ерөнхий нягтлан бодогч, Мөнхсүх Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга, Цогзолмаа Эрүүл мэндийн яамны ерөнхий нягтлан бодогч, Энхболд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Батчимэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Отгонбат Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. Ажлын хэсгийг танилцууллаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн дарга танилцуулна. 7 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 163 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 139 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 24 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, харьяа 102 байгууллагад өөрчлөлтгүй, 34 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 141.2 тэрбум төгрөгийн зөрчлөөс 0.2 тэр тэрбум төгрөгийн зөрчилд 62 төлбөрийн акт, 105.7 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоож 62 албан шаардлага, 2.8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 9 албан шаардлага хүргүүлж, 32.2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 207 зөвлөмж өгч, 0.2 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлээд байна.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 95.5 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 тэрбум төгрөгийн алдааг залруулах зөвлөмж өглөө.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
Үүнд:

Эрсдэлд суурилсан дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг бууруулах.

2.Тухайн онд бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлж өгөх.

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах эдгээр болно.

2.Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 450 санхүүгийн тайлан нэгтгэснээс 353 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 97 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 289 байгууллагад өөрчлөлтгүй, 59 байгууллагад хязгаарлалттай, 3 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 2 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 113.9 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.4 тэрбум төгрөгийн зөрчил 269 төлбөрийн акт тогтоож, 89.7 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, 462 албан шаардлага хүргүүлж, 19.2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 650 зөвлөмж өгч, 3.1 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 18 албан шаардлага, 0.5 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 133.6 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
Үүнд:

1.Өмнөх онуудад ашиглалтад орсон барилга, их засварын ажлыг холбогдох дээд шатны байгууллагын шийдвэр гаргуулж, ашиглагч байгууллагын данс бүртгэлд бүртгүүлэх.

2.Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй өмнөх онуудаас хуримтлагдсан хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд давхар бүртгэсэн алдааг залруулах эдгээр болно.

3.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, 2 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 77 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага, 76.8 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж

өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4.3 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1.Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 76 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, рашаан, сувиллын өмнөх онуудаас дамжиж ирсэн 0.1 тэрбум төгрөгийн авлагыг тус тус барагдуулах.

2.Чингис хаан банканд байрших сангийн харилцах дансны үлдэгдэл 27.9 тэрбум төгрөгийг тус банкаар төлүүлэхээр СБД-ийн Иргэний хэргийн Анхан шатын 2020 оны шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах эдгээр болно.

4.Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 санхүүгийн тайлан нэгтгэх 20 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 13 сангийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаар нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 15 сангийн санхүүгийн тайланд өөрчлөлтгүй, 4 сангийн санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 сангийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 322.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.01 тэрбум төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 169.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, 16 албан шаардлага 143.4 тэрбум төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй 27 зөвлөмж, 9.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 их наяд 794.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж ажиллалаа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна. Үүнд:

Чингис хаан банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай байгаа байдлыг дүгнэлт хийж тодорхой арга хэмжээ авч ажиллах.

2.Капитал банкны эрх хүлээн авагчаас авах эрсдэлтэй байгаа авлагыг хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ хангалтгүй байгаа зөрчлийг арилгах, хүлээж авсан хөрөнгийг борлуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.

3.Олон жилийн насжилттай найдваргүй болох эрсдэлтэй иргэн, ААНБ-аас авах авлагыг хууль хяналтын байгууллагад хандан үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээ авах эдгээр болно.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг санал болгож байгаа байна. Үүнд:

1.Чингис хаан банкин дахь харилцах дансанд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн 93.4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын 27.9 тэрбум

төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тус банкнаас гаргуулах шүүхийн шийдвэрийг бүрэн хангуулах арга хэмжээ авах.

2.Капитал банкны эрх хүлээн авагчаас авах Нийгмийн даатгалын сангийн 65.7 тэрбум төгрөг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 76 тэрбум төгрөгийн авлагын барагдуулалт удаашралтай байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.

3.Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд бодлогын шинэчлэл хийх.

4.Нийгмийн даатгалын сангийн чөлөөлөлт үлдэгдлийг мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад тулгарч байгаа асуудлыг салбарын хууль тогтоомж, журам, заавартай нийцүүлэх холбогдох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

5.Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цар хүрээ, нэр төрөл, зориулалтын шалгуур тодорхойгүй, тухайн хөрөнгө оруулалтын зардалтай холбоотой төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах.

6.Аудитаар тогтоосон төлбөрийн акт өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчил гаргахгүй байх зэрэгт анхаарах шаардлагатай байна.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Ерөнхий аудиторт баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын хийсэн танилцуулга болон аудитын тайлантай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

А.Ариунзаяа: Төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор нийтлэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гүйцэтгэл 97.6 хувьтай гэж байгаа юм. Гэхдээ дотор нь дахиад задлаад энэ чинь нөгөө үндсэндээ маш их мөнгө байдаг учраас энэ дотор нь задлаад харахлаар нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд маань 77.7 хувийн л гүйцэтгэлтэй байгаад байгаа байхгүй юу. Энийг цаана нь 94 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гэдэг чинь төлөвлөгдсөн 121-ээс 94 гэхлээр цаана нь бараг 30-аад орчим тэрбум төгрөг хэмнэгдсэн гэж үзэх юм уу, зарцуулагдаагүй. Гүйцэтгэл багатай байна л даа.

Тэгэхээр энэ ямар хөтөлбөр нь хэрэгжээгүй болоод ийм хэмнэлт үүсчхэв ээ? Энэ жилийн хувьд энэ хөтөлбөр нь хэрэгжилт нь ямар байгаа вэ? Яг төсвийн тодотгол дараагийн ээлжид орж ирэх учраас энэ угаасаа гүйцэтгэл муутай байгаа хөтөлбөр байгаа юм бол үүн дээр бас дараагийн арга хэмжээ авах боломжтой эсэхийг тооцоолох гэсэн юм.

Хоёр дахь нь болохлоор Нийгмийн даатгалын, Эрүүл мэндийн даатгалын өр, авлага бид нар мэднэ. Капитал банк болон тэр чинь Капитал банк болон Чингис хаан банк байгаа. Энэ бол яах вэ болж байна. Бид нар ажиллаж байгаа хүндрэлийг нь би мэдэж байгаа. Олон жил дамнаад ирчихсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бас ийм өр, авлага байгаад байдаг юм.

Тэгэхээр энэ бараг Хөдөө аж ахуйн яамнаас бас тухайн үедээ ирж байсан ийм бараг 20 жилийн өмнөх авлага шиг санаад байх юм. Энийг надад тодруулж өгөөч. Энэ угаасаа эргүүлэн авах боломжгүй гэдэг нь ойлгомжтой байгаа юм бол үүнийгээ бас хуралдаад тэглэх бас ийм боломж байгаад байдаг шиг санаад байх юм. Энэ нь энэ тал дээрээ ажиллахгүй бол мөнхийн л энэ өр, авлага барагдуулсангүй гэдэг ийм үнэлгээтэй явах гээд байна. Яг энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн өр, авлагын гүйцэтгэл 15.4 хувьтай л гарсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ уг нь эргүүлээд зөв талд нь өөрчлөх хэрэгтэй байгаад байдаг. Ямар асуудал байгаа билээ. Энийгээ тодруулж өгөөч.

Ер нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн энэ үйл ажиллагаа бол бусдаар гүйцэтгүүлэх боломжтой л гэж би үздэг юм. Энийг бол манай ажилтнууд яг банкны теллер шиг ажиллаад байдаг нь өөрөө бас буруу тийм зарчим ажиллаад байгаа. Тэгэхээр энийг бас өөрчлөх халамжаас хөдөлмөрт шилжих энэ бодлогыг яг төгсөлтийн аргачлал л хэрэгжүүлж байгаа энэ төслийнхөө хүрээнд яг адилхан зорилтот бүлэгтээ буюу яг халамж авч байгаа өрхүүдээ хөдөлмөрт зуучлах энэ боломжийг нь ашиглаж энэ төсөл, хөтөлбөрүүдийнхээ шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай байна гэж үзэж байна. Тэгэхээр асуултад хариулсны дараа дахиад тодруулъя.

Л.Энхнасан: Баярлалаа. 2 сайд маань хаана байна? Чинбүрэн Эрүүл мэндийн сайд Чинбүрэн? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакирыг дуудна уу. Сайд иртэл Мөнхзул дарга хариулах уу? 3 дугаар, 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Нийгмийн бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөр дотор зориулалт 7-гоор гэсэн кодтой хөтөлбөрийг аваад үзэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөлбөрийн хэрэгжилт 77 хувьтай. Эндээс 6 тэрбум төгрөг зарцуулагдаагүй. Мөн хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрөөс 13 тэрбум төгрөг зарцуулагдаагүй байгаа. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөлбөрөөс зарцуулагдаагүй үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр Архангай аймагт баригдаж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга барилгын үйл ажиллагаа нь зогссон 24 онд ашиглалтад орохоор төлөвлөгдөж байсан боловч энэтэй холбогдолтойгоор урсгал зардал хэмнэгдсэн.

Мөн түүнчлэн Улаанбаатар хотод баригдаж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүний Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн бас барилгын үйл ажиллагаа 10 сард ашиглалтад орно гэж урсгал зардал тавигдсан байсан боловч 25 оны 1 дүгээр сараас ашиглалтад орсон учраас урсгал зардал бас хэмнэгдсэн ийм зохицуулалт байгаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 500 орчим сая төгрөг бас зарцуулагдаагүй үлдсэн гэсэн ийм зарцуулалт байна. Хүүхэд хамгааллын хөгжил хөтөлбөрөөс мөн хэмнэгдсэн гол зардал маань Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхэд хамгааллын зардал бас зарим аймгуудад зарцуулагдаагүй. Улаанбаатар хотод зарцуулагдаагүйтэй холбогдолтой. Энд болохоор бас мөн

эхний хагас жил хэрэгжилт нь удааширсандаа бас холбогдолтойгоор тус тус хөрөнгүүд гүйцэтгэл бага гарсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд он удаан авлага авлагдсан асуудлаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга бас Энхболд дарга тайлбар хэлнэ.

Л.Энхнасан: 5 номер.

3.Энхболд: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга Энхболд. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагаанд явж байдаг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгаа. Энэ дэмжих сан дээрээс холбогдуулаад авлагын хэмжээ 2024 оны байдлаар 37.6 тэрбум төгрөгийн авлагатай байгаа, байсан. Үүнээс бол 2 тэрбум 221 сая төгрөгийн авлагыг барагдуулсан 2024 оны хувьд. Мөн 2024 онд бид нар бас шинээр 13 тэрбум төгрөгийн авлага үүсгээд нийтдээ 53 тэрбум тэрбум төгрөгийн авлагатай явж байгаа. Сая гишүүний асуулт дотор орж ирж байгаа энэ томоохон авлагуудын хувьд Оёдлын нэгдсэн холбоо гэх байгууллага руу Хөдөө аж ахуйн ямаар дамжуулан зээлдүүлэх зорилгоор 2013 онд Засгийн газрын 250 дугаар тогтоол гарч, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээрээс 17 тэрбум төгрөг дамжуулан зээлдүүлсэн. Энэ дамжуулан зээлдүүлсэн төлбөрийн барагдуулалт бол явж байгаа хэдий ч хангалтгүй байгаа. Үүн дээр бол бид нар Оёдлын нэгдсэн холбоогоос 2024 оны хувьд 443.6 сая төгрөгийн авлага барагдуулсан. Үндсэн авлага дээр 12.9 тэрбум төгрөг. Зээлийн хүү, алданги 2.7 тэрбум төгрөг. Нийтдээ 17 тэрбум төгрөгийн авлага үлдэгдэлтэй явж байна. Капитал банкин дээр бид нар Үндсэн зээлийн 1.3 тэрбум төгрөг хүү, алдангийн 2.5 тэрбум төгрөг нийтдээ 3.8 тэрбум төгрөгийн авлагатайгаас 2024 онд 36.5 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Анод банк 2009 оны авлагаар шүүхийн шийдвэрээр 800 сая төгрөг авлагатай байдаг гээд эдгээр 10 гаруй жилийн хугацаатай хүлээгдэж байгаа авлагуудыг бол энэ.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя.

3.Энхболд: 2024 оны хувьд 600 гаруй сая төгрөгийн авлагыг барагдуулж эдгээр авлагууд, мөн жижиг зээлтэй буюу иргэдэд олгосон авлагуудыг нийт дүнгээр нь авч үзэх юм бол 2 тэрбум 221 сая аравны 6 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ийм үзүүлэлттэй явж байна. Нийт авлагын дийлэнх нь эдгээр 3 төрлийн том авлага байгаа. Үүнээс гадна иргэдийн сүүлийн 10-аад жилийн хугацаанд олгосон 364.2 сая төгрөгийн авлага байгаа. Энэ жижиг зээлийг иргэдэд олгосонтой холбоотой. Энэ авлагыг бол аймаг, дүүргийн хэмжээнд зохион байгуулан авах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Ариунзаяа гишүүн тодотгол хийнэ үү.

А.Ариунзаяа: Ер нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол Засгийн газрын бүтцийн яам болохоос биш банк бол биш тээ? Банк бус бүр биш. Тийм учраас ер нь энэ зээлдүүлдэг ийм төсөл, хөтөлбөрүүдээ хэдүүлээ болж өгвөл уг нь банкаар дамжуулаад өөрсдөө магадгүй татаас хэлбэрээр бусад энэ төрийн бодлоготой адилхан хөнгөлөлтийг нь гэдэг юм уу, татаасыг нь гэдэг юм уу хүүгийн энэ хэлбэрээрээ дэмжих тал руугаа орохгүй өөрсдөө банк шиг ажилладаг нь эргээд нэгдүгээрт ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг учраас бас зарим хэнд илүү

давуу байдал үүсгэж байна вэ, яаж байна вэ гэдэг ийм асуудал өнгөрсөн хугацаанд үүссэн.

Хоёр дахь нь болохлоор буцааж энэ мөнгөө авч чаддаггүй. Манай уг нь бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр ажиллах ёстой төрийн албан хаагчид, мэргэжилтнүүд банкны теллер шиг ажиллаад байгаа байхгүй юу. Авлагынхан шиг. Тэгэхээр энийгээ ердөөсөө чаддаггүй. 13 жилийн өмнөх энэ Оёдлын нэгдсэн холбооны асуудлыг яг нэхэмжлэх хүн байгаа юм уу, үгүй юм уу гээд.../минут дуусав./

Л.Энхнасан: 5 дугаар микрофон.

3.Энхболд: Оёдлын нэгдсэн холбоод дамжуулан зээлдүүлсэн байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байсан тухайн үед. Шууд Оёдлын нэгдсэн холбооноос нэхэмжлэл үүсгэж шүүх дээр хэд хэдэн удаа очсон боловч прокуророос бол Оёдлын нэгдсэн холбоо зээл аваагүй, хариуцагч биш байна аа гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг үзсэн байдаг. Үүнтэй холбогдуулаад шууд хариуцагчаар татах байгууллага нь бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болчихоод байгаа юм. Төрийн байгууллага төрийн байгууллага хоорондын нэхэмжлэлийн асуудал үүсээд үүн дээр Улсын прокуророос бас дэмжлэг хүсэж ажилласан. Гэхдээ энэ дээр бол төрийн байгууллага хоорондын асуудлыг яам хоорондын шугамаар Засгийн газар дээр шийдвэрлэхээр ийм чиглэлүүд гараад явж байгаа.

Л.Энхнасан: Ариунзаяа гишүүн тодотгол.

А.Ариунзаяа: Харин энийгээ аудиттайгаа хамтдаа ер нь шийдлээ олоод явахгүй бол хэчнээн жил муу ажилласан гэдэг дүн авах юм бэ дээ. Тийм байгаа биз дээ? Тэгэхээр чинь өөрсдөө л муу дүн аваад байна шүү дээ. Тэгэхээр энэ прокурорын шийдвэр байгаа юм бол үүнийгээ Засгийн газар дээрээ оруулаад шийдвэрлүүлээд явахгүй бол хязгаарлалттай дүгнэлт авдгийн хамгийн гол учир шалтгаан чинь энэ шүү дээ. Тэгэхээр энийгээ та бүхэн маань шийдээрэй гэж хүсье.

Хоёр дахь нь болохлоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг хэд, банк, банк бус шиг биш харин сая хэрэгжүүлсэн сая хэрэгжүүлсэн төслийн аргачлалын энэ хэлбэрээрээ ядуурлын бууруулах буюу халамжаас хөдөлмөрт шилжих энэ бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу.

С.Эрдэнэбат: 2024 оны төсвийн мэдүүлэг. Ер нь бид нар цаашдаа энэ төсвийн үр дүнг цөөн хэдэн тоогоор илэрхийлэх энэ зүйл дээр илүү анхаарал хандуулмаар байгаа юм. Баахан мөнгө тавьдаг, тэнд олгосон, санхүүжүүлсэн, ингэсэн гээд. Энэний үр дүнд хэчнээн хүнд ажлын байр бий болгов? Хэчнээн хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэв? Хэчнээн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ийм байдлыг сайжруулав гэдэг ийм байдлаар ярихгүй бол ерөнхийдөө зарсан, үрсэн, дутуу, илүү гарсан гэдэг дээр хэдэн тоо ярьсхийгээд л бүтэн жилийн төсвийнхөө үр дүнг иймэрхүү хэмжээнд ярьж байгаа нь жоохон харамсалтай байна.

Эрүүл мэндийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал гээд тэр банкнуудад байж байгаа авлагууд байгаад байгаа. Энд алданги тооцож байгаа юм

байна уу, байхгүй байна уу? Алданги тооцохгүй байхаар хэзээ ч төлсөн яадаг юм гээд л наадах чинь л дахиад л баахан юм байгаад байна шүү дээ. Тийм учраас энэ тал дээрээ тэр хурааж авсан хөрөнгө байдаг юм бол тэрийг нь борлуулна гээд л баахан асуудал оруулж ирж байсан. Тэр нь борлогдоогүй юм уу, эс үгүй бол бүүр тэр хүн борлуулж авах тийм үнээр зарагдахгүй хэмжээний баахан юм авчихсан юм уу энэ чинь. Багагүй хэмжээний мөнгө байгаад байдаг. Энэ дээр тодруулж авмаар байна. Эрүүл мэндийн яаман дээр тэр гэрээт ажил гээд баахан зүйл байгаад байна. Энэ яг юу байдаг юм бэ? Хөдөлмөрийн яаман дээр БНСУ-ын нийгмийн даатгалын юу гэдэг ч юм татан буулгачихсан уу яалаа? Энэ чинь тэг гээд зардал байхгүй. Энэ дээр тодруулж өгөөч.

Эрүүл мэндийн яамнаас хэлэхэд энэ өнгөрсөн жил энэ энэ бүс болгонд MRI аппарат аваад өгчих боломж байдаггүй юм уу? Төсөв тодорхой хэмжээгээр хэмнэгдэх энэ тэр асуудал гарвал шилжүүлэх байдлаар шийдээд тавихгүй бол мянган км-ийн цаанаас хүмүүс чинь MRI-д үзүүлэх гээд Улаанбаатар хотод бөөнөөрөө очерлоод яваад байна. 2025 оны энэ төсөв дээр иймэрхүү байдлаар нэн яаралтай гэсэн юмаа тавьсан уу? Сураг сонсох нь 60-аад тэрбумынхаа юмыг эргүүлээд тендерээ зарлаж чадахгүй байж байгаад татуулчихсан сураг байна лээ. Энэ тал дээр Жавхлан сайд аа яг ийм хүндэтгэн үзэх шалтгаантай юман дээр бас эргээд энэ Эрүүл мэндийн яамны тендерээ зарлаж чадаагүй ганц нэгэн албан тушаалтны хохь гэдэг байдлаараа биш бас энийг тусад нь авч үзэхгүй бол энэ цаанаа олон хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал учраас та энэ дээр бас Сангийн сайдын хувьд Чинбүрэн сайд 2 байж байна. Энэ дээр харж үзвэл яасан юм бэ?

Хөдөө орон нутгаар явахаар их сонин сонин юм нэхдэг юм. Нярайн шарлагын аппарат байвал өгөөч гэнэ. Сумын багийн төвийн багийн эмч нар хөдөө бараг 50, 60км хол явах юм мотоцикл шийдэж өгөөч эд нар гээд л энэ мэт ийм асуудлуудыг дэс дарааллаараа шийдчих боломж, бололцоо ер нь байдаггүй юм уу? Өнгөрсөн онд хэчнээн хүн тэр багийн эмч нарын хэд нь унаатай байгаа юм гэдэг дээр би бас тодруулга авмаар байна. Дараа нь би тодруулж асууя даа.

Л.Энхнасан: Жавхлан сайд хариулах уу?

Б.Жавхлан: Чинбүрэн сайд бас мэргэжлийн талаас нь хариулт нэмж хариулна биз. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хэрвээ бид нар ингэж буцааж тавиад байх юм бол ер нь ийм Хэмнэлтийн хуулиар яах юм? Хэмнэлтийн хуулиа бүр больчихвол яадаг юм. Ноднин эрүүл мэндийн салбар салбар салбаруудаа тоног төхөөрөмжид тавьж байхад пүү паа яасан их зардал вэ, яасан их тэлж байна аа л гээд байсан одоо бүгдээрээ пүү паа яасан аймаар хасаад байна аа гээд бүгдээрээ салбар салбар дээрээ хайртай болоод нөгөө тийшээ уралдаад. Ингэмээргүй л байгаа юм.

Хэрвээ буцааж тавих юм хойтон ч гэсэн энэ хариуцлагагүй байдал үргэлжилнэ шүү дээ яам дээр нь. Хэмнэлтийн хуулийг энэ байх ёстой. Хэрэгжих ёстой. Ер нь аль ч салбар дээр Хэмнэлтийн хуульд орсон хасагдсан зүйлүүдийг буцааж тавина гэдэг ийм зүйл бол байхгүй. Надаас л лав тийм санал гарахгүй Засгийн газар дээрээс ийм санал гарахгүй. Тийм учраас яг эрүүл мэндийн ч гэлтгүй бусад бүх салбарууд дээр маш хайран шүү дээ. Ноднин бид нар юу болж арайхийж ийм төсвүүд тавилаа. Гэтэл хар аа энэ чинь ганц эрүүл мэндийн салбар биш нийтдээ 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хэмнэгдэж байгаа шүү дээ. 535 эрүүл мэндийн салбар дээр 69 байгаа юм бүгд л хайран бүгд л ард нь салбар

салбарын хөгжлийн зорилтууд энэ хэмжээгээр хойшоо сууж байна гэсэн үг. Нөгөө Ки Пи Ай-ууд чинь энэ хэмжээгээр суларч байна гэсэн үг. Маш харамсалтай энэ салбар нь өөрөө ёстой, энэ хариуцлагаа харин ухамсарлах ёстой хойтон ийм байдал дахиж давтаж гаргаж болохгүй. Тийм ингэж л явмаар байгаа юм.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сайд Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Мэдээж хөрөнгө оруулалтын ялангуяа их өндөр үнэтэй биш жижиг тоног төхөөрөмжийн ийм дутагдал өдийд шийдчихсэн, өөрснөө санхүүжилтээрээ, гүйцэтгэлээрээ бас илүүдэл мөнгөөр авчихдаг болох ийм тогтолцоог хийж зорьсон боловч энэ зорилгодоо хүрч чадаагүй санхүүжилтийнхээ үнэлгээг дутуу хийсэн, гүйцэтгэл нь гүйцэд орж ирдэггүй хасуулдаг энэ болгонтой холбоотой эмнэлгүүд нь өөрсдөө бие даагаад хэрэгтэй тоног төхөөрөмжүүдээ шийдээд явах ийм боломж нь биеллээ олоогүй харамсалтай тохиолдол. Энэ болгоныг сайжруулахын тулд бид тогтолцооны том өөрчлөлт хийхээс өөр аргагүй боллоо. Тэр утгаараа л ер нь Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн даатгалын сан 2 нэг дор байх нь тийм давуу тал харагдахгүй байна гэдэг өнгөрсөн 3 жилийн хугацаанд бидэнд харагдаж байна. Нэмээд хариулчих уу? Цаг дуусаж байна.

Л.Энхнасан: Нэмж хариулъя. Чинбүрэн гишүүний, сайдын микрофоныг өгнө үү.

Ж.Чинбүрэн: Тийм учраас бид дараагийн том мэдээж сая Жавхлан сайдтай би санал нэг байна. 69.8 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтаа хийж чадалгүй хураалгачихсан гэдэг хариуцлагын асуудал. Бидэнд бас таны хэлж байгаа сая MRI-ийн тухай ярилаа. Тэгэхлээр бид аймаг болгон иргэддээ яаралтай тусламж, түргэн тусламж, амь тэнсэн үеийн тусламж, эрчимт эмчилгээг жигд аймаг болгон иргэддээ хүргэж чаддаг байх ийм тогтолцоог хийх зорилго тавин сая дөнгөж саяхан би бас энэ Эй Ди Би-д санал болгох гэж байгаа Эй Ди Би-гийн санхүүжилттэй санал болгох гэж байгаа төслүүдээ бас яриад энэ дээр бүүр цогцоор нь бүх аймгуудад эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийг хүн 20 минут дотор л амь тэнсэн үедээ тусламж авахгүй л бол бүсийн оношилгоо төвөөр явахгүй Улаанбаатар руу явж чадахгүй, онгоцоор нисэж чадахгүй ийм уудам нутагтай Монголын иргэдэд энэ тусламж ойртохгүй байгаад байгаа юм. Тэгэхлээр энд хэрэгжүүлэхээр бас том бодлогын бичиг баримтыг бэлдээд сууж байна.

Л.Энхнасан: Сангийн алдагдалтай холбоотой. Алданги тооцдоггүй гээд. 2 дугаар микрофон Энхболд дарга хариулна уу.

С.Энхболд: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Капитал банкны 136 тэрбум төгрөгийн өр, авлагаас 46.7 тэрбумыг үл хөдлөхөөр авсан. Үүнээс 11.8 тэрбум төгрөгийг үл хөдлөхийг борлуулж Даатгалын санд орлого олж төвлөрүүлсэн. Үлдэгдэл 34.9 тэрбум төгрөгийн 15 объект байгаа. Энэ 15 объектыг бас түрээслэх, мөн бас хувь лизинг тохирох маягаар бид борлуулалтын арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа. Үүнээс 15 үл хөдлөхөөс 3 үл хөдлөхийг лизингээр авах үнийн санал ирсэн. Бид бүхэн ЭМДҮЗ-тэй танилцуулж энэ шийдвэрүүдийг гаргаад явдаг.

Чингис хаан банкин дээр байршсан мөнгөн дүнгийн хүү жилдээ 900 гаран сая төгрөг хүү бодогдож бид

Л.Энхнасан: Нэмж хариулах уу болчихсон уу? Мөнхзул дарга нэмж хариулъя. 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах авлага 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 104.2 тэр тэрбум төгрөгөөр хаагдсан. Эрх хүлээн авагчдаас хөрөнгө хүлээж авсан 13 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр барагдуулсан. 25 тэрбум төгрөгийг үл хөдлөх хөрөнгөөр барагдуулсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр 78 ширхэг хөрөнгийг авч борлуулаад 25 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, нийтдээ 38 тэрбум төгрөгийн өрийг барагдуулаад одоо 65.4 тэрбум төгрөг байгаа. Тэгэхээр Ариунзаяа болон Эрдэнэбат гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Манай энэ нийгмийн даатгалын байгууллага үндэсний зөвлөлөөрөө хэлэлцээд энэ хөрөнгүүдийг зах зээлийн үнэлгээг нь тогтоох замаар холбогдох мэргэжлийн байгууллагаар борлуулах үйл ажиллагааг бас манай нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд ажлынхаа хажуугаар давхар гүйцэтгэдэг. Энэ бас тодорхой хэмжээнд.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцэж хариулах уу? Аубакир сайд хаана байна? Сайдаа дуудаарай. Баярмаа гишүүн асуултаа асуух уу? Сайдыг дуудаарай.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Монгол Улс хавдрын маш их асуудалтай ийм орны тоонд орж явдаг. 100 мянган хүн тутамд оногддог нас баралтынхаа тоогоор бараг дэлхийд нэгд гэж явдаг ийм статистик байдаг юм байна лээ. Жил болгон бараг 7 мянган хүн шинээр хорт хавдар өвддөг. 65 хувь нь хожуу гээд байгаа юм. 60 хувь нь орон нутгаас ирдэг гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээрээс чинь бид нар мэдээж зөвхөн ор, эмнэлэг чухал биш гэдгийг ойлгож байгаа. Урьдчилан сэргийлэх тэр асуудал дээрээ илүү түлхүү анхаарал хандуулах ёстой. Ор битгий хөөцөлд гэж манай мэргэжлийн хүмүүс хэлдэг боловчиг саяын энэ 2 дүн юуг харуулж байна гэвэл зайлшгүй хэвтэж эмчлүүлэх шаардлагыг энэ 2 дүн харуулж байгаа юм. Ялангуяа 60 хувь нь орон нутгаас гэхээр.

Тэгэхээр нөгөө Хавдрын эмнэлэг 2-ын маань бүтээн байгуулалт, барилгын ажил юу болж байгаа юм бол? Дээрээс нь миний санаж байгаагаар ноднин нөгөө дахиж тодотгол хийх үеэр нөгөө юу билээ шинээр худалдан авах эмнэлгийн барилга, Энэ ажил нь ямаршуу түвшинд яаж байгаа юм бол? Энэ бэлэн эмнэлгийг шууд худалдаж авах нь зүйтэй. Яагаад гэвэл ерөөсөө энэ шинэ эмнэлэг ашиглалтад ортол мөдгүй юм байна. Гэтэл ерөөсөө эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчдийнхээ тоог ерөөсөө дийлэхээ болилоо гээд ганцхан эмнэлэгтэй уртаашаа. Тэгэхээр энэ дээр асуулт асууя. Дахиад энэ 2 салбарын 2 яам дээр Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээрх 25 оны төсөвт тусгагдсан тоног төхөөрөмжийн зардал нийт хэд байсан юм бэ? Сая хэд нь тодотголоор хасагдав? Яагаад гэвэл эрүүл мэндийн ялангуяа салбартай холбоотой асар чухал тоног төхөөрөмжүүд би сая эмнэлгийг нь ярилаа. Гэхдээ тоног төхөөрөмжүүд бас хасагдсан гэж яриад байгаа. Тэгэхээр хэд байж байгаад хэд болж хасагдсан юм болоо? Ер нь нийт энэ 2 салбар дахь 2 юу байх вэ энэ 2 яамтай холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчдын тоног төхөөрөмжийн зардлыг хэлээд өгөхгүй юу? Баярлалаа.

Л.Энхнасан: Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Нэгд 4 дүгээр эмнэлэгтэй холбоотой 2 ч удаа Эрүүл мэндийн яамнаас тендер зарласан боловч энд оролцсон байгууллага байхгүй. Оролцохгүй байгаа шалтгаан нь Хөгжлийн банк өөрөө ТУЗ дээр шийдвэр нь гараагүй, дээрээс нь үндэслэлгүйгээр 160 тэрбум гэсэн анхны дуудлага худалдаа хийсэн. Өөрийнх нь хүү болон зээл энэ бүх дүн нь 40 орчим тэрбум юм шиг байгаа юм. Тэгэхлээр та бод доо 40 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй барилгыг 160 тэрбумаар дуудлага худалдаанд орж байна шүү дээ Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар дээрээс. Энэ нь өөрөө ашиг сонирхлын асар их зөрчилтэй байгааг илэрхийлж байгаа тоо байна. 2 удаа дуудлага худалдаа хийсэн. Одоо 3 дахиа хийгээгүй гагцхисан сууж байгаа. Хавдар судлалын үндэсний төв энэ жилийн төсөвт 17 тэрбум суулгасан шүү дээ та бүхэн бас дэмжиж яагаад. Тэгэхлээр энэ төсөв нь байгаа байж байгаа.

Хоёр дахь зүйл тоног төхөөрөмжтэй холбоотой 6.8 тэрбум энэ 69.8-тай ороод цуцлагдчихсан. Байхгүй болчихсон ийм байдалтай байж байгаа.

Л.Энхнасан: Жавхлан сайд хариулна уу.

Б.Жавхлан: Гишүүний асуулт дээр нэмэлт мэдээлэл өгье. Тэр маш харамсалтайгаар эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж хасагдаж байгаа. Ноднин юу болж тавилаа? Тэгэхдээ тэр энэ буруу ойлголт яваад байна. Тодотголоор хасагдаж байгаа зүйл ерөөсөө огт биш шүү. Энэ чинь аль хэдийн Төрийн хэмнэлтийн хуулиар 5 сарын 31-нд нийтдээ 535 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнүүд хэмнэгдээд Засгийн газар ороод баталгаажгаад тогтоол нь гарчихсан. Энэ тодотголд огт хамаагүй тоо шүү.

Л.Энхнасан: Мөнхзул дарга 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Баярмаа гишүүний асуултад хариулъя Мөнхзул. Тус яаманд тоног төхөөрөмжид 15 тэрбум тусгагдсан. Татагдсан хөрөнгө 1.3 тэрбум. Бусад тендерийн үйл ажиллагаанууд бүрэн зарлагдсан. Татагдсан 2 багц дээр татагдсан. Нэгдүгээр шалтгаан нь болохоороо 3 удаа зарласан. Шаардлага хангасан оролцогч орж ирээгүй. 5 сарын 31-ний хугацаа болсон энд. Үүнтэй холбогдолтойгоор 551 сая төгрөг татагдсан.

Хоёр дахь нь болохоор 2 удаа зарласан. Эхний зарлалт дээр шаардлага хангасан гүйцэтгэгч орж ирээгүй. Энэ болохоор лабораторийн тоног төхөөрөмж байсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн. 2 дахь сонгон шалгаруулалт дээр нь 2 өрсөлдөгч орж ирсэн. 1 өрсөлдөгч нь гомдол гарснаар Сангийн яамнаас түдгэлзүүлээд шалгах хугацаа болсонтой холбогдолтойгоор 5 сарын 31 болсон. 1.3 тэрбум төгрөг татагдсан. 96 хувьтайгаар манайх худалдан авах ажиллагаа хийсэн. Бүх худалдан авах.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярмаа гишүүн тодруулна уу.

Ж.Баярмаа: Тодруулж асууя. Хавдар судлалын үндэсний барилга урт удаан түүхтэй явдаг энэ барилгын ажил сая юу гэсэн бэ? Ямар шалтгаанаар ерөөсөө юу ч хийгдэхгүй энэ дээрээс харахаар 10 тэрбум төгрөг тавьсан юм уу? 5 тэрбум гээд. Гүйцэтгэл “0” гээд.

Хоёрт тэнд ерөөсөө нөгөө хавдартай хүмүүс чинь бүр ерөөсөө орох байх газраа олж ядаад маш хүнд байгаа шүү дээ. Тэгэхээр ноднин тэр тодотгол ярих

үеэр тэр 40 тэрбумыг зөв гээд тавьчихсан юм уу, яагаад тавьчихсан юм? Энэ тэр тодорхой хэмжээний мөнгөн дүнгийн 40 тэрбумыг нь 25 онд санхүүжүүлнэ гэсэн байсан уу? Яагаад ноднин болгоё бүтээе гээд тодотголын үеэр энийг энэ төсөвт суулгачихсан юм бэ? Хэрвээ маш буруу тэр ашиг сонирхлын зөрчилтэй тийм ажиллагаа байсан юм бол яагаад ноднин энэ дотор оруулчихсан юм бол?

Л.Энхнасан: Чинбүрэн сайд хариулна уу. Бид нар нөгөө Байнгын хороогоороо энэ чинь нэлээн ажил болж байж оруулсан шүү дээ. Та бас өөрөө мэдэж байгаа. Тэгэхлээр энэ дээр маш сайн тодорхой хариулаад өгнө үү.

Ж.Чинбүрэн: Баярмаа гишүүн ээ энэ буруу гэж ерөөсөө яриагүй шүү дээ. Бид битүүмжлэгдсэн бодитой үнээр нь 4 дүгээр эмнэлгийг авах санхүүжилт тавьчихсан байгаа. Энэнээсээ ухраагүй байгаа. Тэгэхлээр бүх процедур өөрөө хууль ёсны дагуу явахгүй бол жишээлбэл Хөгжлийн банк өгөх хүсэлтэй боловч ТУЗ нь зөвшөөрөл гаргаагүй байна. Дээрээс нь 10 жилээр байгууллага түрээсэлчихсэн. Тэр түрээснийх нь асуудал маргаантай байж байна. Өнөөдөр надад авсан мэдээллээр Билэгт тэр эзэмшигч хүн нь өөрөө би энийг үнэгүй түрээслүүлнэ ээ Хавдар судлалынхан нь ороо гээд Хавдар судлалынхан нь нүүгээд орж байгаа ийм мэдээлэл байж байна. Бидэнд төсөвт тавьсан энэ жилдээ санхүүжүүлэх 17 тэрбум төгрөг нь байж байгаа. Жишээлбэл худалдаад авах юм бол энэ жилийн эхний төлбөр нь 17 тэрбум төгрөг хийхэд бэлэн байж байгаа. Миний хэлж байгаа зүйл бол хууль ёсны дагуу бодитой, үнэтэй л байвал энийг чинь авахад ерөөсөө татгалзаж байгаа зүйл байхгүй.

Л.Энхнасан: Тэгэхлээр үнэлгээ нь гараагүй байна гэсэн үг үү? Бид нар бол ноднин жил үнэлгээ нь гарчихсан гэж ойлгож байсан шүү дээ. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Жил жилд л Үндэсний аудитын газрын дүгнэлтүүд гүйцэтгэл дээр орж ирж байгаа. Ер нь бид нар бас нэг зүйлийг их сайн бодох хэрэгтэй болчихсон юм байна. Энэ Төрийн аудитын тухай хуульд бид нар нэлээн энэ төрийн аудитын байгууллагын эрх зүйн чадамжийг сайжруулах үг, үсгийг хийж өгөхгүй бол энэ алдаа, дутагдал ер нь засарч байгаа юм алга. Акт тавьсан л гэнэ, зөвлөмж гаргасан л гэнэ, дүгнэлт гаргалаа л гэнэ. Ингээд хуулийг нь аваад үзэхээр Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлээр 23.1-ээр төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ л гэсэн заалттай. Энэ нь өөрөө хүчгүй. Авч хэрэгжүүлж чадахгүй байдалд л очсоноос улбаатай. Өнөөдрийн энэ асуудлууд жил болгон гарч байгаа байхгүй юу. Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын илрүүлэлтээр улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар нийт 15.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь өмнөх оныхоос 7.5 тэрбум төгрөгөөр буюу 93.2 хувиар өссөн байгаа. Үүнээс санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил 2.9 тэрбум төгрөгөөр буюу 48 хувиар. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил 4.6 тэрбум төгрөгөөр буюу 229.9 хувиар өссөн байгаа юм. Жишээлбэл.

Дараагийнх нь Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит дээр санхүүгийн тайлангийн аудитаар нийт 149.5 тэрбум төгрөгийн 145 тэр зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож 141.2 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 0.8 тэрбум төгрөгийн зөрчил

гаргасан 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлж, 7.2 тэрбум төгрөгийн зөрчилд 57 зөвлөмж өгч, 0.1 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 2.2 их наяд төгрөгийн зөрчил илэрснээс 2.2 их наяд төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 22.1 тэрбум төгрөгийн зөрчилд 38 зөвлөмж хүргүүлсэн байгаа. Гэтэл дотоод аудитын үйл ажиллагааны хяналт дээр улсын секторын дотоод аудитын бүтэц, орон тоог 2024 оны байдлаар авч үзэхэд нийт 61 төсвийн ерөнхийлөн захирагчийн 54 нь дотоод аудитын нэгжтэй бөгөөд 546 албан хаагчтай хүнээс 314 нь дотоод аудит дээр ажиллаж байна гэж байгаа юм. Би 1 минутаа авчихъя дарга.

Л.Энхнасан: Нэмж 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Одоо тэгээд яах вэ? Ийм олон дотоод аудит байна. Үйл ажиллагаа дээр. Бүхэл бүтэн 564 албан хаагч ажиллаж байгаа юм. 61 төсвийн ерөнхийлөн захирагчаас 54 дотоод аудиттай байгаа. Аудитын нэгжтэй байгаа. Бид нар ийм их хэмжээний зөрчил, дутагдал жил болгон ярьж байна. Энэ нөгөө талдаа хулгай. Ний нуугүй хэлэхэд. Энэ дотор байгаа. Тэгэхээр энэ Төрийн аудитын тухай хуульд манай Улсын Их Хурлын гишүүд бас нухацтай хандаж, энэ төрийн аудитын байгууллагын эрх зүйн чадамжийг сайжруулж, жоохон хүчтэй болгохгүй бол өнөөдрийн гарч байгаа энэ зөрчил, дутагдал ирэх 20 жилийн хугацаанд ч гарна. Энэ маш тодорхой асуудал.

Энэ зөвлөмж шаардлага, албан шаардлага, акт тавьж байгаа юмны гүйцэтгэл нь ер нь хэдэн хувьтай байна вэ Үндэсний аудитын газар аа? Яагаад гүйцэтгэгдэхгүй, яагаад жил болгон энэ алдаа, дутагдал давтагдаад байна вэ гэдгийг хариулт авъя.

Л.Энхнасан: Наранчимэг дарга хариулах уу? 6 дугаар микрофон.

Ц.Наранчимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Монгол Улсын 2024 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өмнөх өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 57.2 хувийн хэрэгжилттэй байгаа. Төрийн аудитын тухай хуульд аудитын байгууллагаас гаргасан тайланг хүлээж аваад 30 хоногийн дотор алдаа, зөрчлөө хэрхэн яаж арилгах талаар төлөвлөгөө боловсруулж ирүүлэх үүрэгтэй байгаа. Хэрвээ төлөвлөгөөгөө ирүүлээгүй бол хариуцлага тооцох ийм хуулийн санкцтай байгаа.

Алдаа, зөрчил жил болгон гараад байгаа асуудал нь аудитын байгууллагаас өгч байгаа энэ алдаа зөрчлийг арилгах энэ төлөвлөгөөгөө боловсруулахдаа хариуцлагатай хандахгүй. Энийг хэрхэн, яаж шийдвэрлэх талаар ялангуяа төсөв захирагч нар тодорхой арга хэмжээ авахгүй. Төрийн аудитын байгууллагаас гаргаж байгаа энэ тайлангуудтай танилцахгүй, зөвхөн санхүүгийн ажилтны үүрэг мэт ойлгоод байгаа гэж аудитын байгууллагаас дүгнэж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварын асуудал байгаа. Төсөв захирагч нарын гаргаж байгаа шийдвэрийн хуулийн гаргаж байгаа шийдвэрүүд бас үнэн, зөв байх ёстой гэсэн ийм асуудлуудаас болж энэ алдаа зөрчил жил болгон нэмэгдээд байгаа. Бид нар энэ аудитын байгууллагаас өгч байгаа ялангуяа энэ санхүүгийн тайланг баталгаажуулж байгаа гол асуудал дээр авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гэсэн ийм асуудал дээр дүгнэлтүүдийн үндэслэлд орж өгдөг. Тэгэхээр энэ дээр ямар асуудал

байна вэ гэхээр эдгээрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх энэ асуудал дээр удаашралтай буюу хойрго хандаж байгаа ийм асуудлууд байгаад байгаа.

Бид нар энэ асуудлыг барагдахгүй байгаа дээр зөвлөмжөө хэрэгжүүлэхийн тулд, албан шаардлагаа биелүүлэхийн тулд бид нар өгч байгаа энэ албан шаардлагаа сүүлийн үед дандаа хувьчилж өгдөг болсон. Монгол Улсын хэмжээнд нийт 6.8 их наяд төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа. Та бүхэнд энэ тараасан тайлан дээр байгаа бид нарын баталгаажуулсан тоон дээр. Энэ авлага, өглөгийг барагдуулахын тулд энэ жил та нар 20 хувийг нь ядаж барагдуулчихаач ээ. Сүүлдээ 30 хувийг нь барагдуулчихаач ээ гээд. Яагаад гэвэл манай Төрийн аудитын тухай хуульд байгаа зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бол албан шаардлагыг өгнө. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцно гэсэн ийм хуулийн санкцтай байгаад байгаа. Тэгэхээр зарим нь бас тухайн төсөв захирагчаас шалтгаалахгүйгээр бодлогын хэмжээний асуудлууд байгаад байгаа учраас бид нар эдгээр шийдлүүд дээрээ хэрэг хэрэгжүүлэхийн тулд авлага, өглөг дээр хувь зааж өгч байгаа. Энэ жилдээ та нар энийг ийм хувийг барагдуулчихад бас боломж байгаад байна аа гэдгийг судалж байгаад өгч байгаа.

Дараагийн нэг асуудал нь.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу Наранчимэг дарга 6 дугаар микрофон.

Ц.Наранчимэг: Тайлан дээр алдаа, зөрчил хоёроо салгаж тайлагнаж байгаа. Бид нар төсөвт захирагч нарын гаргаад ирж байгаа 6832 байгууллагад аудит хийж байгаа. Энэ манай байгууллагын хувьд маш ажлын ачаалалтай ингэж ажилладаг. Тэгэхээр энэ тайланг нь буруу гаргаад ирж байгаа тайланг нь төрийн аудитын байгууллага зөв болгож баталгаажуулах үүрэгтэй. Энэ гаргаж байгаа тайлангууд дээр байгаа тоон мэдээллийг Улсын Их Хурал, хэвлэл мэдээллийнхэн бусад хэрэглэгч нар тоон мэдээллийг үнэн, зөв гэдгийг аудит баталгаажуулж энэ тоон дээр ажиллаж шийдвэр гаргахад энэ тоог барьж шийдвэрээ гаргахад боломжтой юм аа гэсэн. Ингэж баталгаажуулж өгч байгаа.

Тийм учраас энэ гараад байгаа алдаанууд дээр яг тэр санхүүгийн тайланг гаргаад ирүүлж байгаа ажилтнуудын ур чадварын асуудлууд бас байгаад байгаа. Энэ дээр бид нар бас тодорхой асуудлууд дээр төрийн аудитын байгууллага судалгаа хийж өгч байгаа, үзэж байгаа. Сургалтын чанар нь ямар байгаад байгаа юм. Яг энэ санхүүгийн ажилтныг бэлтгэж байгаа сургалтын чанар ямар байгаад байна. Тэнд ажиллаж байгаа хүн.../минут дуусав./

Л.Энхнасан: Бат-Эрдэнэ гишүүн тодруулга хийнэ.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр дарга аа ийм шүү дээ, наадхыг чинь 20, 30 жил л ярьж байгаа юм. Та бүх төрийн байгууллагууд дээрх томилгоо яаж явагдаж байгааг мэдэж байгаа шүү дээ. Бид нар энийгээ яриад байвал дахиад 20, 30 жил ярина. Төрийн аудитын үндсэн зорилт дээр би танд уншаад өгье төрийн аудитын үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль, ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ ээ гэж байгаа юм. Эдийн засгийн тогтвортой хөгжил. Эдийн засгийн тогтвортой хөгжил чинь алдагдчихаад байна та бүхний дүгнэлтээр.

Гүйцэтгэл дээр та нар харахаар 57.2 хувьтай байна. Энэ чинь маш бага хувь байхгүй юу даа. Маш бага хувь. Тэгэхээр энэ эрх зүйн орчин харилцаатай холбоотойгоос авхуулаад та бүхнийг давхар ажил хийгээч ээ л гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Л.Энхнасан: Санал байна тээ? Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: 1 дүгээр асуулт нь Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв, БНСУ дахь Нийгмийн даатгалын алба гэж 2 байгууллага байж байгаад 25 он дээр ямар ч зардал нь больсон байна. Тэгэхээр энэ байгууллагууд татан буугдсан гэсэн үг үү? Энэ дээр тодруулга тайлбар өгөөч.

Хоёр дахь асуулт нь энэ зардлын нийгмийн энэ 5 дугаар хуудсан дээр байна л даа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт гэж байгаа юм. 2.7, ерөнхийдөө 2.7, 2.6 тэрбумын зардалтай байгууллага байна. Дахиад доошоогоо явахлаар дахиад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан дахиад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт гэж байгаа юм. Яг 2 адилхан агуулгатай ийм байгууллага байхгүй юу. Тэр нь болохлоор зардал нь 25 оных болохоор 3.1 тэрбумын орчмын зардалтай байна. Энэ хоёрын хооронд яг эд нар ямар ялгаатай юм? Ийм том бүтэц байгууллага байдаг юм уу? Би энийг бас харж байна. Тэгвэл яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн энэ нийгмийн даатгал, нийгмийн халамж, хамгааллын судалгаанууд дээр дандаа тоо баримтгүй, эсвэл ийм анализгүй юмнууд яваад байдгийг ерөөсөө ойлгосонгүй. Судалгааны бүтэцтэй юм бол?

Дараагийнх нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд энэ 48 тэрбумын, 58-аас 48 тэрбум болж буурсан энэ том байгууллага байна. Энэ нь дахиад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан гээд дахиад яваад байх юм эд нар ингээд. Тэгэхээр энэ зардал нь өснө гэдэг чинь ажилд орж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа гэсэн үг үү? Ач холбогдлыг нь би бас ойлгох гээд байна л даа. Тэгэхээр зардал өсөхөөр миний ойлгох ухаанаар ажилд орж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэх ёстой, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд нь аль аль нь өсдөг юм бол? Энэ зардал нь яаж тооцогддог вэ? Ямар ямар үзүүлэлтүүдээр энэ зардал нэмэгдэж, хасагддаг вэ гэдэг дээр би нарийвчлан мэдээлэл авъя. Түрүүний энэ 2 адилхан нэртэй судалгаа, сургалтын институтийн талаар бас юугаараа ялгаатай юм гэдгийг нь бас тодруулаад өгөөч. Дараа нь тодруулъя.

Л.Энхнасан: 3 дугаар микрофон.

Ж.Энхтөр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. БНСУ болон. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхтөр байна. Саранчулуун гишүүний эхний асуултад хариулъя.

Манай яамны харьяа Солонгос болон Япон улсад Хөдөлмөр, халамж, үйлчилгээний алба ажилладаг байсан. Өнгөрсөн оны төсвийн тодотголоор Япон улсад Хөдөлмөр, халамж үйлчилгээний алба татан буугдаж, 2 яамны хооронд тохиролцсоны дагуу Гадаад харилцааны яаманд ажиллаж байсан 3 хүн нь шилжиж ажилласан байгаа. Хөдөлмөр, судалгааны институтийн гэж байгууллага манай яамны харьяанд ажилладаг. Тэр байгууллагын урсгал зардал нь 2.6 тэрбумын төсөвтэй ажиллаж байгаа. Үүнээс гадна Хөдөлмөр эрхлэлт дэмжих сан

маань нийтдээ 34 санд, дэд санд хуваагдаж ажиллаж байгаа. Үүний 1 дэд сан нь Хөдөлмөр, судалгааны институтийн хажууд ажиллаж, Хөдөлмөрийн судалгааны институт бусад төрлийн ажиллагааг явуулж байгаа энэ зардлаасаа.

Хөдөлмөр эрхлэлт дэмжих сангийн зардлыг Энхболд дарга бас дэлгэрэнгүй хариулчих уу.

Л.Энхнасан: Энхболд дарга 5 дугаар микрофон Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

3.Энхболд: Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга Энхболд. Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой 57 тэрбум төгрөг гэж яригдаж байгаа. Энэ бол нийтдээ 9 дүүрэг, 21 аймаг, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны зардал байгаа. Энэ бол урсгал зардал. Үүнтэй холбогдуулаад үүн дээр бол Солонгос Улсад байгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв бас санхүүжилтэд нь давхар орж явдаг. Мөн үүн дээр нэмэх нь бол улсын хэмжээний нийтдээ 11 асрамжийн газрууд байгаа. Ахмад настны асрамжийн үйлчилгээний газрууд. Эдгээр байгууллагуудтай холбоотой зардлуудыг энэ төсөв дотор орж явдаг.

Нөгөө төсөв нь бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв. Энэ бол Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар өөрийн үйл ажиллагааныхаа орлогоор бүрдүүлдэг. 2025 онд бол 130 тэрбум төгрөг зарцуулахаар ажиллаж байна.

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. Аубакир сайд сая орж ирлээ. Сайд Саранчулууны асуусан асуултад, эс үгүй бол Мөнхзул дарга хариулах уу?

Л.Мөнхзул: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны институт хуучин нэрээр. Энэ байгууллага болохоор судалгааны ажил явуулдаг. 3.1 тэрбум нь болохоор үйл ажиллагааны урсгал зардал. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас мөн санхүүжилт авч тодорхой хэмжээний судалгаанууд хийгддэг. Мөн Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр ур чадвар олгох бас тэр ажлыг гүйцэтгэсэн. Энэтэй холбогдолтойгоор дэмжих сангийн хөрөнгө нь тусад нь ингэж тусгагдсан байгаад байгаа юм нөгөө Тусгай сангийн тухай хуулиараа. Энэ болохоор хөтөлбөр, арга хэмжээний зардал гэсэн үг. Тэгэхээр 1 энэ байгууллага дээр 2, 1 нь урсгал үйл ажиллагааны зардлын эх үүсвэр, нөгөөдөх нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан зардал гэсэн үг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан зардлын хэмжээ яагаад өсөн нэмэгдэж байгаа вэ, энэ дээр тодорхой хэмжээний тариф байдаг уу гэж Саранчулуун гишүүн асуусан. Тариф бол байдаг. Нэг сургалтад хамрагдаж ахуй эрхлэлтийн болон бусад төрлийн сургалтад хамрагдахад тариф хэрэгждэг. Мөн хамрах хүрээгээрээ нийт хамрагдах хүн.../минут дуусав./

Л.Энхнасан: Үүрийнтуяа гишүүн асуултаа асууна.

Д.Үүрийнтуяа: Оройн мэнд хүргэе. Үндэсний аудитын газраас 1 асуулт байна. Санхүүгийн тайлангийн аудитаар бид нар 3 төрлийн дүгнэлт өгч байгаа тийм ээ? Зөрчилтэй, хязгаарлалттай, зөрчилгүй гээд. Төрийн аудитын тухай хуульд 2020 онд хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр хязгаарлалттай дүгнэлтэд

хариуцлага тооцдог байсныг болиулсан. Өнөөдөр манай төрийн албан хаагчдын дунд ч тэр, ард иргэдийн дунд ч тэр ялангуяа төрийн өндөр албан тушаалтнуудын дунд аудитын дүгнэлтийн энэ нэршил, томъёолол, түүний үр дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ойлголтын зөрүүнүүд нэлээдгүй яваад байна.

Тэгэхээр энэ талаар Үндэсний Аудитын газрын зүгээс тодорхой тайлбар хэлээд өгөөч. Аудитын бас олон улсын стандарт гэж нэг юм байдаг шүү дээ. Тухайн үйл ажиллагааны хамрах хүрээнд шалгах боломжгүй, эсвэл шалгах нөхцөл бүрдээгүй байх юм бол тэр хүрээгээр хүртэл хязгаарладаг. Тэр нь өөрөө мөнгө төгрөг идээд дуудсан гэсэн асуудал байх юм уу? Энэ тал дээр бас тодорхой мэргэжлийн үүднээс тодорхой ойлголт өгөөч ээ гэдэг ийм асуулт, хүсэлт байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны гүйцэтгэл орж ирэхэд энэ барилга байгууламж, тоног төхөөрөмж дээр нийтдээ 171 ажил жагсаагдсан байна. Энэний 29 нь үндсэндээ гүйцэтгэл нь “0” огт гүйцэтгэл гараагүй ээ гэсэн үг. Энэ 29-ийн ажлын 10 нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 19 нь Эрүүл мэндийн яамных байна л даа. Бид нар чинь яаж энийг чинь оруулах гэж өнгөрсөн жил чинь төсөв, хуруу хумсаа хуйхалж тавих гэж бөөн юм болж, зарчмын зөрүүтэй санал энэ тэр гаргаад л Зоонозын үндэсний төв гээд л лав би энэ дээр яригдаж байсан 2 асуудал 2-уулаа энд явж байна. Огт гүйцэтгэл байхгүй “0” гээд. Яагаад ийм байгаа юм бэ? Хийх боломжгүй ажлыг төлөвлөөд байна уу, эсвэл төлөвлөлтийн явцад, гүйцэтгэлийн явцад төлөвлөлттэй холбоотой, хэрэгжүүлэлттэй холбоотой ямар нэгэн асуудлууд үүсэв үү? Яагаад 2 яаман дээр ийм өндөр дүнгээр гарч ирж байгаа юм бэ гэдэг энэ 2 асуултад хариулт авъя.

Л.Энхнасан: Аудитын газраас Наранчимэг дарга 6 дугаар микрофон.

Ц.Наранчимэг: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын байгууллагууд бүгд Энтаса буюу АСА-гийн гишүүн ийм байгууллагууд байдаг. Энэ байгууллагууд аудитын дээд байгууллагын олон улсын стандартыг мөрддөг. Энэ стандартынхаа дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор заавар, журмаа гаргаад аудитор өөрөө хараат бусаар аудиторуудын ёс зүйг эрхэмлэж дүгнэлтээ өгдөг байгаа. Аудит хийсэн аудиторууд.

Бид нар аудитыг хийхдээ хязгаарлалттай санал, дүгнэлтийг та сая хэллээ 2020 оны Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон энэ хуулиар хязгаарлалттай санал, дүгнэлт авсан бол хариуцлага тооцдог энэ асуудлыг хуулиас болиулсан. Яагаад гэвэл энэ өөрөө стандартаараа Монгол Улс хариуцлага тооцдог байсныг олон улсын стандартын дагуу энэ арга хэмжээг авч хуулиас энийг хассан байгаа.

Хязгаарлалттай санал, дүгнэлтийг ямар тохиолдолд өгдөг юм бэ гэхээр аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авч буй аудитор нь тухайн буруу илэрхийллүүд нь дангаараа, эсвэл нийтээрээ санхүүгийн тайлангуудад материаллаг боловч өргөн тархаагүй гэж ингэж үзэх юм бол хязгаарлалттай гэсэн ийм санал, дүгнэлтийг өгдөг. 4 дүгнэлтийн маань хуулиар сөрөг дүгнэлт авсан бол хариуцлага тооцох санал, дүгнэлтийг, албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлж байгаа. Аудит хийхээс татгалзсан бол ажлаас халах гэсэн ийм албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлдэг ийм стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа.

Ер нь хязгаарлалттай санал, дүгнэлтийг аудитын олон улсын стандарт 705-ын дагуу дүгнэлтүүдээ өгөөд явдаг. Энэ хараат бус дүгнэлт байдаг. Санхүүгийн тайлангийн аудитыг 4 тайлангаа баталгаажуулж байгаа ийм аудит байгаа. Санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй гэж үзсэн буюу бодлогын асуудлын аудитыг гүйцэтгэлийн аудитаар бид нар бас аудит хийж, бодлогын чиглэлийн арвилан хэмнэлт ийм асуудлуудыг, үр өгөөжийн асуудлуудыг нь гүйцэтгэлийн аудитаар үзэж байгаа. Мөн хууль тогтоомжид нийцсэн хэсэг асуудлыг нийцлийн аудит хийж аудит хийдэг. Ийм 3 төрлийн аудитыг төрийн аудитын байгууллага хийж гүйцэтгэж, тайланг холбогдох Байнгын хороод нь хүргүүлж ажиллаж байна.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сайд Чинбүрэн хариулна.

Ж.Чинбүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Бид үйл ажиллагааны зардлаас бас нэлээдгүй хэмжээний санхүүжилт хасагдсан байгаа 33 тэрбум төгрөг. Энэ дотор нийгмийн эрүүл мэндийн тусламжтай холбоотой нэлээдгүй ажлууд, тэр дотроо халдварт өвчний тандалт, судалгаа, хэрвээ халдварт өвчин гарах юм бол эмийн нөөц, хангамж ямар байх вэ, мөн цахим шилжилттэй холбоотой лабораторийн шинжилгээ, шинэчлэлд, эмнэл зүйн эмийн салбарын шинэчлэл, цахим хөтөлбөр энэ тэр гэсэн нэлээдгүй олон. Тухайлах юм бол орчны эрүүл мэнд дээр гэхэд л 1.2 тэрбум ч гэсэн хасуулчихсан байх жишээний гээд л яривал их ч олон зүйлүүд байна. Энэ болгоныг нөгөө Хэмнэлтийн хуулиараа хасагдсан буцаагаад тавих боломжгүй ч гэсэн бид бас дараа дараагийн санхүүжилт энэ тодотголын дараагаар энэ дутагдаж бай.../минут дуусав./

Л.Энхнасан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Аубакир. 3 дугаар тодруулах юм уу? Түрүүнийхээ 2 сайдаас асуусан асуултаа. Тодруулга Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Буруу ойлголт л явчих шиг болох юм. Бид нар чинь 24 оны гүйцэтгэл хэлэлцээд байгаа шүү дээ. Тийм 25 оны төсвийн тодотгол биш л дээ. Би 24 оны гүйцэтгэл дээр барилга байгууламжийн, тоног төхөөрөмжийн худалдан авалтын өөрөөр хэлбэл ажлын гүйцэтгэл 171 объект бид нар барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдаж авна гээд хөрөнгө оруулалтын ажил төлөвлөснөөсөө 29 нь огт гүйцэтгэлгүй "0" байна. Үүний 10 нь Эрүүл мэндийн яамных байна, биш ээ 10 нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамных байна, 19 нь Эрүүл мэндийн яамных байна. Энэ яагаад "0" гүйцэтгэлтэй өнгөрсөн жилийн гүйцэтгэл гарчхав л гэдгийг асуугаад байгаа юм.

Л.Энхнасан: 3 дугаар микрофон Энхтөр дарга.

Ж.Энхтөр: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн онд хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр нийт 48.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн хөрөнгө санхүүжих дүн нь батлагдаад 35.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, 72.4 хувьтай дууссан байна. 10 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн санхүүгийн жилд санхүүжүүлж амжаагүй байна. Энд бол барилга шилжиж байгаа болон он дамжсан 4 барилга, 6 тоног төхөөрөмжийн ажил тухайн үед ондоо гүйцэтгэлээ санхүүжүүлж чадаагүй байна.

Энэ 25 оны хувьд нийтдээ, 25 оны хувьд нийтдээ 29 төсөл, арга хэмжээ батлагдсан учраас 25 нь сая 5 сарын 31-ний өмнө гэрээгээ бүрэн байгуулж дууссан байгаа. 24 оны хувьд ийм байдалтай 10 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гаргаж чадалгүй дууссан байна.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн яамнаас Мөнхсүх дарга 1 дүгээр микрофон хариулна уу.

Э.Мөнхсүх: Эрүүл мэндийн яам Мөнхсүх. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 2024 онд бид бас төсөл, арга хэмжээнүүдээс тендер шалгаруулж гэрээ байгуулж чадаагүй 2 төсөл, арга хэмжээ, бусад нь тоног төхөөрөмжийн ажлууд бас гэрээ байгуулж чадаагүй, гүйцэтгэл гараагүй байна.

Л.Энхнасан: Тодруул, Аубакир сайд хариулна уу.

Т.Аубакир: Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй холбоотой ерөнхийдөө шинэ цаглавар руу шилжээд 5 сарын 31-нээр үндсэндээ сонгон шалгаруулалт нь зарлагдаад, тендер юм нь зарлагдаад, гэрээ контракт нь хийгээгүй бол автомат татах хуулийг Хэмнэлтийн хуулийн 13.1.1 дээр хийгээ өгчихсөн байгаа.

Үүнтэй холбоотой ер нь салбар болгон дээр зөвхөн яам яамд, Эрүүл мэндийн яам гэдэг ч юм уу манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэхээсээ илүү улсын хэмжээнд татагдсан зүйлүүд байгаад байгаа юм Үүрийнтуяа гишүүн ээ. Энэ өнгөрсөн 24 оны 124 дүгээр Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг гараад ажиллаад явж байгаа. Ер нь энэ манай энэ төсвийн цаглаврууд зөв явж байгаа юм уу? Улирлын чанартай бүтээн байгуулалтууд хийгддэг учраас зам, барилгын ажлаа бид нар хэдийд зарлах ёстой юм, тоног төхөөрөмж дээр бид нар яг 5 сарын 31-нээр тасалбар болгох нь ер нь хэр зохимжтой юм бэ гэдэг асуудлууд бас яриад явж байгаа. Энэ хуулийн хүрээнд улсын хэмжээнд нэлээн төсвүүд буцаад татагдчихаад байгаа юм. Бид нар энэ ажлын хэсэг дээр бас цаглавруудаа бас харах юмнууд бас бай.../минут дуусав./

Л.Энхнасан: Үүрийнтуяа гишүүн тодотгол хийнэ үү.

Д.Үүрийнтуяа: Үгүй ээ яамны дарга нар аа энэ эсвэл бид нарт өөр материал тарааж өгчхөөд байгаа юм уу? Ажлынх нь нэр нэрээр заагаад өгчихсөн материалаас хараад асуугаад байгаа шүү дээ. Эрүүл мэндийн яам жишээлэх юм бол 19 ажил дутуу байна гэхээр 2 нь, 2 л ажил байгаа юм 2 нь л, бусад нь бүгдээрээ тоног төхөөрөмж гээд байх юм. 2 нь барилга гээд. Гэтэл тэр чинь 2 нь тоног төхөөрөмж худалдан авалт, бусад нь дандаа барилгын ажил байна шүү дээ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 4 нь барилгын ажил гээд байх юм. Энэ чинь 8 барилгын ажил байна шүү дээ. 2 нь л тоног төхөөрөмж байна шүү дээ. “0” гүйцэтгэл гэдэг чинь ерөөсөө юу ч хийгээгүй байгаа байхгүй юу. Хийхгүй юм бол төлөвлөж яах юм бэ? Баахан ахмадын байрнууд байна, гэр бүлийн төвийн барилгууд байна. Эрүүл мэндийн яаман дээр Зоонозын үндэсний төвийн барилгууд байна, ЭМТ-ийн барилгууд байна. Өвөрхангай, Хайрхандулаан, Бат-Өлзий энэ тэр гээд барилгууд байна. Энэ яагаад зөрүүтэй юм яриад байна?

Л.Энхнасан: Энэ гишүүд тараасан материал байгаа. Энийг бүүр тод яг гишүүний асууж байгаа энэ жагсаалтын дагуу яагаад “0” биелэлттэй байна? Мөнхзул дарга хариулах уу? 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя Мөнхзул байна. Шилжих хөрөнгө оруулалтаас 1 хөрөнгө оруулалт 24 онд гүйцэтгэлээ гаргаж чадаагүй байна. Энэ Найрамдал зуслангийн хажууд баригдаж байгаа усан спорт цогцолборын барилгаас 700 сая төгрөг тусгагдсан боловч гүйцэтгэл нь гараагүй.

Яагаад вэ гэхээр барилгын зураг, төсвийг зохиогч нь бол зураг, төсвөөсөө татгалзсан, гүйцэтгэгч нь зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүй гээд энэ барилга олон жилийн хугацаанд ингэж явж байгаа нэлээд ийм салбарын хэмжээнд төвөгтэй барилга байгаа.

Мөн Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр 250 ортой Өмнөговь аймгийн Даланзадгад сумд 500 сая төгрөг тусгагдсан боловч энэ зураг, төсөв байхгүй гэдэг шалтгаанаар. Энэ хэд хэдэн барилга байгууламжууд баригдаагүй шалтгаан нь ихэвчлэн 24 онд шинээр төсөвт тусгагдсан барилгын зураг, төсөвгүй, тендер зарлаад оролцогч ороогүй, шаардлага хангасан оролцогч ороогүй гэх мэт ийм шалтгааны улмаас 10 төсөл, арга хэмжээ.../минут дуусав./

Л.Энхнасан: Эрүүл мэндийн яамнаас Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Ер нь энэ гүйцэтгэлтэй холбоотой зөв төлөвлөлт, магадлан итгэмжлэгдсэн зураг, төсөвтэй байж аливаа төслүүд орж ирэхгүй дураараа дураараа баахан төсвүүд ороод ирдэг, ажлууд ороод ирдэг. Тэр нь хэрэгжих боломж байхгүй. Тухайлах юм бол дулааны эх үүсвэр, цахилгааны эх үүсвэрээс авхуулаад л. Тийм учраас ер нь бид бас энэ төсөв батлахдаа бас энийг бас анзаарч, нөгөө Сангийн яамны тавьж байгаа шаардлагын дагуу асуудлууд нь яг шаардлага хангаж байна уу энэ тэр гэдэг дээр бас нэлээдгүй хяналт тавьж байхгүй бол ингээд тодотгоод оруулж ирэнгүүтээ л баахан төсөв тавьчхаад тэр нь биелэхгүй. Дараа нь биелэхгүй ажлууд нь тухайн салбарын үйл ажиллагаа доош нь татдаг явдлууд ер нь жил болгон л ажиглагдаад байгаа. Тийм учраас бид 26 оны төсөв хийхдээ бас энэ дээрээ хатуу чанга Эрүүл мэндийн яам ч гэсэн өөрсдөө анхаарч, нэмэлтээр орж ирж байгаа хөтөлбөрүүд дээр, төслүүд дээр Сангийн яамны тавьж байгаа шаардлагын дагуу тэр шаардлагуудыг нэлээн тийм чанга тавиад.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа Бейсен гишүүний нэрийг нэмээд өг. Түрүүн төхөөрөмж нь ажиллаагүй байна. Асуулт асууна. Бейсен гишүүн асуултаа асууна уу.

Б.Бейсен: Энэ 24 оны төсвийн гүйцэтгэл дээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа хотын клиникийн эмнэлгүүд байж байна том том, нөгөө дүүргийн эмнэлэг, аймгийн эмнэлэг дээр ер нь хэчнээн тэрбум төгрөгийн өр гарсан юм Эрүүл мэндийн яамныхан? Одоо тэр өр дамжаад энэ жил 25 онд бас ирээд байна. Одоогийн байдлаар зарим эмнэлгүүд бас нэлээн өртэй, эмнэлгийн тусламж салгардсан тийм байдалтай байж байна.

Жишээлбэл, Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг нийт 2.3 тэрбумын өртэй, нийгмийн даатгалд 681 сая, татвар 327 сая, эмийн өр тэрбум 600 сая, тээвэр шатахуун 13.3 сая, хог хаягдалд 23.5 сая Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага нь 3.3 тэрбум юм байна. Тэд нар ер нь санхүүжилт ирэхгүй байна, бид нар цалин 1 тэрбум 200 сая төгрөгийн урьдчилгаа өгөөд бусад нь орохгүй байна гээд тэгж ярьж байна. Энэ талаар тодотгоё, ер нь улсын хэмжээнд жилийн эцсээр хэчнээн сая төгрөгийн өр гарсан юм? Тэр талаар мэдээлэл авъя.

Дараа нь энэ 24 оны батлагдсан төсвийн тоног төхөөрөмж дээр 21.3.21-д Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж гэж байна. Нийтдээ 870 сая, энэнээс 788 саяын гүйцэтгэлтэй байна даа. 91 хувьтай гэж байна. Энэ дээр аудит хийж үзсэн үү Аудитын газар? Ямар учиртай, ямар тоног

төхөөрөмж авсан юм? Ер нь эмнэлгүүдээр очиход энэ тийм юм харагдахаар тоног төхөөрөмж харагдахгүй л байгаа юм. Энэ талын мэдээллийг авъя.

Нөгөө талаар энэ аймгийн төвийн оношилгооны төв баригдсан. Энэ дээр цалингийн зөрүү гээд 3 тэрбум 700-гаад сая төгрөг байж байгаа. Сангийн яамныхнаас асууя энэ бас 2, 3 удаа эмнэлгийн барилгын магадлан хийлгээд аудитаар орсон юм байна. Энийг өгөх боломж байхгүй юу? Энэ барилга чинь дахиад 26 он хүртэл явах гээд байна шүү дээ энэ чинь ашиглалтад өгөхгүй. Алслагдсан аймаг байдал нь хүнд байна. Энэ 3 дээр мэдээллээ аваад дараа нь тодруулъя.

Л.Энхнасан: Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой өр, авлагын асуудалтай холбоотой бол ямар нөөц нэгэнт мэдэж байгаа бид бөөн өртэй, эмийн компаниа бөөн авлагатай, цалингаа тавих байдал бүр хүндэрчихсэн. Одоо бидэнд ямар нөөц, боломж байна вэ гэхлээр жишээлэх юм бол “Чингис хаан” банкнаас 30 гаруй тэрбум төгрөг мөнгөн дүнгээр авах боломж байна. “Капитал” банкнаас авах мөнгөн дүнгээр авах 40 гаруй орчим тэрбум, дээрээс нь үл хөдлөх хөрөнгө 70 орчим тэрбум төгрөг. Одоо энэ дээрээ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар ажлын хэсэг гаргаад энэ өр барагдуулах чиглэл дээрээ өөрсдөө бүр бүх боломжоо дайчлаад энийгээ авах чиглэлд Эрүүл мэндийн яам хамтраад бид энийгээ хөөцөлдөнө.

Нөгөө боломж Нийгмийн даатгалын сантай 89 тэрбум төгрөгийн бас авлага, өглөгийн тохирсон тоо байгаа. Энийгээ авах юм бол бас өр шир овоо барагдах ийм боломжууд байгаа. Тийм учраас одоо байгаа боломжуудаа бид тултал нь ашиглая. Дээрээс нь мэдээж байгаа мөнгийг зөв зарцуулах, энэ мөнгийг илүү үйл ажиллагааны бас бүтээмжийг сайжруулж, давхцалгүй, хийдэлгүй байхаар зохицуулах ийм арга хэмжээнүүдийг энэ богино хугацаанд авч, ямар ч байсан он дамнасан энэ өрнүүдийг өр нь жигдлэхгүй бол энэ бас болохгүй байгааг бас энд хэлье.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс 7 дугаар микрофон. Сангийн яам тээ?

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Тэгэхээр 25 оны төсөв дээр бид нар төслүүд, хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой төсөвт өртгийн нэмэгдэл, нэмэлт санхүүжилт, тариф, цалингийн өсөлтийг тусгаагүй. 25 оны төсөв дагаад Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолууд гарсан. Энэ тогтоолуудтай холбоотой өртгийн нэмэгдлийг Үндэсний аудитын газар хянах ийм чиглэлийг өгсөн байгаа.

Одоогоор Сангийн яаман дээр Барилга, хот байгуулалтын яамнаас хөрөнгө оруулалтын ажлуудаар нэмэлт санхүүжилтээс гадна барилгын ажилтны тариф цалинтай холбоотой 36 тэрбумын хүсэлт ирсэн. Энийг бид нар Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Үндэсний аудитын газар бол тариф цалинг хянахгүй гэдэг ийм хариу ирүүлсэн. Үүнийг нь бид нар буцаагаад Барилга, хот байгуулалтын яаман дээр хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах ийм санал өгсөн байгаа. Ялангуяа Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгатай холбоотой анх 8.7 тэрбумаар эхлээд 23 тэрбум болчихсон үүн дээрээ.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 7 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Цалингийн тарифын өсөлт 3 тэрбумыг магадлалаар хянуулаад ирчихсэн байгаа. Манай Сангийн яамны хувьд энийг нэлээн өндөр эрсдэлтэй, өмнө нь нэлээн олон удаа нэмэгдчихсэн байгаа учраас дахин нягтлах шаардлагатай гэдэг үүднээс Барилга, хот байгуулалтын яаман дээр магадлал дээр ахиад хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулж ирүүлээч ээ гэдэг ийм саналыг хүргүүлчихсэн байгаа.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сантай холбоотой Энхболд дарга нэмж хариулах уу? 2 дугаар микрофон.

С.Энхболд: Бейсен гишүүний асуултад хариулъя. 24 оны даатгалын сангийн нийт өглөг 420 орчим тэрбум байсан. Үүнээс 316-г 25 оны төсвөөс төлж барагдуулсан байгаа. 110 орчим тэрбумыг Азийн хөгжлийн банкны Апакс хөтөлбөрөөс 70 тэрбумыг, сайдын багцаас 35 тэрбум төгрөгийн өр, авлагыг барагдуулсан. Ингээд 316 тэрбумыг энэ оны төсвөөс барагдуулах үйл ажиллагааг эхний улиралдаа багтаагаад хийсэн. Одоогийн байдлаар өмнөх оны өглөгүүд ямар ч эрүүл мэндийн байгууллага дээр өр, авлага үүссэн юм байхгүй. Энэ оны саяын та Баян-Өлгий аймгийн 3.2 тэрбум төгрөгийн авлагатай гэж байна. Энэ 4 сар, 5 сард үүссэн өр, авлагууд явж байгаа. Энэ хойшоо шилжээд явж байгаа. Энэ дээр зохицуулалтуудыг хийж байгаа гэсэн үг.

Л.Энхнасан: Бейсен гишүүн тодруулга хийнэ үү.

Б.Бейсен: Эрүүл мэндийн яамны хяналт шалгалтын хэлтсээс хүн байна уу, санхүүгийн байгууллагаас? Тэгэхээр ийм байна л даа та нар Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс байна уу? Дарга нь яасан юм бол энэ? Гадаадын эмчлүүлэгчдийн юуг чинь Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр зуучилж байгаа асуудал гарч байна. Энэ нь ямар учиртай юм? Бид нар чинь 10 тэрбум төгрөг тусгаад өгсөн гадаадын эмчлүүлэхэд. Энэ талаар аудит хийсэн юм уу Аудитын газрынхан нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ та нар энэ төсөв хүрэхгүй байгаа асуудал жилийн эцсээр Эрүүл мэндийн яам хяналт шалгалт муу хийсэн. Эрүүл мэндийн даатгалын газрыг хүнд байдалд оруулаад ерөөсөө. Тэгээд орон тоог нь нэмээд батлаад өгчихсөн. 24 оны орон тоог бүүр 119 хүнээр нэмэгдүүлчихсэн байгаа юм даа. Энэ ямар учиртай юм?

Л.Энхнасан: Эрүүл мэндийн яамнаас Мөнхсүх дарга хариулах уу? 1 дүгээр микрофон.

Э.Мөнхсүх: Бейсен гишүүний асуулт хариулъя. Ер нь төсөвт орон тоондоо баригдаж ажиллах ёстой. Бид нар энэ дээр ямар нэгэн цалингийн тийм нэмэгдэл зүйлийг гаргахгүй.

Л.Энхнасан: Бейсен гишүүн. Энэ Бейсен гишүүний асууж байгаа асуултад нь ажлын хэсгээс хариулаад аль. Сайд аа Чинбүрэн сайд аа хэн хариулах уу? Бейсен гишүүн тодруулга хийнэ.

Б.Бейсен: Энэ эрүүл мэндийн салбарын төсөв өр, зээл эмч хүний хувьд санаа зовж байгаа л даа. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг бас хүнд байдалд оруулаад Эрүүл мэндийн яамныхны хариуцлагагүй ажиллагаа байхгүй юу

энэ чинь. Баян-Өлгий аймагт 386 орон тоог чинь 24 онд баталж өгсөн байна. 25-нд 505 орон тоогоор баталж өгсөн. Хяналт шалгалт хийдэггүй ерөөсөө. Энэ чинь эргэж цалин, НДШ-д нөлөөлж байгаа асуудал байхгүй юу. Төсөвт өндөр тусаж байна шүү дээ. Энэ аудитын газар энд хяналт хийж, шалгаж өссөн юм уу?

Л.Энхнасан: Энэ Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүн одоо энэ төсвийн тодотголтой хамт бид бас энэ албаны дарга, эмнэлгийн дэд захирлууд, баахан нэмэгдэл орон тоонуудыг хасахаар бид бас ажиллаж байна. Засгийн газраас барьж байгаа юунд ямар ч байсан эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдын тоог хорогдуулахгүйгээр эмнэлгийн хүч хөдөлмөр хийгээд, хөдөлмөр, байгууллагадаа үр дүнгийн гэрээгээр мөнгө олж ирж байгаа улсуудын хийсэн хөдөлмөрийг баахан албаны дарга, баахан дэд захирлуудаар авдаг байдлыг арилгахаар бас зорьж байгаа.

Тэгэхлээр таны энэ хэлж байгаа шүүмжлэл ямар ч байсан энэ үлдсэн 6 сарын хугацаанд илүү бүтээмжтэй, илүү сайн болох ийм зорилго тавьж бүтцийн өөрчлөлтүүд орно. Энэний дараагаар бас танд бас дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Л.Энхнасан: Баярлалаа. Би бас ганц, хоёр зүйл тодруулж асуумаар байна. Энэ 24 оны тайлан дээр Эс, эд, эрхтэн шилжүүлэх суулгах төвийг 140 тэрбум төгрөгийн төсөв баталсан байна. 24 оны байдлаар 10 хувийн хэрэгжилттэй гэж байна. Энэ нь яагаад 10 хувь байгаа юм? Бид нар бас л энийг Байнгын хороогоор ярьж байж нэмж батлуулсан шүү дээ. Энэ жилийн ч төсөв дээр бас энэ орж ирсэн байсан. 10 хувьтай байгаад байх юм бол энэ ингэж батлах шаардлага байна уу?

Хоёрдугаарт энэ Эрүүл мэндийг дэмжих санг 24 оны гүйцэтгэлээр 59 хувь хувийн гүйцэтгэлтэй байна. 9 тэрбум 810 мянган төгрөг төсөвлөөд 5 тэрбум 785 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ яагаад 4 тэрбумыг хэмнэчихсэн юм зөрүү нь? Энэ чинь хамгийн Эрүүл мэндийг дэмжих сан гээд бид нарын өнөөдөр яриад байдаг нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх энэ чухал сан шүү дээ. Энэ яагаад хэрэгжилт нь 50-хан хувьтай байгаад байна?

Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Байнгын хороон дарга бас чухал юм анзаарсан байна. Бид бас өнгөрсөн хугацаанд Эрүүл мэндийг дэмжих санг Тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад 10 тэрбум болгосон. Одоо гүйцэтгэл нь 50 хэдэн хувьтай. Нэг ёсондоо энэ сангаас гадаадад эмчлүүлсэн Монголдоо эмчилж болохгүй хүүхдүүд, насанд хүрсэн улсуудын төлбөрийг өндөр болгосон шүү дээ. Хүүхэд 50 хувь, том хүн 20 хувь. Гүйцэтгэл иймэрхүү хэмжээтэй. Дээрээс нь шинэ технологи нэвтрүүлэхэд санхүүжилт өгөх ийм боломжийг гаргасан багаар нь сургах энэ тэр гээд. Ийм л гүйцэтгэлтэй байсан учраас тодотгол дээр сайн гүйцэтгэж чаддаггүй юм байна гээд 50 хувийг нь хассан байгаа шүү дээ. Ийм л байдалтай байгаа. Би энэнээс өөр хариулт хэлж мэдэхгүй.

Л.Энхнасан: Нөгөө Эс, эд, эрхтэн шилжүүлэх төвийг Мөнхсүх дарга 1 дүгээр микрофон.

Э.Мөнхсүх: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн тендер маань 2024 онд ажил нь эхэлсэн. Энэ ажил нь эхлэхдээ 2013 оны зураг төсөлтэй байсан. Ажил эхлэхдээ ямар нэгэн зураг, төсөв,

зураг нь 2014 онд магадлагдсан, төсөв нь огт магадлагдаагүй байсан. Үүний дагуу бид газар дээр нь ажлыг нь эхлүүлсэн. Эхлэхдээ 2 хэсэг, 3 барилгатай. Үүний гараашны барилгыг бид өнгөрсөн жил гүйцэтгээд түүнд зориулж бас төсвийн санхүүжилтийг олгосон. Төсвийн гүйцэтгэл 10 хувьтай гарсан. Энэ дээр намар оройтож 8 сард ажил эхэлсэн. Гараашны барилга дээр тухайн үеийн санхүүжилт олгогдоод үлдсэн хөрөнгө нь татагдсан байгаа. 42 тэрбум төгрөг тавигдаад зохицуулалтын дараа 37 тэрбум төгрөг татагдсан.

Л.Энхнасан: Тэгэхлээр 25 оны одоогийн байдлаар бол ажил нь ахисан уу?

Э.Мөнхсүх: Одоогийн байдлаар яг өнөөдрийн бас газар дээр нь бид очиж ажиллалаа. Гараашны барилга дуусчихсан, дотор засалтаа орсон, гадна фасадаа хийж байгаа. Үндсэн барилгын ажил, зоорины давхраа, цутгалтууд хийгдсэн. 1 дүгээр давхрын хана руугаа орох хучилт руугаа орох гээд хэв нь зангидагдаад явж байна лээ. Ажил нь хэвийн үргэлжилж байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ингээд асуулт асуух гишүүд асуултаа асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Бейсен гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүн үгээ хэлнэ үү.

О.Саранчулуун: Өнгөрсөн хавар би нөгөө дахиад эхнээс нь хэлэх гээд байгаа өнгөрсөн хавар Берлин дэх дэлхийн хөгжлийн бэрхшээлийн чуулган дээр Монгол Улс оролцсон. Тэр оролцсон чуулган дээр ямар зүйлд нэгдсэн бэ гэхээр хөгжлийн зорилтот төслийнхөө 15 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжихэд зориулна гэдэг дээр нэгдэж орсон байгаа 147 оронтой. Тэр дээр мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Гэрэл дарга болон миний бие, бид нар явсан.

Ер нь төсөв дээр харахлаар төсөв дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан олон ажлууд бас хийдэг гээд байгаа доторхыг нь ухаад үзэхээр. Тэгэхээр бид нар 1, 2 өдрийн өмнө ирсэн ийм бүхэл бүхэл тоон дотор яг энийг зарцуулсан юм уу, энэ дээр нь нөгөө хүмүүсийнхээ амьдралд ямар өөрчлөлт гарсан юм болоо гэдэг тоог үнэхээр харах ямар ч боломж алга. Ижил төстэй 2 сургалт судалгаа, үнэлгээний институт гээд тэрбум тэрбумын зардалтай ийм байгууллага байдаг юм байна.

Гэтэл яахлаараа энэ улсын тоо баримт, датанууд нь тодорхой байдаггүй юм? Ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл нь ч байхгүй, орон сууцын хүсэлт өгч байгаа хүмүүсийн мэдээлэл нь ч байхгүй ийм асуудлууд байсаар байна 1 жилийн хугацаанд.

Тэгэхлээр Нийгмийн бодлогын байнгын хороо өмнөх өмнөх хурлаараа энэ асуудлуудыг шийдэх 17 зорилт бүхий ийм тогтоолыг Засгийн газарт чиглэл болгож өгсөн байгаа. Энэ дотор ялангуяа хөгжлийн бэрхшээлийн асуудлуудаар заавал хийхгүй бол болохгүй ажлуудыг даалгасан. Тэр ажлууд энэ төсөвтэй уялдсан уу, үгүй юү гэдгийг эндээс олж харах ямар ч боломж алга. Матрицлаад харчихъя гэхлээр байхгүй. Тэгэхээр ер нь цаашдаа Их Хурал ч бай, Байнгын хороон дээр чинь яагаад бухимдаад яагаад дахин дахин асуугаад байдаг вэ гэхлээр нөгөө үл үзэгдэгч төсөв гэдэг зүйл нь байгаа, байхгүй 2-ын дундуур явсаар нь байгаад л 1

жил өнгөрчихдөг юм байна. Ай си Эф-ийн тухай ярьсаар байгаад л жил өнгөрчихдөг юм байна, манай яам, танай яам гэж 2 яам нь хоорондоо шидэлцсээр байгаад л өнгөрчихдөг юм байна, хөдөлмөр эрхлэлтийн тэр зураг, төсөв яахаар болсон бас л ярьсаар байгаад л өнгөрдөг юм байна. Энийгээ цэгцлээд харуулсан юм байна уу гэхлээр нөгөө л бүхэл тоотой. Тэгэхээр ер нь би цаашдаа энэ дээр Байнгын хорооны гишүүдэд мэдээлэл өгдөг юм уу? Ямар бүтэц байх ёстой юм бол? Ер нь парламентын гишүүн энэ Засгийн газарт чиглэл өгөхдөө сая зөвхөн хөгжлийн бэрхшээлийн асуудлаар л бүтэн судалж ойлгох гэж 1 жил ингэж үрж байгаа шиг бусад асуудлыг нь ер нь яаж харах ёстой юм бол? Эсвэл яам өөрөө энэ Ки Пи Ай-уудаа сайжруулах ёстой юм уу? Энийг л бүх л түвшинд яриад л дуусаж байгаа. Ямар ч ийм ойлгомжтой биш байгаад байна. Давхацсан тоонууд харагдаад л байдаг. Бүхэл бүтэн судалгаа хийдэг институттэй юм бол яахлаараа ийм тоо баримт нь муу байдаг юм гээд л ийм бүрхэг асуудалтай л ийм л хурал болж байна л даа. Тэгэхээр энэ дээр ер нь би илүү мэдээллийг ойлгомжтой авмаар байна. Би ойлгохгүй байгаа юм чинь яаж иргэд ойлгох юм? Энэ ойлгохгүй байгаа чинь ил тод биш байна л гэж хэлнэ шүү дээ. Мэдээлэл нь ил тод биш байна л гэж хэлнэ. Ингэхээр чинь иргэд бухимдалгүй яах вэ дээ ер ойлгомжгүй байна. Тэгэхээр энэ дээр ер нь аягүй сэтгэл дундуур байна.

Л.Энхнасан: Энэ дээр Аубакир сайд анхаараарай. Саранчулуун гишүүн бараг хурал болгонд л энэ асуудлыг ярьж яамнаас мэдээллийг хүсдэг. Мэдээллийг нь ойрын хугацаанд яаралтай өгнө үү.

Д.Үүрийнтуяа: Үүрийнтуяа гишүүн үгээ хэлнэ үү.

Тэгэхээр асуусан асуулт, хариулттай холбоотой саналаа нэгтгээд хэлчихье. Өнгөрсөн жил бид нар хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөж оруулахдаа Сангийн яам ч бас тийм шаардлага тавьсан. Зураг, төсөвгүй 1 ч ажил ороогүй л гэдэг ийм зүйлийг бид нарт, гишүүдэд танилцуулж байсан шүү дээ. Төсвийн ажлын хэсэг гараад ч ажилласан. Энэ ажлууд дээр зураг, төсөвгүй 1 ч төсөв байхгүй ээ гэж.

Гэтэл өнөөдөр гүйцэтгэл гараад ярихаар зураг, төсөв нь байхгүй учраас хийгээгүй юм аа гээд сууж байгаа юм. Энэ чинь юу гэсэн үг вэ? Бид нар зураг, төсөвгүй ажлыг Төсвийн хууль зөрчөөд баталчихсан юм болж байна. Тайлбар худлаа яваад байна уу, эсвэл төлөвлөлт чинь хууль бус яваад байгаа юм уу? Сангийн яам энэ дээр бас онцгой анхаармаар байна. Би бас Үндэсний аудитын газар энэ дээр тодорхой дүгнэлтүүд хийгдсэн болов уу гэж найдаж байна. Эсвэл энэ Байнгын хорооны та хуралдаан дээр энэ танхимд хариулт өгч байгаа гишүүд, хариулт өгч байгаа албан тушаалтнууд гишүүдэд худлаа мэдээлэл өгөөд байгаа юм уу? Энийг тодорхой болгомоор байна. Яг энэ гүйцэтгэлээр хэчнээн барилга байгууламжийг зураг, төсөвгүйгээр эхлүүлчихсэн учраас “0” байгаа юм гэдэг дээр албан ёсоор надад эргэж хариу өгөөрэй гэж би хүсье Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас.

Л.Энхнасан: Тэгэхлээр зураг, төсөлгүй төсөвт тусгагдсан ажлууд энэ ажлуудыг зөвхөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэхгүй Эрүүл мэндийн яам дээр бас байгаа. Энийг Байнгын хороод болон Үүрийнтуяа гишүүнд хариултыг нь бичгээр албан ёсоор өгнө.

Бейсен гишүүн үгээ хэлнэ үү.

Б.Бейсен: Энэ эрүүл мэндийн салбарын төсвийн асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй байна. Энэ он дамжсан ч өр, зээлүүд байж байна. Одоо ч эмнэлгүүд өр, зээлтэй, төсөв нь гүйцэд авч чадахгүй байна. Энэнтэй холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээ салгардаж байгаа асуудал байгаа. Үүний тулд энэ бүтэц, орон тоог нь шинэчилж батлахгүй бол Эрүүл мэндийн яам гүйцэтгэлийн санхүүжилттэй учраас эмнэлгүүд мэднэ гээд энэ ерөөсөө болохгүй. Орон тоог нь заавал батлах хэрэгтэй. Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөрийн яам маань хамтарч байгаа төсвийн баталж өгөхгүй бол Эрүүл мэндийн даатгалын сангаас хамаа намаагүй мөнгө нэхсэн шүү дээ эд нар чинь нэхэмжилнэ. Яг батлагдсан орон тоо ийм байна гээд тогтоож өгөхгүй бол ерөөсөө энэ цаашаа явахгүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ хөрөнгө оруулалтын асуудал дээр Эрүүл мэндийн яам хяналт шалгалт хийх хэрэгтэй шүү дээ. Сая 8000-гаад сая төгрөг, нийтдээ 1 тэрбум 100 сая өнгөрсөн жил Аубакир гишүүн, Баделхан гишүүн мэдүүлэг тавиулсан. Одоо эмнэлгээ энэ ашиглалтад ороход 900 сая төгрөгийн тэр юу тавих ёстой байсан чинь юу авсан нь ч мэдэгдэхгүй. Аудитын байгууллага ч гэсэн энэ дээр гүйцэт аудит шалгалт хийгээгүй, юу авсан нь мэдэгдэхгүй ийм л асуудлууд байгаа байхгүй юу.

Саяын эмнэлэг жишээлбэл Хотгорын уурхайн эмнэлэг гээд байж байна. 16 оноос эхэлсэн одоог хүртэл байж байна. 14 оноос. Эхлээд 400 сая байсан, 200 хэдэн сая байсан, одоо тэрбум 200 сая болсон төсөв нь. Нэг том айлын 2 давхар хаустай адилхан барилга байна шүү дээ. Тэнд чинь Хотгор том уурхай байгаа, сургууль, цэцэрлэг байгаа. Уурхайд осол аваар гардаг. Тэгэхэд ийм хүндрэлтэй асуудал үүсэж байхад Эрүүл мэндийн яамныхан ерөөсөө шалгаад очдоггүй. Барилга хариуцсан улсууд ч байж байна, санхүүгийн алба байж байна, хяналт шалгалтын алба байж байна. Ер нь энэ дээр хяналт шалгалт хийгээд очиж байхгүй бол болохгүй. Хуучин яамны групп шалгалт гээд очиход ёстой 5 жилд 1 удаа очиход ёстой бид нар бүх бэлтгэлээ хангаад юмаа шалгуулдаг байсан. Энэ дээр анхаарах хэрэгтэй.

Нөгөө талаар асуух асуудал Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал ирсэн үү шинэ захирал нь? Бас л байдаггүй энэ. Одоо гадаадад эмчлүүлэгчдийн юу энэ хөгжлийн төвөөр дамждаг болсон. Монгол Улсад гадагшаа эмчлүүлж байгаа улсууд гадагшаа яваад очиж ченжүүдийн гарт ордог. 60 юм уу, 100 мянган доллар гэхэд тэрний 10 хувийг нь өгөөд ченжүүд авдаг. Гэтэл эндээс тийшээ бас холбогдсон сураг байна. Аягүй бол мөнгө эргүүлээд мөнгө сааж байж мэднэ ерөөсөө буцааж. Энэ дээр аудитын байгууллага, хууль хүчний байгууллага энэ хяналт хийхгүй бол ард иргэд энийг чинь гадаадад эмч рүү зарим юу дээр чинь даахгүй байна шүү дээ. Хүнд байна.

Эмийн тендерийн асуудал байж байна. Бүх эмнэлгүүд өөртөө Хятадын эмч чинь бүгд гаднаас эм авчирч байна. Энэ дээр энэ хяналт шалгалт хийхгүй бол болохгүй байна. Энэ дээр анхаарч ажиллаарай Эрүүл мэндийн яамныхан байна аудитынхан байж байна. Энэ дээр нэлээн анхаарахгүй бол болохгүй шүү гэдгийг хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Гишүүдийн гаргасан саналыг бол бас манай 2 яамны сайдуудад маань анхаарч, холбогдох баримт бичгийг нь яаралтай хүргэж өгөхийг хүсэж байна.

Ингээд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүн танилцуулна.

Маргааш шүү тийм. Дараагийн асуудалд орёе.

17.32 цаг

Хоёрдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуучнаараа байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуучнаар байгаа гэж би ойлгосон. Зөв үү? Зөв. Сангийн сайд Жавхлан энэ Инновац, цахим хөгжлийн байнгын хороонд танилцуулга хийж байгаа учраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Тилеуханы Аубакир танилцуулна.

Т.Аубакир: Баярлалаа. Нийгэм бодлогын байнгын хорооны хуралдаанд.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд байгаа сорилт, бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1,2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагуудыг тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа. Энэ хүрээнд бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардал, бүх хөтөлбөр, арга хэмжээг зогсооно. Үүнд:

Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо. Мөн төсвийн байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин, төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин, төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардал төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасны зардал, байгууллагаас олгох 1 удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 32.6 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 3.5 тэрбум төгрөгөөр, нийт 36.1 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 541 орон тоогоор бууруулж, 5707 орон тоотой байхаар тооцлоо.

Эрүүл мэндийн сайдын багцын төсвийг 2025 оны батлагдсан төсвөөс нийт 151.1 тэрбум төгрөгөөр, үүнээс урсгал зардал 81.2 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 69.9 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөлөө.

Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд төрийн албаны шинэчлэлийн хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулахаар тусгасны дагуу 2651 орон тоогоор бууруулахаар тооцсон.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнийг танилцуулсан ба Засгийн газар нь 16 яамтай, Ерөнхий сайдаас гадна 19 сайдтай ажиллахаар болсон.

Монгол Улсын Ерөнхий сайд төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр ажиллах зорилт тавьж, зарим сайдын чиг үүргийг ойролцоо чиг үүрэг эрхэлдэг харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бусад сайдын эрхлэх асуудалд шилжүүлэх болсонтой холбогдуулан төсвийн тодотголын төсөлд зарим өөрчлөлтийг тусгав.

Тухайлбал, хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг Сангийн сайдын чиг үүрэгт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын чиг үүрэгт, 20 минутын хотын хөгжлийн асуудлын асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын чиг үүрэгт тус тус шилжүүлж, холбогдох төсвийн өөрчлөлтийг тусгав.

Чиг үүргийн өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын сайд, Хяналт, үйлчилгээний Үндэсний хорооны даргын ажлын алба, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын ажлын алба, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын ажлын албыг тус тус татан буулгалаа.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 36.52 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Аубакир сайд баярлалаа.

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн дарга танилцуулна. 9 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 4 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 68.2 тэрбум төгрөгөөр, зарлагыг 230.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөжээ.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд:

Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулж болзошгүй.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

Хоёрт нь төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий

болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байгааг анхаарч үзэх.

Гуравт нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний 1 удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц, шийдлийг олох шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Магнайсүрэн даргад баярлалаа.

Хуулийн төслүүдийн талаарх танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Энэ үг хэлэх дэггүй байгаа шүү. Тэгэхлээр гишүүд асуултаа асууна уу.

Бейсен гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуултаа асууна уу.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Төсвийн тодотгол хийж байгаа учир, шалтгааныг сайн ойлгож байгаа. Бас тэвчиж болох зардлаа хасаад явж байна. Өнөөдрийн энэ хурал дээр бас тэвчиж болохгүй зардлууд бас олон байгаа. Ялангуяа манай энэ Нийгмийн бодлогын байнгын хороотой холбоотой асуудлууд нэлээн байгаа. Тодотгол хийж байгаа хэд хэдэн арга замууд байна л даа. Хөрөнгө оруулалтын зардлууд хасагдаж байна. Учир, шалтгааныг нь сая бас нэлээн ярьчихлаа. Дараагийнх нь тэр 9 хувийн цомхотгол гэдэг зүйл байгаа.

Дараагийнх нь урсгал зардал гээд үндсэндээ ийм зүйлүүд л байгаа даа. Тэндээс энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудал дээр танагдаж байгаа дээр энэ тоног төхөөрөмжийн 60 тэрбум гээд сонсоход хайран юм тэгээд орон нутгаар явахад энд тэнд очоод сонсож байхад маш их тоног төхөөрөмжүүд дутагдалтай, орон нутгууд автомашины хангалт төдийлөн сайн биш, өчигдөр гэхэд л Сүхбаатар аймгийн Онгон сумынхан ирээд л машингүй Фургон нь эвдэрсэн гээд л л байж байгаа жишээтэй. Дорнодын Дашбалбарынхан машин хэзээ өгөх вэ гээд л ингэж байгаа. Хэнтийгээс бас олон сумдууд л асууж байх жишээтэй. Тэгэхээр энэ би шууд асуухад энэ 60 тэрбум төгрөгийг эргүүлээд тавих бололцоо байна уу? КОП-ын хууль бас яг адилхан тохиолдол шүү дээ. Хийж чадаагүй татагдсан 5 сарын 31-нээр. Гэхдээ эргүүлээд тавьж байгаа. Тэгэхээр би тэвчиж болох зардал, болохгүй зардал гэж ангилахад энэ бас тэвчиж боломгүй зардал гэж ингэж бас бодож байгаа юм.

Дараагийнх нь энэ Эрүүл мэндийн даатгалын сангаас бас 40 тэрбум. Одоо нөхцөл байдал нь ямар байгаа билээ, орон нутгийн нөхцөл байдал ямар байгаа билээ? Одоо очиход орон нутагт эрүүл мэндийн салбар дээр нэлээн хэл амтай байгаа шүү дээ. Иргэд, олон нийт маш их бухимдалтай байгаа. Одоо эндээс нь дахиад 40-ийг хасчихаар чинь энэ чинь ер нь эрүүл мэндийн байгууллага гэж тэнд ер нь үйл ажиллагаа явуулах нь уу, үгүй юу гэдэг ийм.

Дараагийнх нь тэр цомхотголтой холбоотой асуудал байгаа. Цомхотгол 2, 3 янз бас дотроо байгаа. Чиг үүргийн давхардалтайг нь хасна гэж байгаа. Энэ эрүүл мэндийн салбар дээр их гарахгүй болов уу.

Дараагийн тэр нэг цомхотголын бүрэлдэхүүн хэсэг нь юу байна вэ гэхээр одоо байгаа орон тоог нь, нөгөө сул орон тоог шууд тэр чигт нь царцаана гэж байгаа юм. Тэгэхээр эрүүл мэндийн салбар дээр ийм байдлаар царцааж байна уу, энэ чинь шаардлагатай бол эмч, сувилагчаа авахгүй гээд яах юм бэ? Тэгэхээр энэ тодотголын оруулж ирж байгаагаас энэ эрүүл мэндийн салбар дээр ийм чухал зүйл байна.

Хүүхэд хамгааллын хөгжлийн зардлыг ер нь яаж хасаж байна уу, хасахгүй байна уу? Миний хувьд энэ хүүхэд хамгааллын энэ тогтолцоо шинэ хуулиа батлагдаад энэ чинь жил л болох гэж байгаа биз дээ. Тэгээд уул нь энэ 2 зардлыг би танахгүй байх юмаар ийм байгаа юм. Аараа ч таначхаагүй болов уу гэж бас бодож байна. Гэхдээ тодотгол дээр эрүүл мэнд, боловсрол хоёроос бусдыг нь танана гээд байгаа шүү дээ. Би бол хүүхдийн энэ хамгааллын асуудлыг би бас оруул.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмж 1 минут.

Ц.Идэрбат: Дараагийн энэ тодотголын бас дараагийн хувилбар нь юу гэхээр нөгөө урсгал зардал гээд байгаа юм эрүүл мэндийн байгууллагын урсгал зардлаас арай би танагдаагүй болов уу. Ялангуяа тэр дулаа, цахилгааны үнэ гэж. Энэ дулааны асуудал чинь орон нутгийн аймгийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгүүд дээр туйлын төвөгтэй байдал үүсгэнэ шүү. Хувийн компани нь халаадаг, мөнгөө авах гэдэг өгдөггүй. Тэрнээс болоод нүүрсний уурхайтайгаа өр шир үүсдэг. Энэ ч бас орон нутагтаа нэлээн том хэрэглэгчээр явдаг юм байгаа юм. Тэгэхээр тодотгол хийх бол амархан. Өнөөдөр дулаахан байна. Өвөл болно. Тэгэхээр энэ тодотголын маань үр дүн бас тэнд сөргөөр нөлөөлөх вий гэсэн ийм зүйлүүд би тодорхой асууя гэж ингэж бас бодож байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Сангийн яамнаас Санжаадорж дарга 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд тодотголоор хасаж байгаа гэхээсээ илүү Төрийн хэмнэлтийн тухай хуулиар бол автоматаар хэмнэгдэж байгаа. Тэгэхлээр тэр бол гэрээ байгуулаагүй учраас шууд тодотгол дээр тооцоо нь автоматаар нэгтгэгдээд буугаад ороод ирж байгаа.

Гэхдээ бол төсвийн ажлын хэсэг дээр бол яг энэ асуудлыг бас нэлээд ярьсан. Энэ ярьж байгаатай холбоотойгоор бол бас тодорхой хэмжээнд бол ямар байдлаар энийг шийдвэрлэж болох вэ гэдгийг ярьж байгаа.

Хоёрдугаарт орон тоотой холбоотой асуудал бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг дээр бол маш тодорхой заачихсан байгаа. Тэр нь бол төрийн албан хаагчдын нийт орон тоог 9 хувиар бууруулна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 230 мянган албан хаагчдыг 9 хувиар бууруулахлаар 20.1 мянган хүн нь буурах ёстой. Гэхдээ энэ дотроо эмч, багш орохгүй гэдэг байдлаар бол орчихсон байгаа. Яг таны хэлж байгаа асуудалтай холбоотойгоор бол бас яг хүний нөөцийн дутагдал гэдэг талаас нь харах юм бол эмч гэхээсээ илүү сувилагч, асрагч нь илүү хомсдолттой эрүүл мэнд дээр байдаг. Багшийн хувьд, боловсролын салбарын хувьд бол жишээ нь илүү багшийн туслах бол СӨБ дээр илүү дутагдалтай байдаг.

Гэхдээ бол томъёолол нь яах аргагүй эмч, багш гээд орчихсон ийм байдлаар бол орж ирчхээд явж байгаа. Тэр дагуу бол бид хэд энэ жилийн тодотгол дээрээс бууруулж, бууруулахаар тооцооллыг оруулж ирсэн. Шалтгаан нь юу вэ гэхлээр бол ирэх жилийн хувьд бид нар 1 жилийн дотор хүү хаа гээд шууд 20 мянган хүнийг бол бууруулах ийм боломжгүй нөхцөл байдалтай байгаа.

Нөгөө талдаа болохлоороо Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд бол нийт буурч байгаа зардлын хэмжээ 36 тэрбум төгрөг байгаа. Бид бол аль болох тарифтай хүний тоогоор тооцогддог энэ зардлуудыг бол бууруулахгүй байхыг хичээсэн.

Гэхдээ та бүхэнд бид бас танилцуулж байсан. Нийт зарлагын бүтэц маань одоо ямар байна гэхлээр 75 хувь нь бол урсгал зардал, 25 хувь нь бол хөрөнгийн зардал бол байгаад байгаа. Урсгал зардал дотроо бол дийлэнх нь бол өөрөө цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, халамжийн зардлууд болчхоод байгаа. Нийгмийн салбараар нь аваад үзэх юм бол эрүүл мэндийн салбар, нийгмийн хамгааллын салбар, боловсролын салбар маань бол нийт төсвийн бас 60, 70 хувь руугаа дөхчхөөд байгаа учраас бусад хэсэг дээр бол бас зөвхөн ачааллыг аваад явахлаар бусад хэсэг дээр бараг зардал үлдэхгүй шахуу л тийм л болчхоод байгаа.

Тэгэхлээр аль болох бид нар халамж руу болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг бол тодотгохгүй гэдэг ийм байр суурь бариад явсан. Мөн хүний тоотой уягддаг ийм зардлуудыг.

Эрүүл мэндийн даатгалын сангаас бол зардал бол буурч байгаа. Эрүүл мэндийн байгууллагуудын хувьд бол бас ялгаагүй бичиг хэрэг гэх мэт ийм зардлууд нь тодорхой хэмжээгээр буураад би андуураагүй бол даатгалын санд олгох татаасын хэмжээ бол 40 орчим тэрбум төгрөгөөр буурч байгаа ийм зүйл 37.6 сая, тийм 37 тэрбум төгрөгөөр буурч байгаа юм байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн тодруулга.

Ц.Идэрбат: Тийм яах вэ Хэмнэлтийн хууль гаргасан нь гаргасан 5 сарын 31 гэж байгаа юм. Яг төсвийн тодотгол дээр жишээ нь яг КОП-ын хурал чинь яг ийм байхгүй юу. Бас 5 сарын 31-ний өмнө хамаг юм нь амжаагүй, зарлаагүй тэгээд татагдсан. Эргүүлээд тодотгол дээр энэ төсвийн тодотгол дээр хасаад тэгэхдээ дахиад эргүүлээд тавьж байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ эрүүл мэндийн салбар

дээр энэ даатгалын, Эрүүл мэндийн даатгалын энэ сангийн татаас дээр одоо ингээд наад даатгалын сангаа дахиад 40 тэрбумаар цохиод унагаачихвал дахиж энэ сан чинь ер нь босож ирэхгүй дээ. Одоо ер нь үлгэн салган байгаа биз дээ Энхболд дарга аа тийм ээ? Тэгэхээр бас хэдүүлээ тэвчих юм байна, танах юм байна. Би энэ дээр битгий танаасай л гэж ингэж бодоод байгаа юм. Тэр боловсон хүчин дээр одоо байгааг нь энэ орон тоо дутуу ч байсан зүтгүүлбэл дахиж бас энэ ажилчид нь ажлаа хийх нөгөө нуруугаа авна шүү. КОВИД-ын үе шиг юм болох вий.

Тэгэхээр ганцхан эмч биш тэр сувилагч, асрагч гэсэн одоо сул байгаа орон тоог нөхөх.../минут дуусав./

Л.Энхнасан: Сангийн яам Санжаадорж дарга дугаар микрофон.

М.Санжаадорж: Гишүүний саналыг бид бас ойлгож байгаа. Гэхдээ нөгөө талдаа бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай бид нар бас нийцүүлсэн байдлаар ирэх жилийн төсвөө оруулж ирэх ёстой. Энэ дээр хөгжлийн бодлого, 26 оны хөгжлийн төлөвлөгөө дээр юу гээд заачихсан бэ гэхлээр урсгал зардлыг 24 хувьд барина ДНБ-ий нэгд нь.

Хоёрт нь бол урсгал зардлыг энэ жилийн төсвөөс дараа жилийн төсөв гэнгүүт 15 хувиар бууруулна.

Гуравт нь бол энэ орон тоог бууруулна гэдэг ийм зүйл орж ирчхээд байгаа юм. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас хасагдаж байгаа дүн бол түрүүний тэр тэвчиж болох зардлууд дээр нэмээд орон тоо хасагдаж байгаатай холбоотой зардлаар буурчхаж байгаа юм.

Нөгөө талдаа бол бодитоор бол ирэх жилийн төсвийг бид 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлж хийхийн тулд одоо энэ жилийн төсөв дээр бол л нэмэгдэх боломжтой орон зай ойролцоогоор 600 тэрбум төгрөгийн л орон зай байгаа. Тэр дүнд багтах ёстой болчхоод байгаа.

Л.Энхнасан: Энхболд даргаас бас асуусан уу тээ Идэрбат? 2 дугаар микрофон.

С.Энхболд: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Манай даатгалын сангаас нийт 47 тэрбум төгрөг тодотголоор хасагдаж байгаа. Бид өнгөрсөн 23, 24 оны бас гүйцэтгэл, энэ хагас жилийн гүйцэтгэл дээрээ бас дүн шинжилгээ хийгээд жилийн эцсээр бас хүлээгдэж байгаа гүйцэтгэл маань 230-аад тэрбум төгрөгийн бас тийм эрсдэлтэй гарахаар тийм тооцооллын хийсэн.

Тэгэхээр бас 47 тэрбум хасагдах дээр бас цаашид бас тусламж, үйлчилгээ явуулахад бас тэр хэмжээгээрээ л эмнэлгүүд дээр асуудал үүсэж, санхүүгийн эрсдэлүүд гарах тийм байдалтай байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн тодотгол хийнэ үү.

Ц.Идэрбат: Хэдүүлээ энэ байшин, барилга юмнуудыг бас болно. Энэ тоног төхөөрөмж энэ чинь хүний амь настай холбоотой шүү дээ. Эх хүүхдийн эрүүл мэндийн төв дээр MRI гэдэг аппарат нь эвдрээд нэлээн хэдэн сар болж байгаа юм байна лээ шүү дээ. Энэ чинь Монгол Улсын ганц хүүхэд яадаг төв эмнэлэг нь биз дээ? Тэгээд одоо энэ төсвийн тодотгол гээд хэн нэгэн хүмүүсийн хариуцлагагүй

байдлаас болоод тэнд MRI-гүй байж байж болохгүй шүү дээ. Тэр КОП гэдэг чинь та хэд яг тэр Хэмнэлтийн хууль л яриад байна. Яг адилхан шүү дээ.

Тэгэхдээ энэ олон улсын хурал манай улсын нэр хүндтэй холбоотой хийхээс өөр арга байхгүй. Яг үүнтэйгээ адилхан энэ бусад тэгвэл зардлуудаасаа өшөө танаад тэгвэл энэ ядаж эрүүл мэндийн салбарын энэ тоног төхөөрөмжийг нь байлгаж өгөөч, тэр санг нь байлгаж өгөөч. 40 тэрбум төгрөг хэмнэх гэж байгаа гэж байгаа ч энэ сангаа бүүр тарааж хаяад дахиад босохгүй юм болгочих вий дээ л гэж би бол тэгж л санаа зовоод байна л даа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ үү.

А.Ариунзаяа: Яая сая юу орж ирсэн бэ Аубакир сайд аа? Шинийг нь далимдуулаад алах гэж байна шүү дээ. Гишүүд ч их айхтар уншиж, танилцаж амжаагүй Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчдын эрх зүйн статусыг төсвийн хэмнэлт үүсгэж байна гэдгээр хөдөлгөж болохгүй шүү гэдэг заалтыг хүчингүй болгож байгаад нэг хуулиар шүү дээ, хүчингүй болгож байгаад тэгээд алах гэж байгаа байхгүй юу. Тэтгэвэрт гарахад төрийн албан хаагчид 19-23 онд 5-аас доошгүй жил ажилласан байж 36 сарын тэтгэмжийг тухайн ажилласан жилдээ ногдуулж тооцож авах байсныг Дээд шүүхийн шийдвэрээр энэ 5 жил гэдгийг нь болиод 23 оноос хойш 1 жил ажилласан ч бай, 1 жилдээ ногдохыгоо тооцуулдаг ийм хууль Дээд шүүхийн шийдвэрээр хэрэгжиж байгаа.

Үүнийг бол хууль батлагдсан өдрөөс хойш хамгийн багадаа 15 жил ажилласан байж энэ 36 сарын тэтгэврийг, тэтгэмжийг авах эрх нь үүсэх хууль орж ирж байгаа байхгүй юу. Үгүй ээ нөгөөдөр тэтгэвэртээ гарах гэж байгаа 14 жил 364 хоног ажиллачихсан хүн яах вэ төрийн албанд? Уйлаад ёстой газар хатуу, тэнгэр хол л Аубакир сайд хэрэгт ороод л дуусах байсан. Ямар азаар эргүүлэн татах болов. Дагасан хуулийн дагасан тогтоол нь бас буцаагдах гэж байгаа. Тэр дээр бас Улсын Их Хурлын гишүүд нэлээн сайн ажилласанд баярлалаа. Дахиж ийм юм оруулж ирэх вий дээ Аубакир сайд аа. Хүчтэй төрийн албан хаагчдынхаа талд бас хүчтэй дуугардаг ширээ шаадаг хүн байх ёстой шүү та.

Энэ нэмэгдлийг 500 хүрэхгүй докторын 5-10 хувийн нэмэгдлийг 40 хувийн нэмэгдэл авдаг аа гэж ярьж байгаад бас болиулах гэж байгаа юм. Үгүй ээ зөрүүлээд мэргэшсэн нягтлан бодогчдын асуудлыг нь ярих хэрэгтэй байхгүй юу. Яг нягтлан бодогчоороо ажиллаж байгаа юм уу, үгүй юм уу нэмэгдлээ хэн аваад байна вэ гээд. Цалингийн нэмэгдлийн 40 хувиар хязгаарлана гэж байгаа. Хамгийн багадаа багш нар чинь хамгийн багадаа 55 хувийн нэмэгдэл авч байгаа. 60 хувийн нэмэгдэл авч байгаа. 15 хувиар цалинг нь бууруулах нь байна шүү дээ. Нөгөө хил дээр байгаа залуучууд маань 170 хувийн нэмэгдэл авдаг. Хамгийн хамгийн ихээр нь бодохлоор. Тэгээд 170 хувийг нь 40 хувиар хязгаарлаад цалинг нь 130 хувиар бууруулах нь байна шүү дээ. Үгүй ээ үлдэх үү тэнд ажиллаж хүн? Төрийн албан хаагчид ажлаа хаяад босоод гудамжинд гарахад хэн буруудах вэ? Хувийн хэвшлийн дундаж цалингаас төрийн албаны дундаж цалин илүү байна гээд байгаа байхгүй юу. Хуулиар 5 хувийн зөрүүтэй байж болдог юм. 2-хон жилийн өмнө 20 хувийн зөрүүтэй байсан юм. Харин ч Оюун-Эрдэнийн Засгийн газар сайн ажиллаж, төрийн албан хаагчдынхаа цалинг нь нэмэгдүүлж чадсанаар өнөөдөр бас харьцангуй гайгүй ийм юунд орсон байгаа. Та үүнийг мэдсэн үү, танаас санал авсан уу?

Л.Энхнасан: Аубакир сайд хариулна уу.

Т.Аубакир: Төрийн албаны хууль тогтоомж дан ганц бас манай яамны асуудал биш л дээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн эрхлэх зөвлөлийн эрхлэх хүрээний л бас асуудал. Энэ зүйл явж байгааг мэдсэн.

Гэхдээ энэ бас улс төрийн шийдвэр гаргаад Монгол Ардын намын бүлэг татаж авах нь тодорхой байсан учраас. Мэдээж хэрэг Сангийн яам тодорхой хэмжээнд хэмнэлтийн хүрээнд, тодотголын хүрээнд хэмнэлт хийх бодолтой байсан. Улс төрийн шийдвэр нь ингэж гарах байсан учраас айхтар юм яасангүй л дээ. Тэр орой та бид 2 бас утсаар ярьсан. Тэгэхэд би яг хараад сууж байсан л даа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийнхөн ч гэсэн эсрэг л байр суурьтай байсан. Манайх Төрийн албаны тухай хуулийг ганцаар санаачлах бас эрх байхгүйг та сайн мэдэж байгаа. Гэхдээ энэ зөв шийдвэр болсон. Яг энэ хавтгайруулан эрх зүйн байдлыг нь дордуулан, дордуулах шийдвэрийг Улсын Их Хурал ямар ч нөхцөлд гаргахгүй л байсан л даа. Тэгэхдээ Ариунзаяа сайд, гишүүнд бас баярлалаа. Энэ салбарт үргэлж санаа зовж явдагт.

Л.Энхнасан: Ариунзаяа гишүүн тодруулна уу.

А.Ариунзаяа: Төрийн албан хаагчдынхаа төлөө бол хамтдаа байнга хамгаалж, дуугарч ажиллах болно гэдгээ бол зөвхөн би ч биш манай Улсын Их Хурлын гишүүд, энэ салбарт ажиллаж байсан хүмүүс бүгдээрээ л дуу нэгтэй байх байх.

Төсвийн тодотголтой холбоотой ажлын хэсэгт бас орох ажиллах завшаан тохиосон. Ийм учраас бас зарчмын зөрүүтэй саналууд гаргаж, эрүүл мэндийн салбар болон боловсролын салбар дээр төсөв эргүүлэн тодорхой хэмжээнд бага зэрэг ч гэсэн хамаагүй эргүүлэн тавих энэ ийм саналуудыг гаргаж байгаа. Улсын Их Хурлын гишүүд маань бас чуулган дээр, Төсвийн байнгын хороон дээр дэмжээрэй гэж хүсэж байна.

Засгийн газрын хувьд энэ Хэмнэлтийн тухай хуулиа эргэн хараач ээ. 6 сарын 1-нээр хамаг тендер нь зарлагдаагүй байхад буцаан авдаг чинь буруу шүү дээ. Тендерийн тухай хуулиа бас өөрчлөх хэрэгтэй байхгүй юу даа. Маргаан үүсгээд л би авч чадахгүй бол чи авч чадахгүй гээд л маргаан үүсгэж байгаа байхгүй юу даа. Өрсөлдөгчөө гэж хараад л ажил унагааж байна. Энийг өөрчлөх хэрэгтэй. Улс орны хөгжилд энэ чинь маш чөдөр, тушаа болж байгаа байхгүй юу. Энийгээ эргэж хараарай гэж захиж байна.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ үү.

С.Эрдэнэбат: 1, 2 жилийн хүндрэлийн асуудалтай ойлгож байгаа төсөвт тодотгол хийх. Өөдрөг байсан, нүүрснээсээ хараат байсан орлого маань тасалж байгаатай холбоотой. Тэгэхдээ нэлээд хэдэн жил 20, 30 жил өрж авчирч ирж байсан олон хүний итгэл, сэтгэлтэй холбоотой энэ юмнуудыг бас хамаагүй өөрчилж болохгүй. Сая тэр аудитын Ерөнхий аудитор маань хэллээ. Энэ олон цомхотголын асуудалтай холбоотойгоор тэр тэтгэмжийнх нь асуудлыг давхар шийдэх ёстой шүү гээд арай мөнгийг нь тавиагүй байгаа юм биш биз дээ хуулийг нь эргүүлэн татчихаад нөгөө тэтгэмжтэй холбоотой асуудлыг нь? Тэгэхээр энэ тал дээрээ би бас буруу ойлголт аваа юу. Тэрийг тодруулж асуумаар байна. Нэг.

Хоёрдугаарт тэр эрүүл мэндийн юу гээд харахад энэ хүний амь настай холбоотой асуудал шүү. Энэ 1, 2 албан тушаалтан чадаагүй нь хохь нь, чаддаг нь юу вэ гэхээр магадгүй чаддаг нь гэхээр хамгийн мэргэшсэн хурдан тендерээ зарлаж авч чаддаг, овсгоотой сэргэлэнгүүдийнх нь аз. Тэнд нь судлах, ингэх, тэгэх гээд эрүүл мэндийн тоног төхөөрөмж ч гэсэн өөрөө бас явдалтай. Тийм учраас энэ дээрээ бүгдийг нь хасна гэхээсээ илүү тодорхой хувийн нэн яаралтай тэр эх нялхсын үр хүүхэдтэй холбоотой, хавдар, бусад өөр юу байдаг юм энэ тал дээр манай Чинбүрэн сайд өөрөө бас сайн мэдэж байгаа учраас энэ тал дээрээ ярьж үзвэл яасан юм бэ гэдгийг бас би хэлмээр байна.

Орон тоо 9 хувиар цомхотгох нь гээд Санжаа маань багш, эмч гэдэг томъёоллоороо орчихсон гээд юм дахиад хэлчих юм. Боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад гэж би ойлгоод байгаа шүү дээ. Энэ чинь сувилагч байдаг шүү дээ. Зарим аймгууд тэр 20, 30-аараа дутуу байгаа. Бүр хэмнэх нь байтугай тэр хүмүүс гарвал тэр аймгийн эмнэлгийн үйлчилгээ тэр чигээрээ зогсохоор.

Тэгэхээр бид нар магадгүй маш олон хүний амь, хүн амины хэрэг юунд бас орох вий дээ. Сувилагч хамаагүй ээ, тэр туслах багш хамаа байхгүй ээ гэж. Хүүхдийн асуудал гарч ирнэ. Тийм учраас энэ тал дээр би тодруулж асуумаар байна. Багш, эмч гэдэг томъёоллоор орчихсон бусдыг нь цомхотгох болчихоод байгаа гэдэг юмыг тодруулж асуумаар байна.

Ажилгүйдлийн тэтгэмжийг энэ даатгалын сан дээр тусгасан уу гэдгийг би асуумаар байна. Одоо энэ чинь 14 мянган хүн, түүний ажилд ороогүй байгаа гээд байж байгаа хүмүүсийг цомхотгохоор хэчнээн хүний ажилгүйдлийн даатгалын сангийн мөнгийг нэмж оруулж ирсэн үү гэдгийг хэлмээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас оролдоод хэрэггүй байгаа юм даа. Тэртээ тэргүй хүрч ядаж байгаа. Манай энэ төсвийн ярьж байгаа Сангийн яамныхан энэ хавдар тэр өөр 1 дүгээр эмнэлэг өөр хөдөө гадаа очоод үзээч. Тоо хараад үзгийн үзүүрээр тоо өөрчилж болно. Тэрний цаана олон мянган хүний амь нас, эрүүл мэнд, эм тариатай холбоотой асуудал байгаа. Ажилтан, албан хаагчтай холбоотой асуудал байгаа.

Тийм учраас яах вэ хэмнэж болно. Дахиад дотор нь нягталбал бас юм байна шүү. Би бас олон юм яриагүй байгаа. Зарим тэр барилга байшинг тэгвэл дахиад хэдэн жилээр хойшлуулчихвал яадаг юм? Эм, тариатай холбоотой асуудал гэхээсээ илүү тэр байшинд орох, орохгүй асуудал 1, 2 жилээр хойшлох хүртэл асуудал байж болохоор байгаа.

Л.Энхнасан: Сангийн яам хариулах уу? Санжаадорж дарга 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө дээр юу гэж заасан бэ гэхлээр төрийн албаны шинэчлэлийг хийж таслал тавиад чиг үүргийн давхардлыг арилгаж, таслал тавиад төрийн албан хаагчдын тоог хаалт дотор багш, эмч нараас бусад 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ гээд яг заачихсан. Тэгээд яг энэ хэлэлцүүлгийн үеэр бол чуулган дээр болон Байнгын хороон дээр бол бас энэ гишүүд тодруулж асууж байхад энэ 9 хувийн цомхотголд нь өөрөө бол бас төрийн зарим албууд дээр арай өөр өөр хувь, процентоор явахаар тайлбарыг тухайн үед хийгээд явж байсан.

Цомхотголтой холбоотойгоор бол бид бол 2 янзын баримт, мэдээлэл дээр тооцоолж энэ удаагийн тодотголоор оруулж ирсэн.

Нэгд нь бол Үндэсний аудитын газраас бол хүний нөөцийн аудитыг бол хийсэн байгаа. Үүн дээр бол сул орон тоо бол 5 мянга гаруй гэсэн ийм тооцоо гарч ирсэн. Манайхаас цалингийн мэдээллийн систем дээр 6 мянган орон тоо бол сул байна аа гэдэг ийм тооцоолол гарч ирсэн байгаа.

Түүнчлэн 2025 оны төсвийн жилд бол 7.3 мянган төрийн албан хаагч тэтгэвэрт гарахаар байна гэдэг ийм тооцоолол байж байгаа. Энэ тооцооллын хүрээнд бол бид нар аль болох бодитоор хүн халахгүй байхаар зөвхөн сул орон тоог бууруулах замаар энэ асуудлыг эхний ээлжид шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Хоёрдугаар ээлжид бол юу гэхлээр 2026 оны төсвийн төслийг бол өргөн барих хугацаанд чиг үүргийн шинжилгээгээ хийгээд төрийн нийт албан хаагчид нь бол буурахаараа, тоо нь бол бариулж бууруулахаар, харин албад болгон дээр бол энэ бол хэрэгцээ, шаардлага нь арай өөр байгаа ч хэрэгжүүлж байгаа чиг үүргүүд нь өөр байгаа. Энэ дагуугаа бол тооцооллыг бол бид хийж оруулж ирнэ гэсэн ийм тооцоололтой бол байж байгаа.

Нийгмийн даатгалын сан дээр, Ажилгүйдлийн даатгалын сан дээр бол бид нар холбогдох зохицуулалтыг оруулж ирсэн байгаа. Тухайн байгууллагаас нь өгөх 3 сарын тэтгэмжийн зардлыг батлагдсан төсөвтөө багтаа гэдэг байдлаар бид орж ирсэн байгаа. Ер нь төсвийн тодотгол дээр бол ердөө 3 төрлийн л зардал бол нэмж оруулж ирсэн. Бусад бүх зардлыг бол бууруулсан байдлаар оруулж ирсэн байгаа. Эхнийх нь бол түрүүн ярьсан КОП-той холбоотой зардал. Хоёр дахь зардал нь бол ТЭЦ 3-ын осолтой холбоотой гээд зардал, гурав дахь нь бол энэ байгалийн гамшиг, түймэртэй холбоотойгоор Засгийн газрын нөөц сангийн зардлыг нэмэгдүүлэхээр бол тоолцож орж ирсэн байгаа. Бусад зардлуудыг бол огт нэмэгдүүлээгүй байгаа.

Л.Энхнасан: Баатархүү гишүүн. Тодруулга уу? Эрдэнэбат гишүүн тодруулга хийнэ үү.

С.Эрдэнэбат: 30 жил ажилласан хүнийг 3 сарын тэтгэмж өгөөд л хөөх гэж байгаа юм байна л даа. Тэгээд тэр хөгжлийн төлөвлөгөө гээд л та нар зарим үедээ биелэхгүй болохоор нь тэр чигээр нь хаячихдаг. Одоо болохоор их сүрхий яг энэ дээр заачихсан үг, үсэггүй бид нар үгчлэн биелүүлэх ёстой энэ тэр гээд л ингэж бас юманд хэт туйлширч хандаж болохгүй. Амьдрал баян.

Тийм учраас тэр чинь яг өнөөдрийн энэ нөхцөл байдал шиг юмыг тооцож бас хийсэн зүйл биш. Жилийн өмнө асуудал бас өөр байсан. Тийм учраас энэ хүний аж амьдралтай холбоотой асуудал дээр хамаагүй ингэж хандаж болохгүй байх. 1 сувилагч тэтгэвэртээ гарчихад оронд нь хүн авахгүй гэх юм уу, 1 диализын бөөрний аппаратаар ажиллаж байгаа 1 хүнийг тэтгэвэртээ гаргах гээд түр зуур тогтоож бариад хүмүүсийг гарсны дараа оронд нь энийгээ авахгүй энэ хүмүүс үхвэл үх гэж байгаа юм уу. Тийм учраас иймэрхүү юмнуудаа аягүй сайн бодоорой. Сүүлд нь асуудал гарсан тохиолдолд, хөдөлмөрийн томоохон маргаанууд гарсан тохиолдолд энэ сүүлд нь энэ төсөв батлагдсаны дараа шийдэх гээд шийд.../минут дуусав./

Л.Энхнасан: Баатархүү гишүүн асуултаа асууна уу.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тодотгол, эдийн засгийн нөхцөл байдал энэ бүхнийг ойлгож байгаа гэдгээ хэлье. 1 асуулт, 1 санал байна. Эрүүл мэндийн сайд маань хажууд сууж байна бас ярилцаж л байна. Энэ төсвийн тодотгол гэдэг бүх зүйлийг хасна гэсэн үг биш. Тодорхой зүйлүүд дээр, шаардлагатай зүйлүүд дээр төсвийг нэмэх боломж байдаг. Сангийн яамныхан энэнтэй санал нэг байгаа. Манай Байнгын хорооны гишүүдийн хэлж байгаа би саналуудтай санал нэг байна.

Монгол хүний эрүүл мэнд хамгийн чухал. Энэ 100 мянган хүнд хавдраар нас барж байгаа хувь чинь дэлхийд маш өндөр байна шүү дээ. Эрүүл мэндийн салбарын энэ эрт илрүүлэг, Монгол хүний шүд хөтөлбөр гээд олон зөв зүйл хийж байна. Энэ хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх хангалттай хэмжээний бас төсвийн менежмент байгаа юм уу? 1 л жишээ хэлье л дээ. Өнгөрсөн долоо хоногт над руу 1 хүүхэд бамбай хоншоортой могойнд хатгуулаад хордлогыг нь тайлах тариа олдохгүй байна. Бүхэл бүтэн улс байна 12 цагийн хугацаанд энэ тариаг хийх ёстой гээд олон хүн рүү хандсан байх. Үнэхээр энэ тариагаа хоцорч хийсэн юм байна лээ. Энэ юу илэрхийлж байна вэ гэхээр хаана хаанаа бид нар энэ бэлэн байдлыг бий болгох асуудал байгаад байгаа.

Одоо ингээд улаан бурхан өвчний асуудал ярьж байна л даа. Тэгэхээр энэ нөөц хөрөнгө дээр чинь энэ яаралтай, шаардлагатай үед хийх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал гэдэг зүйлээ авч үлдсэн биз дээ гэдгийг Сангийн яамныхнаас асууя. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь энэ Монгол хүүхдийн энэ хөгжлийн асуудлыг бид нар байнга анхаарч байх ёстой асуудал. Хүүхэд хамгаалал, хөгжлийн асуудал Монгол Улсын ирээдүйн хөгжил дэвшлийн баталгаа. Хүүхдийн төлөө фонд гээд иргэд, аж ахуйн нэгжийн хандиваар яг хэдэн төгрөг цугласан юм бэ? Миний ойлгож байгаагаар 25 тэрбум төгрөг иргэдийн хандиваар бүрдсэн. Иргэдийн хандиваар бүрдсэн сангийн мөнгийг Сангийн яам хязгаар тавиад байдаг. Иргэд энийгээ богинохон хугацаанд хүүхдийн төлөө зарцуулаач ээ гээд санд нь хандив өгчихсөн байдаг. Тэгэхээр сангийн мөнгө яг хэд байгаа юм бэ? Энийг яагаад хязгаар тавиад байдаг юм?

Жишээлэх юм бол Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан гээд харилцаа холбоонд байдаг. Энэ салбарын компаниуд өөрсдөө энэ сангаа бүрдүүлдэг. Тэгэхээр Сангийн яам энэ дээр хязгаар тавьчихдаг. Улсын төсвийн сантайгаа андуураад байдаг юм уу, ямар учир байдаг юм? Ингээд реформ, шинэчлэлийн ажлууд нь гацдаг. Ер нь бүх салбарт тодорхой хэмжээний дусаах маягаар явдаг энэ төсвийн менежментийг өөрчлөхгүй бол ингээд дусаагаад байдаг.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмэлт минут.

Ц.Баатархүү: Реформ шинэчлэлийг энэ салбар хариуцаж байгаа, ажил хийж байгаа хүмүүс чинь бас хийхэд хүндрэлтэй байдаг юм байна лээ шүү. Тэгэхээр энэ асуултад хариулаач.

Гуравт 1 зүйлийг асуумаар байна. Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд байдаг юм. Энэ Хөдөлмөр эрхлэлтийн судалгааны хүрээлэн гээд байдаг.

Монгол залуучуудаас судалгаа авахаар ихэнх нь гадаадад ажиллах сонирхолтой байна гэсэн судалгааны дүн гараад байгаа. Энэ дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн чиг хандлагад нийцсэн энэ түр хугацааны сургалтуудыг хийдэг болмоор байна. Энэ тал дээр хариулт өгөөч. Одоо 30 жил үсчин, гагнуурчин, тогоочийг нь дамжаад хичээллүүлж байгаа шүү дээ. Өнгөрсөн жилээс эхлүүлээд ийм мэдээллийн технологийн хөтөлбөр явуулсан. Яг энэ эрүүл мэндийн асуудалтайгаа уялдуулмаар байна. Жишээ нь энэ асрах үйлчилгээний чиглэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлмээр байна. Мэдээллийн технологийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлмээр байна. Энэ ногоон барилга буюу бид нар одоо пассив барилга барья гээд Улсын Их Хурал яриад байдаг, Засгийн газар яриад байдаг. Энэнийх нь.../минут дуусав./

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сайд Чинбүрэн хариулна уу.

Ж.Чинбүрэн: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Ер нь бид ийм бодлогын том өөрчлөлт гаргаж байгаа зүйл бол энэ олон нийтийг хамарсан өвчин гарсан үед Эрүүл мэндийн даатгалын сангаас авдаг биш төсвөөс гардаг байх ийм хуультай, Эрүүл мэндийн хуулийн энэ заалт байгаа. Үүнтэй ч холбоотой сая Засгийн газрын 2 дахь удаагийн хурлаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс 5 тэрбум, мөн хураагдаж байгаа төсвөөс 10 тэрбум буюу 15 тэрбумыг энэ яаралтай үеийн тусламж, үйлчилгээнд зарцуулахаар мөн батлаад хэрэглээд явж байна. Ялангуяа энэ улаан бурхантай холбоотой энэ санхүүжилт явж байгаа шүү.

Таны хэлдэг бас зөв өө. Ер нь эрт илрүүлэх өвчнийг эрт үед нь оношлох нь өөрөө нэгд амь нас аварна. Хоёрт эрүүл мэндийн салбарт ачааллыг их буулгаж өгдөг, өвчнийг бүрэн эмчлэх боломж үүсдэг. Үүнтэй холбоотой 40 тэрбум төгрөг бас төсөвтөө хадгалаастай. Одоо энэ үйл ажиллагаа илүү оновчтой хийхээр төлөвлөөд явж байна. Эрүүл Монгол хүн хөтөлбөр 6.8 тэрбум суусан байгаа. Эрүүл шүд болон дээр бас Идэрбат гишүүн бас хэлж байсан энэ тоног төхөөрөмж эвдэрсэн, ажиллахгүй байгаатай холбоотой бид бас энэ урсгал зардлынхаа мөнгөнөөсөө нэгдүгээрт нь эрэмбэлээд гаргах бас боломжууд байгаа.

Л.Энхнасан: Сангийн яам 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Сангуудын хувьд бол өөрийн эх үүсвэртэй хэд хэдэн сан байгаа. Та 2-ыг нь дурдлаа. Нэгдүгээрт хүүхэд хамгаалалтай холбоотой сан байна. Хоёрдугаарт бол бүх нийтийн үүргийн сантай холбоотой өөрийн орлогоос бүрддэг. Эдгээр сангууд бол өөрөө өөрийн орлогоос буюу эх үүсвэртэй учраас бол бид нар төсвөөс гаргаад хаячихдаггүй. Энэ бол өөрөө төсвийн бүрэлдэхүүн эдийн засаг байдаг учраас бид нар төсвийн нийт зарлага буюу төсвийн хүрээний мэдэгдэл дээр заасан нийт зарлагын дээд хэмжээндээ ороод явдаг гэсэн үг.

Тэгэхлээр бусад зардлуудыг бид нар бууруулж байгаа тохиолдолд яах аргагүй энэ сангууд маань бол буурчхаад байгаа. Жишээ нь хүүхэдтэй холбоотой энэ сан маань бол өөрөө бол эх үүсвэр нь бол энэ автомашины азын дугаарыг борлуулсантай холбоотой зардал бас нэлээдгүй ордог. Одоогийн байдлаар гүйцэтгэл нь 20 гаруй тэрбум төгрөг болсон байгаа. Гэхдээ бид бол жил болгон тийм хэмжээний мөнгийг нь зарцуулах хэмжээг бол тавьж чадахгүй болчихоод байна. Жишээ нь ирэх жилийн хувьд.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Ирэх жилийн хувьд бол бас энэ өөрийн, нэгэнт өөрийн эх үүсвэртэй боловчиг нөгөө талдаа нийт зарлагын хэмжээндээ оруулж байгаа учраас бид нар бол бүрэн хэмжээнд нээж чадахгүй, тодорхой хэмжээнд л нээхээс өөр аргагүй ийм байдалд орж байна.

Нөгөө талдаа бол та Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг ярьж байна. Энэ сангийн хувьд бол мөн ялгаагүй эх үүсвэртэй. Бид хэд, бид бол хамгийн гол ярьж байгаа асуудал нэгэнт эх үүсвэртэй сангууд дээр гэхээсээ илүү нөгөө талдаа бол ямар үйл ажиллагаа ямар үр дүнд хүрсэн бэ гэдэг ийм гүйцэтгэлийг илүү санхүүжүүлдэг үр дүнг бид нар ярьдаг болох юм бол илүү энэ зардал маань бол ойлгомжтой болох гээд байгаа юм.

Жишээ нь, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хувьд бид хэдэн хүнийг ажлын байранд зуучилж ажилтай болгосон бэ, хэдэн хүнийг тухайн нарийн ажил, мэргэжилтэнд сургаж чадсан бэ гэдэг байдлаар санхүүжилтийг нь өгөөд явдаг ийм зүйл рүү бид нар явуулж байгаа. Мөн 21 аймгийн хувьд бол кэйс болгон нь өөр байгаа. Жишээ нь уул уурхай хөгжсөн газруудад бол уул уурхайн мэргэжлүүдийг илүү дэмжих ч байдаг юм уу ийм бодлого бол явж байгаа.

Л.Энхнасан: Баатархүү гишүүн тодотгол хийнэ үү.

Ц.Баатархүү: Одоо энд айхтар хэдүүлээ цэц булаацалдаад хэрэггүй байх гэж бодож байна. Эрүүл мэндийн тэр асуудал дээрээ бүгд анхаарах ёстой энэ. Тэр дундаа энэ хүүхдийн эрүүл мэнд гэдэг дээр бас яаралтай үеийн менежментээ сайн бодно биз дээ.

Хоёр дахь асуудал бол Хүүхэд хөгжлийн тэр фондоод 25 орчим тэрбум төгрөг цугласан байгаа. Түүнийгээ хүүхдийн хөгжлийн чиглэлээр сүүлийн 30 жил Монгол Улс юм хийгээгүй шүү дээ. Хүүхдийн номын сан байсан банк болсон, зуслангууд нь амралтын газар болсон, сургуулийн спортын талбай нь барилга болж хувирсан. Энэ дээрээ Аубакир сайд зоригтой шийдвэр гаргаасай гэж би бодож байна. Өнөөдөр энэ Байнгын хороонд орон нутгаас сонгогдсон гишүүд байж байна. Нөгөө яриад байгаа сүлжээ тавих санд чинь 17 тэрбум төгрөг байж байна. Энийг хувийн хэвшлийн харилцаа холбооны компаниуд бүрдүүлж байгаа. Сангийн яам энийг нь барьчихдаг. Хувийн хэвшлийн компаниуд Цэцэд хандвал яах юм?

Л.Энхнасан: Аубакир сайд Хүүхдийн хөгжлийн сан болон.

Т.Аубакир: Баатархүү гишүүний асууж байгаа асуулт энэ их чухал асуудал юм байгаа юм. Энэ хүүхдийн фондоод 25 тэрбум төгрөг байгаагаас үүнд энэ жил 8.4 тэрбум төгрөг батлагдсан 25-аас. Яг Сангийн яамтай ч ямар ч хамаа байхгүй л дээ. Хүүхдийн үндэсний зөвлөл маань бас бүтээн байгуулалтынхаа шийдвэрийг гаргаагүй энэ жил бас улс төрийн шинж чанартай бас юу яалаа шүү дээ. Түүнээс биш чухал чухал иймэрхүү зүйл. Баатархүү гишүүн ээ та босоод явчхав уу үгүй юу? Таны хэлж байгаа их чухал санал. Дараа дараагийн хурлуудаар бас саналаа илэрхийлээд Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд бас хүүхдүүдийн төлөө санаа зовж ажиллаарай. Одоо бас он дуустал харьцангуй бас хугацаа байна. Тодорхой юмны зарцуулалтууд, янз бүрийн төлөвлөгөөнүүд байгуулж болно.

Ялангуяа энэ хүүхдийн төлөө байгаа зардлууд маань бас хүүхэд хамгаалал руугаа голцуу чиглэсэн энэ хүчирхийлэлтэй холбоотой бас их аймшигтай тоонууд явдаг шүү дээ. Энэ зүйлүүд рүү ч гэсэн бас чиглүүлж болох юм байгаа юм шүү Баатархүү гишүүн.

Л.Энхнасан: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ үү.

Д.Үүрийнтуяа: Надад хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээрт энэ хөрөнгө оруулалтын ажлууд дээр 4 ажил. Тухайлах юм бол өнөр бүл хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамжийн газрын барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн их засвар, ХСҮТ-ийн их засвар гээд 4 ажил 400-аас 1 тэрбум төгрөгөөр тус бүр төсөвт өртөг нь буучихсан байна. Тухайн жилд санхүүжих дүн хасагдаж байгаа бол бууруулж бай гэж бодохсон. Төсөвт өртөг нь буусан нь ямар шалтгаантай вэ? Энэ төсөвт өртөг дээр магадлал хийгээд буурсан юм уу, ямар учиртай буурсан бэ?

Хоёрдугаарт төрийн хэмнэлтийн хуулиар 57 тэрбум төгрөг Эрүүл мэндийн яам хэмнэсэн гээд Санжаадорж дарга Сангийн яам хэмнэлт хийсэн гээд мэдэгдчихлээ тийм үү? Энэ өөрөө сайн зүйл үү? Хэмнэсэн гэвэл бид нар чинь бараг урамшуулдаг биз дээ. Хийж чадаагүй ажлынхаа төлөө, хариуцлагагүй байсан үйлдлийнхээ төлөө, хийх ёстой ажлаа хийгээгүй нь өөрөө хэмнэлт мөн юм уу? Энэ чинь зарцуулж чадаагүй төсвийн үлдэгдэл л болж явах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ хариуцлагагүй хүмүүстэй хариуцлагаа тооцоод эрүүл мэндийн салбарын энэ нэн яаралтай тоног төхөөрөмжийн хангалтаа хийх ёстой гэж үзэж байгаа. Ажлын хэсэгт байгаа гишүүд, төсвийн ажлын хэсэгт байгаа гишүүд энэ дээр бас онцгой анхаарч үзээсэй гэж хүсэж байна. 60 тэрбумаас 3-хан тэрбум төгрөг зарцуулаад 57 тэрбум төгрөг. Энэ чинь юу гэсэн үг вэ? Сая зүүн бүсийн жишээг Идэрбат гиш гишүүн аваад хэлж байна. Манай хойд бүс дээр ч гэсэн Эрүүл мэндийн сайдад Эрүүл мэндийн яам өмнөх Мөнхсайхан сайдад асуудлаа тавиад л ийм ийм асуудлууд хүндрэлтэй байна гэж байгаад л өнгөрсөн жил Нийгмийн бодлогын байнгын хороон дээр эрүүл мэндийн салбарын юмыг хасахгүй шүү гээд л тал талаасаа дайрч байж л хэдэн төгрөг тавиулж авсан шүү дээ.

Гэтэл ерөөсөө 3-хан хувь нь зарцуулагдаад, 5-хан хувийг л зарцуулсан байна шүү дээ үндсэндээ. Ийм хариуцлагагүй байж болохгүй л дээ. Энийг нь хэмнэлт юм шиг яриад байж бас боломгүй байна Сангийн яам. Энэ бол хэмнэлт биш шүү.

Монгол Улсын төсвийн энэ 25 оны төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 15 дугаар зүйл орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулсан байгаа юм. Зарим аймагт олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг бүр хассан. Би ганцхан жишээ хэлье. Булган аймаг 17.9 тэрбум төгрөгийн дэмжлэг авахаар өнгөрсөн жил төсөв батлагдаад энэ онд тэр дүнгээрээ төлөвлөлтөө хийгээд явсан. Сая энэ төсвийн тодотголоор бүгдийг хассан. Хасахдаа яасан гэхээр орон нутагтаа яриагүйгээс болоод асуудал үүсэж байна. Сая ерөөсөө энэ хурал эхлэхийн өмнө Булган аймгийн Засаг дарга надтай орж ирж уулзлаа. Энэ 17 тэрбум төгрөг төлөвлөсөн мөнгөнөөсөө тендер зарлаад Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээндээ 5 сарын 31-нээс өмнө 8.9 тэрбум төгрөгийн тендерийг шалгаруулаад гэрээгээ хийчихсэн байгаа юм. Гэтэл нөгөө мөнгийг нь тэр чигт нь хасаад хаячихсан. Одоо тэгээд яах вэ? 1 аймаг дээр Засаг дарга нь ирээд уулзахад л ийм асуудал.../минут дуусав./

Л.Энхнасан: 1 минут нэмэгдэл.

Д.Үүрийнтуяа: Энэ чинь цаана нь ийм олон асуудлууд нөгөө хүндрэл дагуулж орж ирэх юм биш биз дээ? Энэ гэрээ хийчихсэн тендерийнхээ асуудлыг яах ёстой юм бэ? Тендерийг нь шалгаруулаад компанитайгаа гэрээ хийчихсэн төсвийг нь бүгдийг нь татаад авчихсан. Ядаад 8.9 тэрбумаа тавиулчих юм сан гээд орж ирж байна шүү дээ. Одоо 17.9 тэрбумаас.

Дараагийн асуудал энэ хүүхэд хамгааллын ажилтнуудыг шинэ хууль батлагдаад өнгөрсөн оны 9 сарын сараас эхлээд хэрэгжээд явж байгаа. Хүүхэд хамгааллын ажилтнууд энэ онд 25 оны 1 сарын 1-нээс эхлээд томилогдоод ажлаа хийх ёстой. Гэтэл одоо томилогдоогүй байгаа аймаг, сумдын хүүхэд хамгааллын ажилтнуудыг авахгүй байхаар тийм зохицуулалтыг хийе гэж байгаа юм байна. Эцсийн дүндээ яах вэ төсвийн хэмнэлт хийх, тодотгол хийх шаардлага байгааг хүлээн зөвшөөрч дэмжиж байгаа.

Гэхдээ бид нар чухал, чухал биш ээ эрэмбээ хармаар байна. Юунаас хэмнэх юм бэ, юуг нь хойшлуулах юм бэ гэдэг юмаа эрэмбэлээч. 1 ч хөрөнгө оруулалтын зардал төсөвт өртөгт.../минут дуусав./

Л.Энхнасан: Аубакир сайд. Сангийн яамнаас Санжаадорж хамгийн эхлээд хариулъя. 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2 дээр бол энэ 5 сарын 31 гэсэн хугацаанд, заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох гээд үг, үсгээр байгаа. Энэ дагуу нь хэлж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол би таны хэлсэнтэй бол 100 хувь санал нэг байна. Төсвийн хуулийн маань уул нь яг хамгийн гол амин сүнс гэдэг маань юу вэ гэхлээр хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт байгаад байгаа юм. Тэгэхээр төсөв анх батлагдахдаа ямар шалгуур үзүүлэлт, юу хийнэ гэж төлөвлөсөн бэ? Тэр ажлаа гүйцэтгэсэн үү, үгүй юу гэдэг маань өөрөө чухал болчихоод байгаа юм.

Хоёрдугаарт хэрэв зардал хэмнэж байгаа бол зардал хэмнэлтийг бол ер нь олон улсад юу гэж үздэг вэ гэхлээр энэ бол өөрөө буруу төлөлт байна гэж бас нөгөө талдаа бас үзэх боломжтой байгаад байдаг. Тэгэхлээр энэ бол хэмнэлт үүсэж байгаа нь нөгөө талдаа таны хэлж байгаагаар энэ хариуцлага тооцох асуудлууд бол үүссэн байна гэж бол би миний хувьд, хувь хүний хувьд дүгнэж байна.

Хоёр дахь асуудал нь бол энэ аймгуудын төсөвтэй холбоотой асуудлыг ярьж байна. 21 аймаг дээр бол яг ижил зарчим бол бариад явсан. Барьсан зарчим дээр бол энэ хасах зардлуудын хувьд бол хэрэгжиж эхэлж байгаа болон хэрэгжүүлж эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээнүүдийг бол бүгдийг нь 30-50 хувиар бууруулсан.

Дээрээс нь аймгуудын хувьд бол их засварын зардлыг бол 30 хувиар бууруулсан. Орон тоог бол 9 хувиар хэмнэсэн. Бичиг хэрэг, томилолтын зардлуудыг тэглэсэн байгаа.

Булган аймгийн хувьд бол яагаад ийм онцлогтой байгаа вэ гэхлээр Булган аймагт бол байгаль хамгаалах зардал бол өөрөө өндөр байсан. Энэ зардал 50 хувиар буурсан нь бусад аймгуудаас илүү гарж байгаа юм. Ер нь аймгуудын татаас бол 10 тэрбум төгрөгөөс, хамгийн багадаа 10 тэрбум төгрөг орчмоор бол буурсан. Хамгийн өндөр буурсан аймаг нь бол Дундговь болон Булган аймаг байгаад байгаа.

Л.Энхнасан: Үүрийнтуяа гишүүн тодотгол.

Д.Үүрийнтуяа: Би байгаль хамгаалах зардлын тухай асуусангүй. Та энэ нөгөө төсөв, төсвөөс өгдөг санхүүгийн дэмжлэгийг хараарай. Буурах биш бүүр “0” болчихоод байгаа байхгүй юу. Юун 50 хувь. 17.9 тэрбум төгрөг чинь бүүр байхгүй болчихоод байна шүү дээ. Үгүй ээ 50 хувь ядаад бууруулчихаж болоогүй юм гээд байна шүү дээ. 50 хувийг нь энэ чинь нөгөө ажлынхаа тендерийг зарлачхаад байна шүү дээ. Одоо тэгээд яах вэ? Энэ чинь орж ирж байгаа татаасаа тухайн аймаг, орон нутаг чинь өөрийн орлого гэж тооцоод, тухайн жилийн төлөвлөлтөө хийгээд ажлуудаа эрэмбэлчихсэн байгаа шүү дээ. Тэндээсээ тендер зарлаад юмнуудаа хуваарилчихаж. Энэ зардлын чинь 50 хувь нь төлөвлөгдөөд байгууллагуудтай гэрээ хийчхэж. Одоо яах юм бэ? Энийг болохоороо юу гэдэг юм байгаль орчны зардал нь өндөр байсан юм. Тэрийг нь 50 хувиар хассан гээд суугаад байх юм. Энэ дээр чинь бүр огт байхгүй байна гэдгийг та миний юуг ойлгож байна уу, үгүй юу? Эсвэл би их ойлгомжгүй яриад байна уу?

Л.Энхнасан: Сангийн яам хариулах уу? Санжаадорж 7 дугаар микрофон.

М.Санжаадорж: Аймагт татаас өгөх, эсвэл аймгаас төвлөрүүлэх орлого татах асуудал маань өөрөө Төсвийн тухай хуулиараа зохицуулагддаг. Аймгийн суурь зардал гэдгийг бол Сангийн яаман дээр тооцдог. Суурь зардал гэдэг дээр бол тухайн аймгийн тухайн засаг захиргааны тэр нэгжийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд ямар зардлууд шаардлагатай байна гэдгийг тооцдог.

Нөгөө талдаа орлогыг нь тооцдог. Орлого, зарлагын зөрүүгээс бол татаас авах уу, эсвэл төвлөрүүлэх үү гэдэг энэ тооцоо маань гарч ирээд энэ тооцоо маань өөрөө тухайн жилийнх нь төсвийн тухай хууль дээр бол хуульчлагдаад бол батлагддаг байгаа. Тэгэхлээр тэр байгаль хамгааллын зардал нь бол хамаатай л даа. Тухайн зардал нь бол тэр бусад миний түрүүний хэлдэг гэсэн зарчмаар буюу төсөл, арга хэмжээний зардлуудыг бид нар бол 50 хувиар бууруулж байгаа бууралт дээр бол буураад ороод ирчхэж байгаа учраас өөрөөр хэлбэл нийтдээ 5 тэрбумаар нь буураад ороод ирчхэж байгаа учраас бусад аймгаас бол илүү буурч харагдаж байна. Бусад аймгийн хувьд ийм зардал байхгүй байгаад байна.

Л.Энхнасан: 1 минут Үүрийнтуяа гишүүн тодотгоно уу.

Д.Үүрийнтуяа: Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн талаар энд яриад, надад юу яагаад яах вэ дээ би ерөнхийдөө ойлгож байна яаж хийж байгааг. Би тодорхой жишээ кэйсээр асуугаад байгаа байхгүй юу. Та надад энд хариулахад бэлэн биш байвал яг энийг надад албан бичгээр хариу өгөөч. Энэ хуулийн төслийн 15 дугаар зүйл орон нутагт олгох татаас, дэмжлэг, санхүүгийн дэмжлэг. Энэ дэмжлэг дээр 25 оны төсвийн хууль дээр Булган аймагт 17.9 тэрбум төгрөг байсан. Бусад аймгуудыг таны хэлж байгаагаар доод тал нь 5 тэрбумаар, дээд тал нь том аймгууд дээр 20 тэрбум, 60 тэрбумыг төсөвлөсөн аймгууд дээр 40 болгоод бууруулсан байна лээ. Хамгийн өндөр дүнгээр “0” болчихоод байгаа аймаг нь

Булган аймаг дээр 17.9 тэрбумыг бүр “0” болгочихлоо. Тэр байгаль орчны хамгаалах тэр байгаль хамгаалалтай холбоотой тэр зардал нь 5 тэрбум илүү байсан юм бол 5-гаа хасдаг юм байлгүй бодвол. Яг энэ яагаад “0” болчхов гэдэг дээр энэ аймгаас санал авсан юм уу, үгүй юм уу гэдэг дээр албан бичгээр хариу өгөөч.

Л.Энхнасан: Сангийн яам 7 дугаар микрофон, Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Гишүүний тавьж байгаа асуудлыг ойлгож байна. Албан бичгээр 21 аймгийн хувьд зарлага нь хэд байж байгаад хэд болж буурсан, мөн орлого нь хэд байж байгаад хэд болсон ингээд томъёогоор бол татаас, шилжүүлэг нь хэд болсон бэ гэдэг дээр бол тооцоолол өгье. Гэхдээ цаад асуудлыг нь би бас ойлгож байгаа юм. Энэ бол татаас “0” болчихлоор гэрээ байгуулчихсан асуудлууд яах вэ гэж байна. Бид бол төсвийн тодотголын асуудал дээр бол Засгийн газраар бол оруулж танилцуулаад шууд өргөн барьсан. Хэрэвзээ тодотголоор бид нар ийм зардал хасъя гэх юм бол аль ч салбар хасуулахгүй л гэх байх л даа. Тэгэхлээр 1 зарчим бариад энэ зарчмынх нь дагуу л тооцоолол хийсэн байгаа.

Өмнө нь ийм кейсүүд үүсэж байсан уу гэвэл үүсэж байсан Үүрийнтуяа гишүүн ээ. Тухайн үедээ бол ямар байдлаар шийдэж байсан бэ гэхлээр зарим төсөл, арга хэмжээнүүдээ зогсоох, заримыг нь хойшлуулах байдлаар бол аймгууд шийдээд явж байсан. Энэ эх үүсвэртэй л багтааж хэрэгжүүлнэ гэсэн үг л дээ.

Л.Энхнасан: Баярлалаа. Гамаа гишүүн асуултаа асууна уу.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Энэ гол нь мөнгө, төсөв хүрэхгүй бол мэдээж тодотгол оруулж ирж байгаа. Тэрийг бол ойлгож байгаа. Тэгэхдээ төсөв хүрэхгүй учраас хасаж л таараа.

Тэгэхдээ энэ тодотголыг хийхдээ үр ашгийг дээшлүүлэх тал дээр салбар яам ч байсан Сангийн яам ч байсан тэрнээс хөл дүнг нь автоматаар буурууллаа гэхэд үр дүн байхгүй, үр ашиггүй байгаад тэрнээсээ гадна гишүүдийн түрүүнээс хойш хэлээд байгаа бэрхшээлтэй асуудлууд улам нэмэгдэх гээд байна. Жишээлбэл, яг ямар зарчмаар энийг хэрэгжүүлэх вэ гэдэг нь аягүй надад сонирхолтой санагдаад байна л даа. Жишээлбэл, үр ашиг ярих юм бол зарим эмнэлгүүд ч юм уу, эрүүл мэндийн байгууллагууд ч юм уу нөөцөө хэтэрхий тэлээд ороо ч юм уу, эсвэл орон тоогоо хэтэрхий ихэсгэчихсэн, зарим нь болохоор чинь аягүй сахилга баттай, үр ашигтай ажиллаж байгаа ямар нэгэн өр төлбөргүй явж байгаа ийм газрууд байгаа.

Гэтэл бүгдийг нь 9 хувь бууруулаад хаячихаар автоматаар нөгөө үр ашигтай сайн сахилга баттай явж байгаа нь ч 9 хувиар буураад хохироод байдаг. Угаасаа тэр замбараагүй нэмэгдэл үүсгэчихсэн эд нар нь ч гэсэн улам дордох гээд байдаг. Тэгэхлээр яг энэ хэрэгжүүлэлт дээр Сангийн яам жишээлбэл Сангийн яам цаасан дээр би ойлгохдоо шууд хасчихад бас амархан. Яг хэрэгжилт дээр яаж явах вэ Засгийн газар гэсэн утгаараа нэгдмэл бодлоготой явах ёстой юм байгаа биз дээ манай засаг чинь? Сангийн яам тусдаа, Эрүүл мэндийн яам, тэнд нийгэм бодлого гээд тусдаа байхгүйгээр. Тэгэхлээр энэ хэрэгжилт дээр нь яаж үр ашгийг нь дээшлүүлэхийн хувьд гарах вэ гэдэг ийм нарийвчилсан ийм мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа байна уу? Тэрийг би бас харчихмаар байна.

Сая хэлж байна Эрүүл мэндийн даатгалын сангаас 47 тэрбум төгрөг хасагдаж байгаа гэж байна тээ? Тэгэхээр чинь нөгөө дутагдаж байгаа сангийн хүрэхгүй байгаа мөнгөнөөс хасахаар одоо гэрээ хийчихсэн, эсвэл өргүй гарна гэж найдаж байсан эрүүл мэндийн байгууллагууд, газрууд чинь эргээд энэ өр нь нэмэгдэнэ гэсэн үг үү? Энэ дээр яг ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ?

Жишээлбэл, төрийн үйлчилгээний даатгалынхаа багцаасаа хасах юм уу, эсвэл энэ тарифаа бууруулах юм уу, эсвэл эмнэлгийн гэрээгээ дахиад бууруулах юм уу, Засгийн газар бас энэ дээр ямар бодлого хэрэгжүүлж гэж бодож төлөвлөж ярьж байгаа юм?

Гуравдугаарт энэ 47 тэрбум төгрөг бууруулж байгаа нь шимтгэлээсээ орлогоо санхүүжүүлж үйлчилгээгээ бууруулах ийм боломж нь бас байгаа юу? Жишээлбэл, нөгөө төр хариуцсан хэд хэдэн бүлэг байгаа шүү дээ. Хүүхэд төрөх, яаралтай, халдварт өвчин, анхан шатан эдгээрээ бас бууруулаад явах юм уу гэдэг нь бас их юу гэдэг юм хурцаар тавигдаж байна. Одоо яах гэж байгаа бол гэдэгт жоохон санаа зовж байна. Энийг бас яаж хэрэгжүүлэх юм? Зүгээр механик хасалт хийхгүй байх гэж л бодоод байна. Одоохондоо цаг болчихож байгаа учраас зогсчихъё.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сайд Чинбүрэн хариулна.

Ж.Чинбүрэн: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Тийм ээ зөв. Яг жишээлбэл эмнэлгүүдийн, ижил төстэй эмнэлгүүдийн үйл ажиллагаа, өр зээлийн асуудлыг харахад үр дүнтэй ажиллаж чадаж байгаа, цомхон бүтцээр ажиллаж чадаж байгаа ийм тогтолцоонууд байна. Тийм учраас энийг 1 шаблоноор бүгдийг нь 9 хувь гэж хасахгүй ээ яг зөв. Та энэ дээр битгий санаа зовоорой. Ер нь илүү оронтой, ашиггүй, үр ашиггүй байгаа тэр тогтолцоонуудыг нэг бүрчлэн бид ярьж байж тэн дээр шалгуур тавьж байж хасна. Ер нь болж өгвөл ерөөсөө яг ажил хийж байгаа, хөлсөө гоожуулж эмнэлэгтээ орлого олж байгаа тэр бүтцэд яагаад ч халдахгүй байх.

Дээрээс нь манай салбар голдуу эмэгтэйчүүд ажилладаг. 80 хувь нь эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд хүртэл ажиллаж л байгаа. Гол нь энэ удирдлагын данхайсан тогтолцоог буулгах л хамгийн гол зорилго оршиж байгаа шүү. Энэ дээр яг санал нэгтэй ингэж байгаа юм.

Даатгалын сангийн 47 тэрбум хүрэхгүй болчихсон юм чинь яах вэ гэж байгаа юм. Энэ дээр бид олон гаргалгаанууд хайж байна. Түрүүн хэлсэн Нийгмийн даатгалын сантай 89 тэрбум төгрөгийн өглөг, авлагын байж байна. Энийгээ яаж шийдэх вэ гэдэг бас. 89 тэрбум төгрөг байна гэсэн үг байхгүй юу Эрүүл мэндийн даатгалын санд авлагаар. Дээрээс нь “Чингис хаан” банкнаас 30 тэрбум төгрөг авах мөнгө байна гэсэн үг байхгүй юу. Үйл ажиллагаа явуулаад байгаа шүү дээ. Үйл ажиллагааг нь Монголбанктай яриад хаачих юм бол энэ чинь мөнгөө өгчих юм биш биз гэсэн бас бодлогууд байж байна. “Капитал” банктай бас авлагууд байж байна. Ингээд авдрын ёроолыг ухвал атга гурил гаргана гэдэг шиг боломжоо бүх юмаа дайчилна. Та бүхэн бас ойлгоорой бас эдийн засаг ийм хүнд байгаа. Тодотгол хийж 3.4 их наяд төгрөгийг хасаж, үүн дээр би мэдээж эрүүл мэндийн салбар аль болохоор л мөнгөө хасуулахгүйн төлөө бид бас ч чармайж, хичээж албан бичгүүд хүртэл явуулж л байсан энэ тодотголын нөгөө тооцооллууд орох үед.

Жишээлэх юм бол хамгийн бодитой тоо гэхэд л ЭМД энэ янзаараа явахад оны төгсгөлд 240 гаруй тэрбум төгрөг дутна шүү дээ. Ерөөсөө бүүр нь бүүр тодорхой байхгүй юу гэх мэтчилэнгээр бид бүх боломжуудыг эрэл хайгуул хийх, дээрээс нь ард иргэдээ тусламж, үйлчилгээг зогсоочихгүй байх юм сан. Нөгөө талаараа эрүүл мэндийн салбараа өөрөө элгээр нь хэвтүүлчхэж болохгүй байхгүй юу. Салбар өөрөө нурж болохгүй. Хэмнэж байгаа нэрийдлээр дахиад босгоно гэдэг асар хүнд шүү дээ.

Тийм учраас бид бүх л боломжтой нөхцөл, байдлуудыг хайж, хамтарч ажиллах гаргалгаанууд олох, энэ гаргалгаа олох л Эрүүл мэндийн яамны гол бодлогын том ажил байгаа. Энэ дээр олон талаас нь зөндөө олон аргуудыг бас хайж, судалж, тооцоолж байна. Зүгээр л энгийн жишээ хэлэхэд бид 360 гаруй төлбөртэй тусламж, үйлчилгээ байдаг. Үүний зөвхөн инфляцтай уялдуулаад 20-25 хувийг нэмэгдүүлэх хамтын төлбөрийг ард иргэдээс санхүүгийн дарамтгүйгээр очуулахад л 40 тэрбум төгрөгийн л даатгалын дарамтыг буулгах жишээлбэл тооцоо энэ тэр байх жишээтэй гэх мэтчилэнгээр олон арга хайна.

Л.Энхнасан: Сангийн яам, Эрүүл мэндийн даатгалын газар түрүүн яаж тооцдог вэ гээд асууж байсан шүү дээ. Хамтарч тооцдог уу хэрэгжилт дээр? Сангийн яам 7 дугаар микрофон Санжаадорж дарга хариулна.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Ганмаа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын яг энэ тогтолцоог өөрчлөх энэ ажил дээр бол тухайн үед Чинбүрэн гишүүн бол маш оройлж орж байсан. Одоо бол яг энэ асуудал дээр бас бид Эрүүл мэндийн яамтайгаа хамтраад бол ажиллаж байгаа. Гол нь онолын хувьд бол ямар байх ёстой вэ гэхлээр бид бол өртөгт суурилсан байдлаар оношны бүлгээр нь бол санхүүжилтийг өгөөд явж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тухайн энэ өвчин, эмнэлгийн тусламж, үйлчилгээг бол ийм хэмжээний зардлаар хийхэд бид нар ийм чанар нэхэж болох юм байна гэдэг л агуулга байгаад байгаа юм. Ийм чанартайгаар эмчилж чадах юм бол ийм өртөг өгнө гэдэг.

Гэхдээ хэд хэдэн алдаанууд байгаа гэдгийг бол Эрүүл мэндийн яамтай бид нар ярилцаад санал нийлж байгаа. Тэр нь жишээ болгож хэлэх юм бол жишээ нь нийтийн, нийгмийн эрүүл мэндийн чиг үүргүүд байгаад байдаг. Ялангуяа энэ манай энэ үндэсний төвүүд дээр байж байгаа судалгаа, шинжилгээ, тандангийн энэ зардлуудыг бид нар эмчилгээ, тусламж, үйлчилгээнийхээ энэ зардлаас санхүүжүүлээд байгаа нь бол болохгүй байгаад байна гэдэг ийм агуулга нэгдүгээрт гарч ирж байна.

Тэгэхлээр энэ зардлыг бол бид нар ирэх жилээс зөвхөн улсын төсөв дээр дангаар нь авч явъя. Зөвхөн эмчилгээнд, энэ тусламж, үйлчилгээний санхүүжилт авсан бол нөгөө талдаа зөвхөн яг тэр тусламж, үйлчилгээгээ үзүүлсэн тэр субъектүүдэд, мөн тэр зардалд нь буюу эм, эмнэлгийн хэрэгсэлд нь зарцуулах ёстой гэдэг ийм бол зүйлийг бол ирэх жилээс хийнэ. Нэгдүгээрт.

Хоёрдугаар асуудал бол юу вэ гэхлээр зарим эмнэлгийн энэ ялгаатай байдлыг бол бид нар бас авч үзэхгүй болохгүй нь. Жишээ нь Цэргийн госпиталь, дээр нь Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн хувьд энд бол цол яваад байдаг. Энэ хүмүүс бол өөрөө цолтой байгаад байдаг. Тэгэхлээр бас энэ эмнэлгүүд дээр гарч байгаа ачаалал маань өөрөө даатгал дээр бас нөгөө талдаа бол бас нэлээд ачааллыг бол үзүүлж байна гэж хараад байдаг. Энэ хүмүүс өөрсдөө тушаалаар бол юу гэдэг юм хил рүү очоод яг эмнэлгийн тусламж,

үйлчилгээгээ үзүүлж байгаа тохиолдолд энд арай өөр тариф явах ёстой юм байна гэдэг ийм агуулга бол бас харагдаж ирж байгаа.

Нөгөө талдаа одоо энэ даатгал дээрээс буурч байгаа зардал маань бол юу гэж буурчхаад байна гэхлээр 42 тэрбум төгрөгийнх нь 40 тэрбум нь бол түрүүний хэлсэн нөгөө орон тоог бууруулахаар буурч орж ирчхээд байгаа байхгүй юу. Уул нь онол нь юу вэ гэхлээр тухайн эмнэлэг үйлчилгээгээ л үзүүлж чадаж байх юм бол менежментийн эрхийг нь илүү тэр тухайн эмнэлэгт нь өгөөд хэдэн хүнтэй ажиллах, гол нь ашигтай ажиллах тэр арга замыг нь л зааж өгөх тийм зүйл бол явах ёстой.

Тэгэхлээр бол яваандаа бол энэ бол ирэх жилээс магадгүй бид нар энэ Эрүүл мэндийн даатгалын сангаас огт буурахгүй байх, зөвхөн огт буурахгүй байх зөвхөн тусламж, үйлчилгээний чанараа ярьдаг. нөгөө талдаа эмнэлгээсээ бол энэ тариф дээр ашигтай ажиллах тэр зарчмаа нэхдэг ийм систем рүүгээ явах болно гэдгийг л ирэх жилээс л.../минут дуусав./

Л.Энхнасан: Гамаа гишүүн тодотгох уу? Тодотгол хийе.

Д.Ганмаа: Дэлгэрэнгүй яг үр ашиг, үр дүн, чанар, тэдгээрт суурилсан байдлаар санхүүжилтээ явуулъя гэж ярьж байгаатай санал яг нийлж байна. Засгийн газар эндээс харилцаа холбоотой, уялдаатай ажиллаад явж байгаа юм байна гэж ойлголоо. Бас маш богино хугацаанд хурдан тооцоод яаралтай оруулж ирж байгаа салбарын сайдын хариулж байгаагаас, Сангийн яамнаас хариулж байхад ч гэсэн удирдлагын бүтцээ бууруулна, эмчээс бусад юуг багасгана гэсэн ийм хариултууд гарч ирээд байна л даа. Би сая харж байсан юм. Энэ жишээлбэл, Улсын нэгдсэн төв эмнэлэг гээд бодоход тэнд 800 хүнтэй. 800 хүнээс ажилтнаас 250 нь эмч, 400 орчим нь сувилагч, лаборант зэрэг хүмүүс, үлдсэн дандаа дэмжих ажилтнууд 150 орчим хүн байдаг юм байна. Дэмжих ажилтан гэдэгт нь эмнэлгийн тоног төхөөрөмж, ариутгал, угаалга, харуул, даатгал, санхүү, статистик чанар гээд хариуцсан. Жишээлбэл эднийхээс.../минут дуусав./

Л.Энхнасан: Ганц минут. Хариулчихъя тээ? Энэ дэгээрээ 1 минутаар хариултаа аваад гэж байгаа учраас. Сайд хариулах уу Чинбүрэн сайд?

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр бид нарын энэ том эрүүл мэндийн даатгалын тогтолцооны том үндсэн зорилго бол үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилт. Тэгэхлээр яаж цомхон бүтцээр илүү олон бүтээгдэхүүнээ чанартай хийх вэ л гэдэг том бодлогын асуудал байгаа. Ижил төстэй эмнэлгүүдийн гүйцэтгэл гээд харахад маш өөр байгаа. Үйл ажиллагаа сайн хийж чадсан, чадаагүй, удирдлагын, бас менежерүүдийн ур чадвар энэ тэр гээд олон зүйл байгаад байгаа. Хуульдаа бид хуулийн төсөл дээрээ эмч, эмнэлгийн эмч, сувилагч нарыг цомхотгохгүй гэсэн бүр өгүүлбэр байгаа. Тийм учраас энэ зарчмаа л барина. Энэ зарчмаа л барина.

Л.Энхнасан: Баярлалаа. Бейсен гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ үү.

Б.Бейсен: Сангийн яамныхан тэр түрүүчийн эмнэлгийн байрны юуг бас би судалж үзсэн. Яагаад төсөвт өртөг нэмэгдсэн бэ гэвэл хагалгааны 2 өрөөний яаралтай болон төлөвлөгөөт хагалгааны өрөөний вакумжуулалтаар нэмэгдсэн байна. Дараа нь яаралтай тусламж, сэхээний тасаг, хагалгааны дараах юунуудын нөгөө хүчилтөрөгч юутай холбоотой, хагалгааны дотор талын угаалга энэ тэртэй холбоотой төсөв нэмэгдсэн байна. Энийг бид нар шалгуулсан бас. Тийм учраас энэ эмнэлгийн баруун алслагдсан аймаг нь анхаарч үзэхгүй бол сая 1 өвчтөн

наашаа тээвэрлээд гарч байна шүү дээ хүнд өвчтөн. Тэр хагалгааны өрөөний одоогийн байгаа эмнэлгийн газар хөдлөлтөөр хана бүр цуурчихсан 2 талаас нь түшчихсэн ийм хүнд байдалд байгаа.

Тийм учраас энэ зам чухал байна уу, эмнэлэг чухал байна уу гэдэг дээр бас зам дээр их хэмжээний хөрөнгө тавих юм. Энэ 206 оны бас юун дээр эрүүл мэндийн салбарт нийт хөрөнгө оруулалтын, дотоод энэ нийт дүнтэй харьцуулахад 3 хувь л тавьсан байна. ДЭМБ 6-7 хувь гэдэг. Тийм учраас энэ дээр та бүгд онцгой анхаарч өгөөч. Би тасгийн эрхлэгч, эмнэлгийн дарга, бүүр эмч хийж байсны хувьд би зун очоод бас хүнд хагалгаанд ордог тэнд. Энэ дээр анхаарч өгөөч. Бид нар сая Эх нялхсын 17 эмчийг наашаа явуулахгүйгээр тэнд хагалгаа хийлгээ гэсэн чинь танай өрөө хагалгааны шаардлага хангахгүй гээд очоогүй. Нүдний эмч нар адилхан очоогүй. Хүндрэл гардаг ийм асуудлууд байж байгаа. Энэ дээр анхаарч үзээрэй. Сайд бас энэ дээр онцгой анхаарна уу гэдгээ хэлье.

Нөгөө талаар энэ ЭМД-д энэ орон тоо, бүтэц орон тоог шинэчлэхгүй бол Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ачаалал өгч байна. Яг баталсан орон тоогоор байвал жишээлбэл тасгийн хэрэг чинь 5 ор гэх юм уу, эмчлэгч юм чинь 10 ор юм уу, 15 ор гээд баталж өгөхгүй бол одоо үзэмжээрээ олон эмч яачихдаг, тэр тасагт 6, 7 эмч ажиллаж байдаг. 50 ортой тасагт гэх мэт орон тооны цомхотгол хийх асуудлыг бас эмнэлэг дотор тодорхой зааж өгөхгүй бол бас болохгүй асуудал байж байгаа. Хүний нөөц гэхэд 2, 3-аараа байдаг ч юм уу, жолооч нар, мөн туслах ажилтан, даргын зөвлөх, менежер зөндөө ирнэ. Илүү орон тоо байх нь байж байгаа. Энэ юу гэвэл Эрүүл мэнд яамны хяналт шалгалт султай холбоотой, дураараа энэ орон тоог өөрсдөө мэднэ гэдгээрээ эцэстээ бүүр төсөвт хүндрэл учруулж байна шүү дээ. Энэ дээр та бүгд онцгой анхаарахгүй бол болохгүй нь ер нь.

Дараагийн асуудал энэ эмийн тендерийн асуудал байж байгаа. Одоо эрүүл мэндийн тусламжид хүргэж өгч байгаа эмийн тендерийн асуудал дээр би 1 минутаа нэмээд авчихъя Энхнасан дарга. Улирал болгон хүргэж өгөх ёстой байсан.../минут дуусав./

Л.Энхнасан: Хариулах уу? Нэмэлт 1 минут. Бейсен гишүүнд нэмэлт 1 минут.

Б.Бейсен: Улирал болгон хүргэж өгөх ёстой юм аа, хадгалах юм аа өөртөө жилийн эмийг тендер авчхаад нэгмөсөн хүргээд өгчихдөг. Тэгээд эмийн хугацаа болон чанар алддаг тийм асуудлууд байж байгаа юм. Тийм учраас энэ эмийн тендерийн асуудал дээр бас онцгой анхаараад яг тендерийн гэрээ хийхдээ баталгаат хугацаанд нь хүргэж өгөх тийм талын бүх асуудлыг тусгахгүй бол үнэхээр эрүүл мэндийн салбарт асуудлууд байж байгаа юм.

Дараа нь энэ эмнэлгийн хот, хөдөөд ч гэсэн цалин нэмэгдээгүй. Одоо бүгдийг нь цомхотгоод хаячихвал, зарим эмч нарыгаа цомхотгоод хаячихвал сувилагч нар ачаалал нь улам хүндэрнэ. Яг дотроо хэмжээний харж байгаад Эрүүл мэндийн яам очиж байгаад юун дээр нь илүү байна, захиргаа талд нь олон болчихсон байна уу, 2, 3 даргатай болчихсон байна уу, хүний нөөц, сувилахуйн албаа нэмчихсэн байна уу, захиргаа талдаа нэмэгдээд байгаа шүү дээ энэ чинь. Яах вэ зарим тасагт нь үзэмжээрээ нэмчихдэг орон тоог нэмдэг. Орон тоо багтаах энэ

Л.Энхнасан: Сайд хариулах уу Чинбүрэн сайд. Тэгээд Сангийн яам 9 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Бейсен гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр түрүүний нэгдсэн эмнэлгийн барилга яг адилхан гүйцэтгэл дээр хийсэн тайлбартаа бид нар төсөвт өртгийн нэмэгдлийн магадлал болон аудитын дүгнэлтээр энэ хөрөнгө оруулалтыг бид нар нэмээд өгчихсөн. Одоо энэ тариф цалингийн 3 тэрбум 3 дахь удаагийн нэмэгдэл нь байгаа. Тэгэхээр хэдийгээр магадлалын ерөнхий дүгнэлт гараад Барилга, хот байгуулалтын сайдаас ирсэн ч гэсэн бид нар төсөв талаасаа, хөрөнгө оруулалт талаасаа нэлээн өндөр, дээрээс нь эрсдэлтэй гэж үзэж байгаа учраас хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг Барилгын яаманд хүргүүлчихсэн байгаа.

Хэрвээ хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гараад ирэх юм бол бид нар Их Хурлын тогтоолын дагуу 26 оны төсвийн төсөлд тусгах бодлого барьж байгаа.

Л.Энхнасан: Сайд хариулах уу Чинбүрэн сайд?

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүн, ер нь аливаа гүйцэтгэл, үр дүн ийм тооцдог Ки Пи Ай гэж яриад байгаа үр дүнд тулгуурласан ийм үйл ажиллагаануудыг явуулдаг байх тал дээр хэдүүлээ бас Их Хурал дээрээ, Байнгын хороо дээрээ нэлээн нягт нямбай ажиллая. Их Хурлын гишүүдийн бид нарын том үүрэг бас баталсан төсвөө хянах том үүрэг байгаа учраас энэ хяналтын үйл ажиллагааг нэлээн тийм яг тухайн тухайн төсөвтэй холбоотой гарч байгаа зүйлүүд дээр хийх гэхэд Эрүүл мэндийн яамнаас нээлттэй бүх тоо баримтуудаа өгөх, явцыг танилцуулах. Би Эрүүл мэндийн сайд болоод яг 13 дахь хоног дээр явж байна. Сая энэ бүтээн байгуулалттай холбоотой тусгайлсан нэгж гаргахаар ажиллаж байгаа юм. Бүх үйл ажиллагаатай холбоотой зүйлүүд.../минут дуусав./

Л.Энхнасан: Бейсен гишүүн тодруулна уу.

Б.Бейсен: Тэгэхээр чинь энэ эмнэлэг чинь 26 он хүртэл орохгүй юм байна. 26 оны 6 сар гэдэг чинь бараг жил болох юм байна. Та нар жаахан эрүүл мэндийн салбарт анхаарч үзээч ер нь. Үнэхээр хүндрэлтэй байгаа асуудал байгаа юм.

Хоёрдугаарт энэ Чинбүрэн дарга аа энэ эмнэлгүүдийн эм, эмнэлгийн зарим эм, эмнэлгийн хэрэгсэл байна шүү дээ протезын эд нар бас байхгүй болчихсон байх юм. Төсөв, хөрөнгө гэдгээр зарим нь 2 жилийн очер хүлээж байгаа. Тэгэхээр чинь нийт төсөв сая таны нөгөө тоног төхөөрөмжийн юмыг чинь бусад сэлбэг хэрэгсэл гэх юм уу машины запаас гэхтэй адилтгаж болохгүй шүү дээ энэ чинь. Эрүүл мэндийн салбарын энэ төсвийг авч үлдэх тал дээр та хүсэлт тавьж байна уу, ер нь үгүй юү?

Л.Энхнасан: Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: Эм ханган нийлүүлдэг байгууллагууд эрүүл мэндийн тусламж үзүүлдэг эмнэлгүүддээ өр, авлагын асуудал нэлээн хурц болчихсон байна. Өнөө, маргаашгүй уулзах гэж байна. Ойролцоогоор гүйцэтгэлтэй холбоотой бараг 220, 30 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байна. Энэ чинь бас бага тоо биш. Асар их тоо яригдаж байна.

Мөн ашиглалтад ороод зөвхөн тоног төхөөрөмж нь дутагдсан ийм эмнэлгүүдийг 1 номерт тавьж ашиглалтад оруулахыг бодно шүү дээ. Энд хойшлуулахгүй. Тийм учраас юу ч гэсэн төсөв батлагдсаны дараагаар бид эрэмбэлээд жишээлбэл Эх нялхсын төвийн MRI ашиглалтад байхгүй тэрийг засах мөнгө гарна, ажиллагаанд оруулах мөнгө гарна. Ашиглалтад орсон зөвхөн доторх тавилга эд хогшил нь дутуу байгаа эмнэлгүүдийг ашиглалтад оруулахад ийм мөнгө гарна. Энэ тооцоонууд байгаа шүү бас. Бүүр хоосон царцчихсан гэж битгий ойлгоорой.

Л.Энхнасан: Та минутаа авчихсан шүү дээ. Дэгээрээ нэмээд авчихсан.

Гишүүд асуултаа асуулаа.

Би би бас сайд аа хэд хэдэн юм асууя. Та эртээд чуулганаар эрүүл мэндийн салбараас 150-аад тэрбум төгрөг хэмнэгдэж байгаа, тодотгол орж байгаа гэсэн. Яг тэр дээр бид нарын одоо ойлгож байгаагаар энэ Төрийн хэмнэлтийн хуулиараа бол 69 тэрбум, ЭМД-аас 47 тэрбум, сайдын багцаас 37 тэрбум гэж байна. Бусад мөнгө нь хаанаас хэмнэгдэж байгаа юм?

Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Энхнасан дарга аа нөгөө хэмнэгдсэн гэдэг үг их буруу болчихоод байна л даа. Тэгэхлээр хэмнэгдэх ч юу байх вэ дээ хураагдсан л гэх юм уу даа. Хэмнэлтийн хуулиараа хураагдчихсан л мөнгө. Яг таны хэлж байгаа дүнгүүд нийлээд 150 орчим л дөхөж байгаа гэдгийг л хэлсэн юм. Яг л ийм 3 дүн байгаа.

Л.Энхнасан: Бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр Сангийн яамнаас асуухад Хэмнэлтийн хуулиар бол 3.5 тэрбум хэмнэгдсэн гэсэн. Яам бол 1.5 тэрбум гэж байна. Энэ хаанаа дүн нь зөрөөд байна. Энийг бас асууя.

9 номер.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуулт, Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Дэлгэржаргал Сангийн яам. Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр Хэмнэлтийн зохицуулалт нь хуулиар зохицуулсан нь тодорхой байдаг. Хэмнэлтийн хуулийн дагуу бид нар 2 төрлийн хэмнэлтийг хийж байгаа. Түрүүн Үүрийнтуяа гишүүн бас асууж байсан өртгүүд буурчихсан байна гээд. Нэг дэх нь болохоор 5 сарын 31-нд гэрээ хийгдээгүй ажлуудыг бүх нийт дүнгээр нь хэмнэсэн тооцож байгаа. Энэ хугацаандаа гэрээ байгуулсан ажлуудын хувьд хууль дээр батлагдсан төсөвт өртгөөрөө тендер зарлаад гэрээ байгуулсан тохиолдолд төсөвт өртөг гэрээний дүнгийн зөрүүг худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт гэж үзээд бас Хэмнэлтийн хуулийн 13.1.3-аар хэмнэх ёстой байдаг.

Тэгэхээр Нийгмийн хамгааллын яаман дээр гэрээ байгуулаагүй ажил дээр нэмэх нь энэ гэрээ байгуулсан ажлууд дээр тендерийн хэмнэлтийг нь бид нар бас хуулийн дагуу хасаж тооцоод нийтдээ 3.3 хэмнэлтэд орсон байгаа.

Л.Энхнасан: түрүүн сайд бас энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн 47 тэрбум нөгөө цалинтай холбоотой зардалдаа хэмнэх гэж байгаа гэсэн. Би зөв ойлгосон уу? Яагаад гэвэл Эрүүл мэндийн даатгалын сангийн бараг Энхболд дарга та энэ дээр бүүр яг тоог нь хэлээд өгөөч. Яг цалинтай холбоотой, мөн

ашиглалтын зардалтай холбоотой, түрээстэй холбоотой хэчнээн хувь зардал гарч байгаа вэ? Ер нь ингэж Чинбүрэн гишүүний нөгөө удирдах албан тушаалтныг 50 хувиар бууруулна гээд бас тогтоол дээр орчихсон байсан шүү дээ? Тэр одоо больсон гэсэн үг үү? Энэ төсөвтэй холбоотой Их Хурлын тогтоол байсан. Тэр тогтоол дээр Эрүүл мэндийн даатгалын санг бие даалгах, эрүүл мэндийн бие даасан болгох, эрүүл мэндийн сайдын багцаас бол хараат бус болгож эмнэлгийн ажилтны 50 хувийг удирдах ажилтны 50 хувиар цомхотгох нь уу? Цомхотгох нь ч гэж дээ бууруулна гэсэн тийм тоо явж байсан. Тэр хэвээрээ үлдэж байна уу, эс үгүй бол энэ тогтоол маань хүчингүй болж байна гэж ойлгох уу?

Сайд, Чинбүрэн сайд хариулна уу.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо дээр бид том өөрчлөлт хийх зорилго тавьж байгаа. Тэр дотроо Эрүүл мэндийн даатгалын сан Эрүүл мэндийн яамны яг удирдлага доор байх нь хэр оновчтой вэ гэдэг асуулт байнга яригдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн цаг хугацаа 21 оноос хойш гүйцэтгэлийн санхүүжилттэй яваад ирсэн цаг хугацаа бидэнд бас их том сургамж болсон. Үүнээс бид сургамж аваад энэ саад болж байгаа энэ тогтолцооноосоо илүү зоримог, зөв тогтолцоо руу орёо гэдэг ийм зорилт тавьж байгаа. Тэр ч утгаараа Сангийн яамтай хамтарсан Эрүүл мэндийн яам, Сангийн яам хамтарсан ажлын хэсэг гараад Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог ямар тогтолцоогоор цаашаа үргэлжлүүлж ажиллах ёстой вэ гэдэг дүгнэлт гаргах ажлын хэсгээ байгуулж эхэлж байна.

Ингэснээрээ худалдан авагч нь өөрөө сангаа удирдаад байх нь буруу гэдэг тал дээр дүгнэлт гаргахаар ажиллана. Танд.../минут дуусав./

Л.Энхнасан: Энхболд дарга хариулт энэ сангийн тогтолцооны талаар ч гэсэн та давхар бас өөрийнхөө саналыг хэлнэ үү. 2 дугаар микрофон.

С.Энхболд: Энхнасан даргын асуултад хариулъя. Түрүүн 47 тэрбумыг яаж яаж хасагдсан бэ гэсэн асуулт асуусан. Энэ дээр надад миний олж авсан мэдээллээр сангийн яг тусламж, үйлчилгээ зардлаас 43 тэрбум, үйл ажиллагааны зардлаас, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлаас 4 тэрбумыг хассан байгаа. Ингээд нийлээд 47 тэрбум төгрөг тодотголоор хасагдаж байгаа.

Сая сайд засаглалын талаар хэллээ. Энэ дээр асуудал дээр би илүү тайлбар өгөх нь зохимжгүй байх. Тэгэхдээ энэ асуудал сайн ажлын хэсэг гарч байгаа учраас тэр дээр бас нэлээн дэлгэрэнгүй яригдах байх гэж бодож байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Их Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана гэж заасны дагуу санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Нийгмийн бодлогын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ажлын хэсэгт баярлалаа. Гишүүд байж байгаарай дараачийн асуудал орно.

18.56 цаг

Гишүүд ээ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүдийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсоно.

Нэр дэвшигчийн сонсголын тайлантай холбогдуулж ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай.

Адъяа нэр дэвшигч, Оюунтунгалаг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Нямдаваа Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүдийн албан тушаалд нэр дэвшсэн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн, нэр дэвшигчдийн сонсголын даргалагч Сархадын Зулпхар танилцуулна.

Танилцуулга, тайланг та бүхэнд тараасан байгаа өнөөдөр өглөө тайланг. Зулпхар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

С.Зулпхар: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүдийн оройн мэндийг дэвшүүлъя.

Нийгмийн бодлогын байнгын хороо өнөөдөр өглөө 9 цаг 15 минутад хуралдаж эхэлсэн. Одоо бид 10 цаг хуралдсан байна. Өглөөнөөс бид бас олон асуудлыг хэлэлцлээ. Өнөөдөр өглөө бол бидний эхний хэлэлцсэн асуудал бол Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан. Энэ сонсголтой холбоотой тайланг та бүхэнд уншиж танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт Улсын Их Хурал энэ хуулийн 35.3-д заасан нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129.9-131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар сонсголыг даргалж, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Баясгалан, Б.Бейсен, Х.Болормаа, Х.Булгантуяа, М.Ганхүлэг, Д.Ганмаа, С.Зулпхар Ц.Мөнхтуяа,

О.Саранчулуун, М.Сарнай, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат нарын гишүүд оролцлоо.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд МҮЭХ-ноос МҮЭХ-ны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш Гончигсүрэнгийн Адъяаг Улсын Их Хуралд санал болгосон.

2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Д.Далхжавыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар томилсон.

Хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг, ганцаарчилсан ярилцлага хийсний үр дүнд нэр дэвшигч Г.Адъяаг мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс, зүй, туршлагын хувьд тавигдах шалгуурыг бүрэн хангасан талаарх дүгнэлтээ сонсголд танилцуулсан.

Нэр дэвшигчийн танилцуулга, шинжээчдийн дүгнэлттэй холбогдуулан сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн сонсголд оролцохоор урьдчилан бүртгүүлсэн иргэн Б.Гүнжилмаа, Ч.Бат-Эрдэнэ нар нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хуралдаанд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 84 хувийн саналаар нэр дэвшигч Гончигсүрэнгийн Адъяаг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн дэмжсэн.

Түүнчлэн нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан нэр дэвшигч болон түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлсэн болно.

Анхаарал хандуулсанд та бүхэнд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Танилцуулга, тайлантай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү?

Байхгүй байна.

Үг хэлэх гишүүн байна уу?

Үг хэлэх гишүүд алга байна.

Анх удаа үг хэлэх, асуулт асуух гишүүн байсангүй. Манай Байнгын хороо дандаа хүмүүс асуултаа асууж, үгээ хэлдэг. Тийм ч учраас өглөөнөөс хойш 10 цаг,

11 цаг хуралдаж байна. Боловсролын байнгын хороотой нийлчихлээр яах юм 24 цаг хуралдах юм уу яах юм.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүдийн албан тушаалд нэр дэвшигчдийн сонсголын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан нэгдүгээрт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн Цэндийн Сүхбаатарын хугацаа дууссан тул чөлөөлөх санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт.

52.9 хувиар чөлөөллөө. Ганмаа гишүүн, Зулпхар гишүүн, Үүрийнтуяа гишүүнийг зөвшөөрсөн тэмдэглэе. Дэмжсэнээр оруулъя.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн Гончигсүрэнгийн Адъяаг томилох санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Бэлдээрэй гишүүд бэлэн үү? Санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд бэлэн үү? Санал хураалт.

70.6 хувиар дэмжигдлээ.

Нэр дэвшигч Адъяад баяр хүргэе.

Санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Зулпхар гишүүн томилъё.

4 дүгээр асуудалдаа оръё. 5 дахь өдөр чуулганаар орно. Амжилт хүсье. Баярлалаа.

19.05 цаг

Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонсоно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, С.Эрдэнэбат нарын хүсэлтийн дагуу тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонсохоор өнөөдөр хуралдаанаар оруулж байгаа.

Хүрэлцэн ирсэн төлөөллийг танилцуулъя. Иргэд ирсэн юм уу? Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн. Мөнхзул Байна уу? Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч. Энэ Лхагвасүрэн Ерөнхийлөгч хаана байна? Ерөнхийлөгчийг байхгүй учраас бид нар 7 хоногоор хойшлуулсан шүү дээ. Энэ хаана юу хийж явж байна энэ хүн? Батболд Монголбанкны Макро зохистой бодлогын хэлтсийн захирал, Мөнх-Ундарга Монголбанкны Хууль, эрх зүйн хэлтсийн захирал, Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга, Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Тэмүжин Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч, Сансар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референт, Мөнхзул

гишүүн ирсэн байна. Хэлчихсэн. Тийм. Мөн тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар өргөдөл гаргасан иргэдийн төлөөлөл бас байгаа. Алтанзул иргэн, төлөөллийг оруулаарай төлөөллийг оруулаарай. Энэ гадаа жагсаж байгаа энэ ахмадуудын төлөөллүүд бас оролцохоор хүсэлт гаргасан учраас өнөөдрийн бас энэ танилцуулгад орж байгаа. Иргэн Ганбаатар, иргэн Гантөмөр гээд эдгээр 3 хүн орохоор ирж явна уу тээ? Оролцох юм байна. Иргэдийг орж иртэл түр хүлээгээд.

Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар өргөдөл гаргасан иргэдийн төлөөлөл оролцож байгаа. Иргэн Алтанзул, иргэн Ганбаатар, иргэн Гантөмөр нар оролцож байна.

Хурлаа үргэлжлүүлье. Тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар Монголбанкны Дэд ерөнхийлөгч танилцуулга хийнэ. Энхтайван 5 номер.

Г.Энхтайван: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангах, өрийн дарамтад орохоос сэргийлэх, тэтгэврийн зээлдэгчийн санхүүгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, улмаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих зорилгоор 2023 оноос тэтгэврийн зээлд чиглэсэн шат дараатай бодлогын зохицуулалтыг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Мөнгөний бодлогын хороо 2025 оны 3 дугаар сарын хурлаар тэтгэврийн зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэгдэл нь амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулах шийдвэрийг гаргаж байсан. Мөнгөний бодлогын хорооны 25 оны 6 сарын хурлаар өмнөх зохицуулалтыг өөрчилж банкнаас шинээр олгох тэтгэвэр тэтгэмжийн орлого нь, орлого барьцаалсан зээл болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг өөрчлөхөд өр, орлогын харьцааг 50 хувиас хэтрүүлэхгүй байхаар буюу бусад хэрэглээний зээлтэй ижил зохицуулалттай байхаар шийдвэрлэсэн.

Энэхүү зохицуулалт нь тэтгэврийн зээлтэй иргэд тэтгэврийн орлогынхоо 50-аас ихгүй хувийг зээлийн төлбөрт зарцуулах, 50-аас багагүй хувийг зээлдэгчийн гар дээр өөрт нь үлдээх зохицуулалт юм. Өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувиар тогтоосноор өмнөх зохицуулалт буюу амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулах шийдвэртэй харьцуулахад бага тэтгэвэр авагчийн зээл авах боломж нэмэгдсэн.

Тус арга хэмжээг мөрдүүлж эхэлсэн 2025 оны 6 сарын 16-ны өдрийн өдрөөс өмнө авсан тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч нарын хувьд Монголбанкнаас ямар нэгэн зохицуулалт хийгээгүй болно. Өөрөөр хэлбэл, банкнууд өөрсдийн зээлийн бодлого, зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд нэг талаас зээлдэгчийн өрийн дарамт, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг, нөгөө талаас зээлдэгчийн санхүүгийн хэрэгцээг харгалзан нэмэлтээр зээл олгох боломжтой юм.

Харин банкнаас олгох тэтгэврийн зээлийн хугацааны хувьд Монголбанкны зүгээс ямар нэгэн зохицуулалт, хязгаарлалт хийгээгүй болно.

Энэхүү бодлогын шийдвэрийг гаргаагүй тохиолдолд тэтгэвэр авагч иргэд өөрийн амьжиргаа, суурь хэрэглээг хангах сар бүрийн орлогоо зээлийн өр төлбөрт

зарцуулах нь эдгээр иргэдийн эдийн засаг, нийгмийн баталгаа алдагдах, ядууралд хүргэх бодит эрсдэл тулгарч байна.

Тухайлбал, олон улсад тэтгэврийн зээл нь нийтлэг бус бөгөөд манай улсад тус зээлийн дийлэнх нь ахмадуудын сарын орлогыг бүхлээр нь барьцаалж амьжиргаанд нь зарцуулах орлого үлдээхгүй байгаа нь өндөр настай иргэдийн амьдралд хүндээр тусаж байна.

Тэтгэврийн зээлтэй иргэд сард дунджаар тэтгэврийн орлогынхоо 84 хувийг зээлийн төлбөрт суутгуулж дөнгөж 16 хувийг л амьжиргаандаа зарцуулж байна. 25 оны 4 дүгээр сарын байдлаар Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг 515.6 мянган иргэний 281.2 мянга нь тэтгэврийн зээлтэй байна. Мөн тэтгэврийн зээлдэгчдийн 87.7 хувь буюу 246.6 мянган иргэдийн хувьд зээлээ төлсний дараах үлдэж буй орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшинг хангахгүй байна. Суурь амьжиргааны зардлаа хангахын тулд тэтгэврийн зээлтэй иргэд зээлийн гэрээг сунган нэмж зээл аван зээлээс зээлийн хооронд явсаар байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн зээлдэгчдийн 82.3 хувь нь зээлээ төлж дуусахаас өмнө хамгийн багадаа 1 удаа сунгалт хийж, нэмэлтээр зээл авч байгаа нь үүний нотолгоо болж байна. Нөгөөтээгүүр банкны салбарын чанаргүй ангилалтай тэтгэврийн зээлийн үлдэгдэл дүн 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 11.7 тэрбум төгрөгт хүрч, мөн оны өмнөх үеэс 116 хувиар огцом өссөн байна. Фридрих Эбертийн сангаас 2022 онд хийсэн ахмад настны нийгэм, улс төрийн оролцоо судалгаагаар тэтгэврийн зээлтэй ахмад настнуудын дийлэнх нь хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, гэр бүлийн гишүүдийн автомашин худалдаж авахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр бусдын хэрэгцээнд зориулдаг болох нь тогтоогдсон.

Ийнхүү тэтгэвэр авагч иргэд өөрийн амьжиргаа хэрэглээг хангах, сар бүрийн орлогоо зээлийн төлбөрт зарцуулж байгаа нь эдгээр иргэдийн эдийн засаг, нийгмийн баталгаа алдагдах, санхүүгийн хараат байдал, өрийн дарамтад өртөх үндсэн шалтгаан болж байна.

Тэтгэврийн зээл нь эргээд дийлэнх зээлдэгчийн амьжиргааны баталгаажих доод түвшнийг хангахгүй болж буй зохистой хандлага, улмаар зээл авсны санхүүгийн түр хугацааны хэрэгцээг хангахаас илүүтэйгээр өрийн сүлжээнд оруулж буй системийн гажуудлыг засах тохиромжтой арга замыг ашиглах нь чухал ач холбогдолтой байна.

Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн системд учирч буй эрсдэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналыг үндэслэн өндөр настай иргэдийн өрийн дарамтыг бууруулж, амьжиргааг дэмжих зорилгоор тэтгэврийн зээлийг бусад төрлийн хэрэглээний зээлтэй ижил зохицуулалттай байхаар шийдвэр гаргасан.

Л.Энхнасан: Баярлалаа. Монголбанкны танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байвал нэрээ хэлнэ үү.

Асуулт Идэрбат гишүүн асуултаа асууна.

Ц.Идэрбат: Бид ч айхтар их гийгүүлээд байхаар ч юм, шийдвэр гаргах гээгүй юм даа. Энэ ахмадууд энэ Монголбанк тэтгэврийн зээлийн энэ бүтээгдэхүүн арилжааны банкнуудад гарч эхэлсэн цагаас хойш л бид ийм байдал руу орчихсон. Үүнийгээ 7, 8 удаа огцом огцом өөрчлөөд байдаг. Гэтэл ахмадууд яг энэ нөхцөлд нь тааруулаад амьдралын хэв маягаа аваад явчихдаг ингээд бүр сургачихсан. Энэ огцом өөрчлөлтүүд чинь л олон ахмадуудын амьдралд их төвөгтэй байдал үүсгээд байгаа юм билээ.

Тийм учраас ер нь Монголбанк 2, 3 янзын тайлбар хэлээд байгаад би гайхаж байгаа юм. Нэг болохоор Засгийн газраас өгсөн саналын дагуу ингэж байгаа гэж яриад байгаа юм. Нэг болохоор санхүүгийн байдлынх зээлийн хэрэглээний зээлээ хасмаар байна, дэндүү их болоод байна гэдэг ийм зүйлүүд яриад байгаа юм. Яг аль нь юм бэ гэдгийг би бас нэгдүгээрт асуумаар санагдаад байдаг юм.

Хэрэглээний зээл үнэхээр өндөр болоод, инфляц өсөөд, валютын нөөцөд нөлөөлөөд байна гэвэл энэ Монголд 500 гаруй банк бус санхүүгийн байгууллагууд бараг 5, 6 их наяд буюу ДНБ-ий 7, 8 хувьтай тэнцэх хэмжээний хэрэглээний зээл гаргаад л байгаа байхгүй юу. Та нар тэр дээр ямар ч юм хийхгүйгээр зөвхөн тэтгэврийн зээл гэдэг юмыг барьж аваад хийгээд байгаа чинь хүн харахад нөгөө монголчилж хэлбэл нөгөө дийлсэн дэлдийснээ гэдэг чинь болоод байгаа байхгүй юу. Монголбанк тэр битгий хэл та нар ББСБ-д хүртэл зээл аваачиж өгдөг. Энэ чинь дэндүү шударга бус байгаад байгаа юм.

Би эндээс 2, 3 юм асуух гээд байгаа юм. Хэрэглээний зээл гэж үзэж байгаа бол хэрэглээний зээл чинь 30 сар. Тэгэхээр бас л хэрэглээний зээлийн ангилалд оруулж байгаа юм шиг боловчиг яг тэр нь гүйцэж өгөхгүй бас байгаа юм. Нөгөө талдаа энэ 500 гаруй мянган ахмадаас 280-ыг нь л авч байгаа. 280 мянган ахмадуудыг зөвхөн 1 хайрцагт аваачиж хийчхэж бас боломгүй байна шүү дээ. Амьдрал баян байна. Монгол хүний дундаж наслалт нэмэгдэж байна. 55-тай, 60-тай, 65-тай хүмүүс өнөөдөр энд тэтгэвэр бүгд хүрээд байгаа юм байхгүй шүү дээ. Жоохон үүгээрээ эргэлдүүлж бизнес хийдэг л юм байна лээ л дээ. Тэгэхээр үнэхээр тэр 280 мянган хүнээс хэд нь бизнес хийгээд хэд нь машин авчихсан гэдэг судалгаа яг та нар дээр байна уу? Та нар бас 2 өөр эх үүсвэр ярьдаг. Би та нарын олон юмыг сонсоод байгаа. Нэг болохоор импортын сан ярьдаг, нэг болохоор Дэлхийн банк ярьдаг. Яг алийг нь юм, хэзээ хийсэн, ямар судалгаа байгаа юм та нарт гэдгийг би тодруулж асууя гэж ингэж бодож байгаа юм.

Уян хатан байж болдоггүй юм уу? Энхтайван Ерөнхийлөгч танаас 2, 3-хан ах хүн өнөөдөр тэтгэвэрт гарчихсан бизнесийн зээл хийе гэхээр чи тэтгэврийн хүн гээд өгдөггүй цэргийнхэнд. Яг тийм нөхцөл байдлыг эд нар уян хатан болгоод хэнд нь хэдэн хувь өгөх вэ, яах вэ ийх вэ гэдгийг нь зохицуулаад ингэхгүй бол 4 сар ахмадуудыг бухимдууллаа. 10 хоног гадаа суулгалаа шүү дээ.

Л.Энхнасан: Энхтайван Ерөнхийлөгч хариулна уу? 5 дугаар микрофон.

Г.Энхтайван: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Төв банк мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороо хараат бусаар хэлэлцэж гаргадаг. 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төв банканд ирүүлсэн бичгээр өр, орлогын харьцааг 50 хувиар тогтоож өгөөч ээ гэсэн албан бичиг ирсэн. Түүний өмнө 2024, 2025 оны 3 дугаар сард хуралдсан хурлаар энэ амьжиргааны баталгаажих түвшинд үлдэх

орлогыг нь үлдээгээч ээ гэдэг тийм зохицуулалт ирсэн. Яг Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналаар шийдвэрлэсэн. Нэгд нь.

Хоёрт нь Төв банкнаас хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого явуулж байгаа. Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 50 хувь болгож байгаа нь угаасаа л хэрэглээний зээлийн өсөлт өндөр байгааг хязгаарлах бодлогын үндсэн арга хэмжээ. Тэгэхээр гишүүн бас энэ дээр хэрэглээний зээлийг яг төв банк хязгаарлахгүй байна гэж үзэж байгаа нь дан ганц тэтгэврийн зээлийг хязгаарлаад байгаа юм ерөөсөө биш. Бүх хэрэглээний зээл дээр энэ ижил тэгш мөрдөгдөж байгаа. Тэр 30 сарын хугацаатай хэрэглээний зээл байна, тэтгэврийн зээл чинь 30 сар хүрэхгүй байна гээд байгаа тэр төв банк энэ дээр ямар ч хугацааны хязгаарлалт ерөөсөө тавиагүй. Аль ч банкнаас очоод тэтгэврийн зээл авч байгаа хүн тухайн өөрийн нийгмийн байдал, нөхцөл байдлаасаа шалтгаалаад хэдий хэмжээний зээл авах нь тухайн хүнээс өөрөөс нь хамаарч байгаа. Төв банкин дээр хугацааг нь нээлттэй орхисон байгаад байгаа.

Ер нь цаашдаа төв банкнаас энэ дээр хэрэглээний зээлийн ангиллаас энэ тэтгэврийн зээлийг гаргаад арилжааны банканд нь өөрт нь 100 хувь даатгаад, арилжааны банк нь өөрөө өөрийнхөө бизнес модель, өөрийнхөө бодлого, үйл ажиллагаанд тохирсон зээлдэгчийг тухайн зээлдэгч тус бүрд нь гаргаад явдаг тэр систем рүү бас орох боломжтой гэж үзэж байгаа юм.

Фридрих Эбертийн сангийн судалгаа байгаа 2022 онд хийсэн. Засгийн газрын захиалгаар хийсэн судалгаа. Энэ дээр нийт зээл авч байгаа хүмүүсийн 60.6 хувь нь зээлийн зарцуулалтыг өөртөө бус, үр хүүхэд бусдад зарцуулдаг, энэ нь дийлэнхдээ автомашин болон сургалтын төлбөр төлөхөд зарцуулагдаж байна гэсэн судалгаа гарсан байгаа. Энэ

Л.Энхнасан: Тодруулга Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Тэгвэл Засгийн газраас энэ зээлийн төлөлтийн хуваарийг 70:30 байдаг юм уу тийм бичиг бол та бүхэн тэрийг нь өөрчлөх бололцоо байгаа юу нэгдүгээрт?

Хоёрдугаарт, би хэрэглээний тэтгэврийн зээлийг та бүхэн хумих бодлогоо жоохон уян хатан явуулаач. Тодорхой хугацаатай хүн болгонд ойлгомжтойгоор. Тэтгэврийн зээл гэдэг юм ингээд ингээд багассаар байгаад ер нь тэдэн жилийн дараа гэхэд байхгүй болох юм биш үү. Нэгд.

Хоёрт, энэ тэр цэргийн тэтгэврийнхэн ч байдаг юм уу эд нарыг бодож болохгүй юу?

Гуравт, хэрэглээний зээлийг багасгах бодлого баримталлаа гээд та хэд янз янзын арга хэмжээ аваад байдаг 500 гаруй ББСБ-аар 5 их наяд төгрөгийн хэрэглээний зээл гарчхаад байна шүү дээ. Та нарын наад явуулж байгаа бодлого чинь үр дүнд хүрэхгүй тэр хоморгод нь наад тэтгэврийнхэн чинь хохироод байгаа ийм л дүр зураг байгаа. ББСБ-тай холбоотой янз янзын ийм арга хэмжээ авсан юм байгаа юу?

Л.Энхнасан: 5 дугаар микрофон Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу.

Г.Энхтайван: ББСБ-аар дамжаад 5 их наяд төгрөгийн зээл олгочихлоо гэж байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо хуралдаад өр, орлогын харьцааг өөрчилсний дараа СЗХ яг дагаж хуралдаад арилжааны банкнаас гадна ББСБ-аар олгогдож байгаа нийт зээлийн өр, орлогын харьцааг 60:40 болгоод бас чангаруулсан байгаад байгаа. Тэгэхээр энэ бодлогын хувьд нийцтэй байгаа. Төв банкнаас нийт арилжааны банкнуудад гарсан нийт зээлийн, хэрэглээний зээлийн хэмжээ нийт зээлийн бараг 55 гаруй хувьтай байгаа шүү дээ. Тэгэхээр нийт зээл маань өөрөө 30 хэдэн их наяд төгрөгтэй байгаа. Тэгэхээр арилжааны банкаар олгогдож байгаа тэтгэврийн, үгүй ээ хэрэглээний зээлийн хэмжээ банк бустай харьцуулахад 3, 4 дахин их. Тэгэхээр мэдээж төв банк ч тэр, СЗХ ч тэр бодлого, үйл ажиллагааг нийцтэй байлгах хүрээнд үйл ажиллагаа, шийдвэрүүдээ дундаа ярилцаад явдаг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ.

Уян хатан шийдвэрлэх өр нь боломжтой гэж бид хэдийн зүгээс үзэж байгаа. Тэр хүрээндээ ч гэсэн энэ хэрэглээний зээл.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя. 5 дугаар микрофон.

Г.Энхтайван: Хэрэглээний зээлийн ангиллаас энэ тэтгэврийн зээлтэй холбоотой зохицуулалтыг гаргаад арилжааны банк нь дан ганц өөрсдөө өөрийнхөө бодлого, үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөө дээрээ үндэслээд тухайн зээлдэгч тус бүр дээр өөрсдийн нөхцөлөөр зээлээ олгодог больё. Энэ дээр Төв банк ямар энэ өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалт тавьдгаа больё. Энэ дээр арилжааны банкны өөрсдийн 100 хувийн шийдвэр байх боломжтой л гэж үзэж байна.

Л.Энхнасан: Энэ дээр бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулах уу энэ ямар? Аубакир сайд хариулна.

Т.Аубакир: Энэ яах арга байхгүй бас ахмадуудын дунд хэсэг ахмадуудын дунд асуудал болоод байгаа юм л даа. Монголбанкт бид нар бас удаа дараа ярьсан ахмадуудын зээлийг энэ 50:50 өр, орлогын харьцаатай байлгах нь бас зарим талаараа зарим ахмадуудын авах ёстой байсан зээл амьдралаа залгуулах энэ эх үүсвэр дээр нь садаа болоод байна гэсэн саналуудаа удаа дараа тавьж байгаа. Гэхдээ Монголбанк хараат бусаар л шийдвэр гаргах байгууллага шүү дээ. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд ч гэсэн бид нар бол Монголбанканд анхааруулсаар ирсэн. Хэрэглээний зээлүүд чинь хэрээс хэтэрч байгаа юм биш үү? Залуучууд, бусад гэр бүлүүд хэтэрхий хэрэглээ рүүгээ чиглэсэн зээл яг энэ Монгол Улсын энэ зээлийн энэ хүрээнд хөрөнгө оруулалтын зээл гэхээсээ илүү хэрэглээний зээл хавтгайраад байгаа юм биш үү гэдэг асуудлыг хүртэл тавьдаг байсан л даа. Манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас судалгаа хийгээд Фридрих Эбертийн сангийн хийсэн судалгаан дээр үндэслээд ахмадууд маань зээл.../минут дуусав./

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя Аубакир сайд.

Т.Аубакир: Удаа дараагийн хийсэн судалгааны дүнгээр ахмадуудын авч байгаа зээл нь яг өөрийнх нь нийгмийн энэ аюулгүй байдал, нийгэм хангамжийнхаа талдаа үйлчлэхгүй байна гэсэн судалгааны дүн удаа дараа гарч байгаа юм Идэрбат гишүүн ээ. Яг судалгаа тоо харахад бол. Манай яам бол Нийгэм хамгааллын яамны хүрээнд ахмадуудынхаа амьдралын аюулгүй байдлыг бас бодох ёстой. Яг бүтэн насаараа хөдөлмөрлөж явж байгаад л тэтгэвэрт гараад

эмгэн, өвгөн 2 сайхан амьдаръя даа гэж байтал хажуугаар нь хүүхдүүд нь зээл авч би ингэж болохоо байлаа гээд. Гэтэл яг авч байгаа зүйлүүд нь зөвхөн хэрэглээнд, гар утасны байдаг ч юм уу, машин тэрэг авах байдаг ч юм уу гэсэн судалгааны дүн гарч байгаа шүү. Манай ахмадууд маань бас энийг бас зөвөөр ойлгох хэрэгтэй.

Гэхдээ Монголбанкт ярьж байгаад Монголбанкны нөхдүүд маань бас хараат бусаар өөрсдөө шийдвэрээ гаргана. Энэ хэрэглээний зээлээс ахмадын зээлийг гаргах асуудлыг ярьж байгаа. Манай яамны байр суурь бол ахмадуудынхаа нийгмийн аюулгүй байдлыг бас бодож байгаа шүү гэдгээ бас албан ёсоор хэлье.

Л.Энхнасан: Идэрбат гишүүн тодруулга.

Ц.Идэрбат: Жоохон амьдрал руу ороо. Тийм зүгээр нэг судалгаа яриад суугаад байж болохгүй. Амьдралын энэ чанар юмнууд чинь өөр болчихоод байна шүү дээ. Тэтгэврээрээ амьдардаг хүн байхгүй. Тэтгэврээ харин юм болгочих юм сан гэж ядаад байгаа байхгүй юу. Жижиг бизнес хийчих юм сан, наймаа хийчих юм сан гээд байгаа юм. Тэгэхээр бас энэ талаа бас нэлээн сайн анхаарах, бодох хэрэгтэй. Монголбанкнаас уян хатан байлгая гэдэг. Би бол тэтгэврийн зээлийг тодорхой хугацааны дараа байхгүй болгох нь зүйтэй. Гэхдээ шууд 1 өдөр, 1 өдөр, 1 өдөр шийдвэр гаргаад баймааргүй байна. Тодорхой хугацааны дараа тэтгэвэрт гарахад би тэтгэврийн зээл гэдэг юм огт байхгүй тийм ойлголттой хүн болоод тэтгэвэртээ гарвал хамаагүй хэн хэндээ амар байхгүй юу. Тэгэхгүй бид нар тэтгэврийн зээл гэдэг юмыг нутагшуулчихаад гэнэт гэнэт огцом шийдвэр гаргаад байгаад чинь л энэ. Энд нь тааруулаад амьдралын.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа. Батшугар гишүүн асуултаа асууна уу.

Э.Батшугар: Баярлалаа. 5 сарын 26-нд Зээлийн мэдээллийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан. Хуулийн хэрэгжилт нь байдаггүй. Маш олон иргэд асуугаад байгаа юм. Нөгөө хар жагсаалтын зүйл чинь байхгүй яасан бэ гээд. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хар жагсаалтын зүйлийг алга болгосон. Онооны систем рүү оруулсан. Энэ бол цоо шинэ банк, санхүүгийн системд шинэ шинэчлэл хийсэн юм. Яг бид нарын сайн мэддэг Солонгос, Америк, Япон улстай адилхан тийм онооны систем рүү оруулсан. Үр дүн нь маш эерэг гарах ёстой юм.

Нэгдүгээрт зээлийн хүү буурах суурь нөхцөлийг нь бүрдүүлж байгаа юм. 70 мянган иргэний хар жагсаалтаас гаргана, мөн цаашлаад барьцаа хөрөнгийн шаардлага нь өөрөө буурна гэсэн тийм том эерэг эерэг өөрчлөлтүүд гаргах бололцоог нээсэн юм. Тэгсэн чинь ерөөсөө хууль нь хэрэгждэггүй ээ. Монголбанк журам батлах ёстой тэр журмын хэрэгжилт нь байхгүй байгаад байна. Хэзээ энэ журмаа батлах вэ гэдэг асуултыг Монголбанкнаас асууя. Маш их хэмжээний, маш их том хүлээлт үүсчхээд байгаа юм ард иргэдэд. 70 мянган иргэн шүү дээ. Цаашлаад яривал бараг 1.6 сая иргэний тийм системийн өөрчлөлт гарах гээд байгаа юм.

Хоёрт нь бас энэ тэтгэврийн зээлийн талаар ярьж байна л даа. Миний байр суурь энэ маш тодорхой байдаг юм. Тэтгэврийн зээл бол хэрэглээний зээл биш ээ. Илүү бага хүүтэй байх ёстой. Яагаад гэвэл энэ зээлийн эх үүсвэр нь маш тодорхой сарын эхээр улсаас олгодог Нийгмийн даатгалын сангаас олгодог мөнгө. Тэгэхээр эрсдэлгүй мөнгө гэж ойлгож болох юм нэг утгаараа. Эрсдэл өөрөө хүүг илэрхийлдэг. Тэгэхээр эрсдэлгүй зээл чинь өөрөө бага хүүтэй байх ёстой гэсэн

концепц яваад байгаа юм. Тэгэхээр үүн дээр ч гэсэн бас маш олон гишүүд эмзэг хандаж байгаа юм. Монголбанк ч гэсэн яг хэрэглээний зээлийн ангиллаас гаргаад илүү эрсдэл багатай зээл, нэг ёсны хүү нь прайм рэйт/prime rate/ гэж ярьдаг шүү дээ олон улсын жишгээр. Энэ жишиг рүү оруулах бололцоо байгаа биз дээ, байгаа юу гэж асууя.

Л.Энхнасан: 5 дугаар микрофон Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу.

Г.Энхтайван: Батшугар гишүүний асуултад хариулъя. Тантай санал нэг байна. Өнгөрсөн энэ удаагийн хаврын чуулганаар Зээлийн мэдээллийн сангийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан. Зээлийн мэдээллийн сангийн хууль батлагдаад төв банкнаас бас холбогдох журмыг хийж гүйцэтгэхээр бид бүхэн ажиллаж байна. Мэдээж хуулийн хугацаандаа бид бүхэн хийнэ. Арилжааны банкнуудаас болон банкны холбоо мөн энэ зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч 2 компаниас бид бүхэн бол саналыг авахаар явуулсан байгаад байгаа. Энэхүү саналуудыг бүрэн гүйцэд ирсний дараа бид бүхэн бас журмын төслийг нэгтгээд тун ойрын хугацаанд батална. Танд маш ойрын хугацаанд батална гэж хэлье. Таны санаачилсан энэ хууль нь бас эргээд иргэд, аж ахуйн нэгжүүд, муу зээлийн түүхтэй иргэдийн санхүүгийн чадавхыг сайжруулах, эргээд зээлийн олдоц, хүртээмж нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээ авахад бас маш чухал бодлогын арга хэмжээ болсон гэдгийг Төв банк ойлгож байгаа. Бид бүхэн энэ дээр анхаарал хандуулж ажиллая.

Тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр мэдээж прайм рэйт/prime rate/ байж болно. Та бас бодлогын аягүй чухал асуудлыг хөндлөө. Энэ дээр төв банк бас адилхан байр суурьтай байгаа. Гэхдээ ер нь тэтгэврийн зээл маань гэдэг маань өөрөө эх үүсвэрийн зардалтай байгаад байгаа. Арилжааны банкнаас эх үүсвэр буюу иргэд, аж ахуйн нэгжүүдээс хадгаламж аваад хадгаламжийнхаа хүү ямар өртөгтэй байна түүнтэй уялдуулсан хүү бол тэтгэврийн зээлд тооцогдож байгаа. Гэхдээ мэдээж эрсдэлийн хувьд хамгийн бага учраас прайм рэйт/prime rate/-ээр тогтоох бүрэн боломжтой гэж үзэж байна. Тантай санал нэг байна.

Л.Энхнасан: Тодруулга Батшугар гишүүн.

Э.Батшугар: Баярлалаа. Энхтайван Дэд ерөнхийлөгч өө та тэгвэл яг баримжаагаар хэзээ энэ журам нь батлагдах вэ гээд хэлээч. Хэлж өгөх боломжтой байна уу? Яагаад гэвэл маш их хүлээлт үүсчхээд байн нийгэмд. Энэ бол 70 мянган хар жагсаалтад орчихсон иргэд байна. Дээрээс нь нэмээд 1.6 сая иргэн энэ зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй байгаа юм. Тэгэхээр яг хэзээ юм бэ? Яг баримжаа ядаж баримжаа өгөөч ээ.

Л.Энхнасан: 5 дугаар микрофон, яг хугацааг нь хэлж өгнө шүү.

Г.Энхтайван: Захиргааны ерөнхий хуулиар бид бүхэн энэ энийг батлахад олон нийтээс хэлэлцүүлэг хийсэн байх ёстой. 1 сарын хугацаанд энэ чинь журамд гараад олон нийтэд тавьсан байх ёстой. Энэ хугацаагаа тооцоод үзэхээр бид бүхэн 9 сарын 1 гэхэд бүрэн шийдвэрлэнэ ээ гэж тооцож байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Баатархүү гишүүн асуултаа асууна уу.

Ц.Баатархүү: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Нэг зүйлийг бид нар сайн ойлгох хэрэгтэй. Энэ тэтгэвэр гэж юу юм бэ гэдэг философийг бодох хэрэгтэй. Ахмадууд олон жил ажиллаж хөдөлмөрлөөд Нийгмийн даатгалын санд шимтгэл

төлсөн тэр төлбөрөөсөө хувь хүртэж байгаа хэлбэр шүү дээ. Тэр төлбөрөөсөө хувь хүртэж байгаа хэлбэр. Тэгээд тэр тэтгэвэр нь тодорхой байдаг учраас, орлого нь найдвартай байдаг учраас энийг хэрэглээний зээлийн ангиллаас гаргаж болно. Хэрэглээний зээлийн ангиллаас хэн гаргах вэ гэхээр Монголбанк гаргана. Ингэх юм бол хүү тодорхой хэмжээгээр зээлийн хүү буурах боломж бүрдэж байгаа юм. Ийм боломж байна гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт Монголбанкны хариулж байгаа хандлагад асуудал байна л даа. 2 судалгаа дурдаад байна л даа. Хараат бус байгууллага шийдвэр гаргахын тулд хариуцлагатай байх хэрэгтэй. Хамгийн түрүүнд энэ тэтгэврийн орлогыг барьцаалж зээл авч байгаа ахмадуудын саналыг авах ёстой байсан. Энэ саналыг аваагүйгээсээ болоод нэр бүхий байгууллагын судалгаа, яамны бичиг 2 дээр үндэслээд нэг бол шийдвэр гаргасан юм шиг, нэг бол хараат бусаар шийдвэр гаргасан юм шиг ийм ойлгомжгүй байдал үүсгээд өнөөдөр ахмадуудыг 2 тал болгож хуваагаад байна л даа. Тэгэхээр Монголбанк цаашдаа шийдвэр гаргахдаа энэ шийдвэрт хамгийн түрүүнд өртөх хүмүүсийг оролцуулж байх ёстой шүү дээ. Тийм учраас Монголбанк энэ тал дээрээ хариуцлагатай байгаасай гэж бод.

Ер нь энэ Монголын эдийн засгийн суурь асуудлыг өнөөдөр энд хөндөж байгаа. Өнөөдөр хөдөлмөрийн орлогын хэдэн хувьд нь тэтгэвэр байгаа юм бэ гэдгийг бодох хэрэгтэй. Дундаж тэтгэвэр хөдөлмөрийн орлогын 30-40 хувьд нь байгаа. Бусад улс орон энийг 60-80 хувьтай байлгаж байгаа. Насаараа ажил хөдөлмөр хийсэн хүн бол тэтгэврийн насанд хүрээд цалинтайгаа ойролцоо хэмжээний тэтгэвэр авдаг. Ийм болох ёстой. Тэтгэврийн нэрийн данс гэдэг өгөөжөө өгөх хэрэгтэй байдаг.

Өөрөөр хэлэх юм бол жил болгон тэтгэвэр хуримтлуулсныхаа төлөө өгөөж нь тэр хүний нэрийн данс дээр хуримтлагдаад нэмэгдэж байх ёстой. Энэ асуудал дээр Нийгмийн даатгалын ерөнхий газар яам 2 анхаарч, тэтгэврийнхээ энэ реформыг хурдан хийх хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхгүй болохоор бид нар зөвхөн зээл тойрч яриад байгаа байхгүй юу. Тэтгэвэр өөрөө хангалттай хэмжээнд очих хэрэгтэй. Суурь эдийн засаг сайжрах хэрэгтэй. Монголбанк энэ санхүүгийн зах зээл чинь хэтэрхий их банкнуудаас, банк бусуудаас хамааралтай ийм эдийн засгийн тогтолцоо бий болгочоод байна шүү дээ. Энэ дээрээ Монголбанк, мөнгөний бодлого, энэ санхүүгийн зах зээл дээр байгаа энэ СЗХ энэ тэр бодлогоо зөв болгох хэрэгтэй шүү дээ. Бодлого чинь буруу шийдвэр гаргаж байгаа алхам чинь 2, 3-хан судалгааны дүн үндэслээд шийдвэр гаргачихдаг. Тэгээд өнөөдөр талцуулж байна л даа. Тийм учраас энэ шийдвэрийг эргэж харах хэрэгтэй гэж бод.../минут дуусав./

Л.Энхнасан: Монголбанкнаас хариулах уу? Энхтайван дарга, Дэд дарга 5 дугаар микрофон. Судалгааг асууж байна тийм.

Г.Энхтайван: Төв банк түрүүний бас бас урьд нь би бас хэлсэн төв банк шийдвэрийг хараат бусаар гаргадаг. Мөнгөний бодлогын хороо маш олон нөхцөл, зүйлсийг судалж тунгаасны үндсэн дээр хараат бусаар гаргадаг. Мөнгөний бодлогын хороо нь Төв банкнаас удирдлагуудаас гадна дийлэнх нь 6 хүний 4 нь хараат бусаар буюу гаднаас Мөнгөний бодлогын хороонд Улсын Их Хурлаас томилогдсон гишүүд энэ шийдвэрийг гаргадаг.

Судалгааны хувьд Гэр бүл, нийгмийн хамгааллын яам 2 удаа албан бичиг ирүүлсэн. 2 удаа албан бичиг ирүүлснийг бид хэд харгалзаж үзсэн. Түүнээс биш яг

100 хувь зөвхөн яамны хүслээр шийдвэрийг гаргадаггүй. Хараат бусаар гаргадаг. Яамны ирүүлсэн албан бичиг дотор яам өөрөө захиалж хийлгэсэн судалгаануудаа хавсарсан байсан. Тэдгээрийг бид бүхэн бас харгалзаж үздэг. Янз янзын л судалгаа байдаг. Бид бүхэн Худалдаа аж үйлдвэрийн яамтай хамтраад ч гэсэн энэхүү судалгааг урьд нь хийлгэж байсан. Ер нь үр дүн адилхан л гардаг. Ер нь тантай ер нь санал нэг байна. Тэтгэврийн зээлийг уян хатан болгох хэрэгтэй, хүүг нь бууруулах хэрэгтэй гэдэг. Хүү бууруулах дээр нэг зүйл нэмээд хэлчихье. Гэр бүл, нийгмийн хамгааллын яам энэ Нийгмийн даатгалын ерөнхий газар арилжааны банкнууд хамтраад гэрээ байгуулаад энэ Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкин дээр байршуулаад тухайн эх үүсвэрээрээ тэтгэврийн зээлийг олгоод явах юм бол хүү буурна. Энэ дээр төв банк бодлогын хувьд дэмжинэ.

Л.Энхнасан: Тодруулга Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Энэ нэгдүгээрт бид нар магадгүй энэ Байнгын хорооны мэдээлэл иргэд олон түмэнд хүрнэ. Бас Дэд ерөнхийлөгчийн хувьд та бас маш хариуцлагатай хариулт, мэдэгдлүүдийг хийх ёстой. Өнөөдөр ярьж байгаа энэ асуудлыг магадгүй маргааш ахмадууд маань үзээд өндөр хүлээлт үүсгэх, эсвэл бид нарын энэ хуралдааны байдалд ямар нэгэн байдлаар хэт сэтгэл дундуур байх ийм магадлал үүснэ л дээ. Тэгэхээр тэтгэвэр гэж юу вэ, тэтгэврийн реформ гэж юу вэ, тэтгэврийн реформ хийхийн тулд яам ямар бодлого оруулж ирэх юм, яам ямар бодлого оруулж ирэх юм? Нэрийн дансны өгөөжийг яаж сайжруулах юм, ахмадын нэрийн дансны өгөөж жилийн хэдэн хувь байх юм, ямар орны загвараар бид явах юм бэ гэдгээ маш сайн том зургаар нь хараад энэ тэтгэврийн зээл гэдэг бүтээгдэхүүний орлого найдвартай учраас хүүг нь.../минут дуусав./

Л.Энхнасан: Үг хэлэх бас цаг байгаа шүү. Тэгэхлээр анхаарна уу. Илүү үг хэллээ гэж бодлоо. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвадоржийг эрэн сурвалжлах хэмжээнд очсон байна. Лхагвасүрэнг. Нэрийг нь хүртэл мартчихсан байна шүү дээ. Бүх юман дээр байхгүй. Энэ хүн яг Монгол Улсад байгаа юу? Би энэ хүнийг асуумаар байгаа юм. Улсын Их Хурлын чуулган дээр ч байхгүй, Байнгын хорооны хурал дээр ч байхгүй. Энэ тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр яагаад оролцоод байгаагаа ч хэлж тайлбарлаж байгаа юм байхгүй ний нуугүй хэлэхэд. Тэтгэвэр гэдэг чинь тухайн иргэдийн эдийн засаг, нийгмийн хамгааллын баталгааг л хангаж байгаа нэг талын зүйл шүү дээ. Монголбанк ажилгүй болчихсон юм уу, та нар яагаад энэ асуудалд орооцолдоод байгаа юм. Би энийг чинь ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Хийх ажилгүй байгаа юм уу? Наад валют, ханш, инфляц, бодлогын хүү гээд та нарт их л олон ажлууд баймаар юм. Хэдэн муу хөгшчүүдтэй л зууралдаад байх юм. Би энийг чинь ойлгохгүй байгаа юм.

Хоёрдугаарт нэг юмыг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Одоо энд байна. Сая Дэд ерөнхийлөгч бас хэллээ л дээ. Энхтайван Дэд Ерөнхийлөгч. Орон тооны хараат бус орон тооны бус гишүүд дээр ингэдэг ээ гээд. Ардчилсан намын Пүрэвдорж гишүүн ахмадын тэтгэврийн зээлээр байнгын улс төр хийж байгаа. 50:50 энийг өөрчлөхгүй бол би ахмадуудтайгаа жагсана аа гээд мэдэгдэж байгаа. Гэтэл энэ хүний зөвлөхөөр ажиллаж байгаа Даваадорж гэдэг хүн орон тооны бус гишүүн болоод Монголбанкны дотор байж байгаа. Одоо таны саяын хэлсэн орон тооны бус гишүүдийн хараат бусаар гаргасан шийдвэрийн дагуу Монголбанк

тэтгэврийн зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг бусад хэрэглээний зээлийн адилаар 50 хувиар тогтоохоор шийдвэрлэсэн гэж ярьж байгаа. Үгүй ээ тэр Пүрэвдоржийн өөрийнх нь албан ёсны зөвлөх нь энэ дотор байгаа юм байна лээ шүү дээ. Монголбанк улс төрчдийн зөвлөхүүдийг энэ дотроо оруулаад цаашдаа яваад байх ёстой юм уу эсвэл нөгөө талдаа? Хариулт нь ойлгомжтой л байх л даа. Парламентаас та нар өөрсдөө томилоод явуулаа биз дээ гээд. Зүгээр л арилжааны банкных нь асуудалд үлдээчих л дээ. Та нар Монголбанк энэ Банкны тухай хуулиараа ч гэсэн хөндлөнгөөс яагаад оролцоод яваад байгаа юм. Хориотой биз дээ? Арилжааны банкнуудад тэр эрхийг нь нээж өгөөд л аливаа асуудал дээр нь хаалт хийхгүйгээр л орхичих л доо. Тэр банкнууд нь өөрөө өөрсдөө эрсдэлээ тооцоод л явдаг юм байгаа биз. Монголбанкнаас тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийг би тэтгэврийн зээл дээр аваад явна гэдэгт нь үүнийг хэлэхэд итгэхгүй байгаа. Та нар яах вэ дээ өөрсдөө банк бустай. Ханш дээрээс мөнгө олдог ийм л хүмүүс шүү дээ. Та нар энгийн ахмадуудын яаж амьдарч байгааг ч та нар мэдэхгүй шүү дээ. Мэдэхгүй юм чинь ийм шийдвэр гаргаж байгаа.

Л.Энхнасан: Монголбанкнаас Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу? 5 дугаар микрофон.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эдгээр өдрүүдэд төв банкны Ерөнхийлөгч гадаад улсад томилолттой ажиллаж байгаа. Тун ойрын хугацаанд буцаж ирнэ.

Тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр бид бүхэн мэдээж хараат бус Мөнгөний бодлогын хороо шийдвэрээ гаргасан. Түрүүн хэлсэн бид бүхэн шийдвэрийг гаргахдаа нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн тогтвортой байдал нэг талаасаа, нөгөө талаасаа хадгаламж эзэмшигчдийн хууль ёсны эрх ашиг, санхүүгийн хэрэглэгчийн хууль, ёсны эрх ашиг гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзаж үзэж шийдвэрээ гаргадаг. Хэрэглээний зээлийг бас тодорхой хэмжээнд хязгаарлахгүй бол энэ нь эргээд хөрөнгө оруулалтын зээл олдохгүй байх, зээлийн хүртээмж буурах, хэрэглээний зээлээр дамжиж гадаад импортын хэмжээ нэмэгдээд төлбөрийн тэнцэл дээр томоохон хэмжээний алдагдал учрах, үүнээс шалтгаалаад валютын ханшийн өсөлт гэх мэтчилэн маш олон нийгмийн сөрөг үр дагавруудыг үзүүлж байгаа учраас бид бүхэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү шийдвэрийг тухайн үедээ Мөнгөний бодлогын хороо хараат бусаар хуралдаад гаргасан. Тантай ер нь 100 хувь санал нэг байна. Төв банкны зүгээс хэрэглээний зээлийн ангиллаас тэтгэврийн зээлийг гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Арилжааны банкнууд өөрсдийн эх үүсвэрээрээ, өөрсдийн бодлого үйл ажиллагаагаараа зээлдэгч тус бүрд нь тохирсон зээлийн бүтээгдэхүүн гаргаад, өөрсдөө зээлээ шийдвэрлээд явах нь зүйтэй юм байна гэж Төв банк үзэж байна.

Л.Энхнасан: Тодруулга Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Энхтайван Дэд ерөнхийлөгч ийм зүйл хэлж байгаад баяртай байна. Та нар эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдалтай холбоотой асуудлыг хөндөж байх шиг байна. Төсвийн тодотголын сая хэлэлцэх эсэхийн асуудал дээр танай Лхагвасүрэн Ерөнхийлөгч чинь бас гадаадад томилолттой байсан шүү дээ. Ирээгүй байгаа юм уу? 2024 онд 2025 оны төсөв орж ирж байх цаг хугацаанд та нар эдийн засгийн төсвийн тогтвортой байдалтай холбоотой асуудлаараа ахмадуудын тэтгэврээс илүү анхаарахгүй яасан юм? Би энийг гайхаад байгаа юм. Хэдэн муу ахмадуудаар л оролдоод л. Төсвийн тогтвортой

байдал, инфляц, бодлогын хүү гээд л яриад байх юм. Үгүй ээ 24 онд яагаад 2 удаа төсөв баталсан юм, яагаад тодотгол орсон юм, яагаад одоо дахиад тодотгол орж байгаа юм? Би энийг чинь гайхаад байна. Энэ төсвийн тогтвортой байдалтай холбоотой асуудал танай.../минут дуусав./

Л.Энхнасан: Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу 5 дугаар микрофон.

Г.Энхтайван: Гишүүний асуултад тодруулъя. Төсвийн тодотголтой холбоотой асуудал дээр төв банкнаас миний хэсэг би ажлын хэсэгт орж ажилласан. Төсвийн тодотголоос хамааран нийгэм эдийн засагт үзүүлэх инфляц болон төлбөрийн тэнцэл, валютын ханштай холбоотой асуудлууд дээр бид бүхэн Засгийн газартай харилцаад явж байгаа. Засгийн газар Төв банк 2-ын хоорондын харилцааг нарийвчилсан хуулиар зохицуулсан байдаг. Төв банк Засгийн газарт зөвхөн зөвлөх үүрэгтэйгээр оролцож болно гэсэн. Төв банкны Ерөнхийлөгч Засгийн газрын хуралдаанд зөвхөн зөвлөх үүрэгтэйгээр оролцож болно гэсэн байдаг. Бусад хэлбэрээр Засгийн газартай аливаа хэлбэрээр харилцахыг хуулиар хориглодог. Төсвийг бол Засгийн газар өргөн барьж байгаа. Төв банкны зүгээс өөрсдийн төсөвтэй холбогдсон өөрсдийн танилцуулга болон тооцооллын ажлын хэсэгт нь хүргүүлсэн.

Л.Энхнасан: Тодотгол Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Би таныг Засгийн газартай яаж харилцдаг вэ гэж ерөөсөө яриагүй шүү дээ. Төсөв, төсвийн тодотголыг Засгийн газар баталдаггүй юм. Монгол Улсын парламент баталдаг юм. Улсын Их Хурал баталж байгаа юм. Би 24 онд төсөв 2 удаа орохдоо төсвийн тодотгол орж байгаа цаг хугацаанд та нар жишээлбэл бодлогын хүүгээ ирэх ондоо ямар байдалтай байх юм, инфляц нь яах юм, энэ асуудлууд дээрээ яагаад та нар тэтгэврээс илүү анхаарал хандуулаагүй юм бэ л гэж хэлж байгаа юм. Энэ бодлогын хүүтэй холбоотой асуудлууд инфляцтай холбоотой асуудлууд чинь төсөвтэй, төсвийн тодотгол дээр яригдахаасаа илүүтэй та бүхний хариулаад байгаа хэдэн муу ахмадуудын тэтгэврийн зээлтэй холбогдуулаад нөлөөллийг нь яриад байгаа учраас л би энийг яриад байгаа байхгүй юу. Энийг л би ярьж байна. Одоо та яриад байвал би бас яриад баймаар байна. Мэтгэлцвэл мэтгэлцье.

Л.Энхнасан: Гамаа гишүүн асуултаа асууна уу.

Д.Ганмаа: Оройн мэнд асуулт өмнөх гишүүдтэй давхардсан учраас их асуултаа больё. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэнд чиглэлээр нь бодох юм бол манай Монгол хүмүүс тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийнх нь нас 15 хувь нь л тэтгэвэр авах боломжтой болдог юм байна. Урт удаан насалж чаддаггүй. Манайх дэлхийн дунджаас дундаж наслалт манайх цөөнтэй. Ялангуяа эрэгтэй хүмүүсийн дундаж наслалт 10 насаар бага байдаг. Тэтгэвэртээ гарангуутаа ер нь ядуурлын түвшин рүү алхчихад аягүй ойрхон болдог. Тэгэхлээр нийгэм эдийн засгийн хувьд маш эмзэг бүлэг. Юу гэсэн үг вэ гэхээр Монгол хүмүүс, Монгол төр, Монгол энэ үйл ажиллагаагаа удирдах, зохион байгуулах бодлого хэрэгжүүлэх хүмүүс маань Монголчуудынхаа эрүүл мэндэд ч сайн анхаарч чадахгүй байна, тэтгэвэрт гарсан хойно эдгээр хүмүүсийнхээ ч гэсэн амьжиргааны түвшин, чанартай амьдрах, эрүүл амьдрах энэ боломжоор огт хангаж чадахгүй байгаа нь наад захын тоогоор харагдаж байгаа.

Тэгэхлээр энэ тоогоо харсан ч гэсэн хэдийгээр Монголбанкнаас гаргаж байгаа энэ бие даасан бодлогоор ч болсон, энэ тэтгэвэр, энэ тэтгэврийн зээл энийг аль болохоор юүзер фрэндли/user-friendly/гэж ярьдаг шүү дээ хүндээ ээлтэй ийм систем рүү аль болохоор шилжүүлж өгөөч. Ялангуяа энэ эрсдэл аягүй бага байдаг гэдэг прайм рэйт/prime rate/ гээд сая ярилаа шүү дээ жишээлбэл Америкт моргэж/mortgage/ ч юм уу, кредит картын пэймент/payment/ дээр яг тулгуурладаг тийм тийм байдлаар бууруулж, хүмүүстэй аягүй фрэндли/friendly/ авахад амархан эргэн төлөх боломжтой. Сая Монголбанкны тэр тайлангаас уншигдаж байхад сонсоход сэтгэл шимширмээр сонсогдож байна шүү дээ надад. Юу гэж байна гэхээр зэрэг ихэнх нь зээл аваад л тэр зээлээ эргэж төлж чадахгүй учраас нэмж зээл аваад 16-хан хувь нь тэр амьжиргаандаа шилжүүлэх боломжтой гэсэн тоог хэлчих шиг боллоо. Зөв үү? Зөв ойлгосон бол би. Энэ асуудал нь эргээд нөгөөдөх амьжиргааны наад захын хэрэгцээг хангах боломжгүйд хүргэдэг. Тэгэхлээр бид нар Улсын Их Хурал дээрээ ч Засгийн газар дээрээ ч бодлого гаргах түвшиндээ ч гэсэн энэ тал дээр нь аль болохоор энэ тэтгэврийн зээлийг хамаагүй хүндээ, нийгэмдээ ээлтэй талаас нь харж үзээч ээ, энэ талаас нь бодолцоосой, энэ талаас нь та нарыг сэтгэл санаагаа чилээж, бодлогоо боловсруулаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Санал хэллээ. Болормаа гишүүн асуултаа асууна уу.

Э.Болормаа: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Юуны өмнө бас Нийгмийн бодлогын байнгын хороогоор энэ чухал асуудлыг оруулж ирж байгаа бас Байнгын хорооны даргадаа баярлалаа.

Монголбанкныхнаас асуухад та нар аав ээжгүй хүмүүс үү, эмээ өвөөгүй юу? Та нарын ойр дотнын хүн тэтгэвэр авдаггүй хүн байхгүй юм уу? Энэ хэрэглээний зээлийн өсөлтийг бууруулах гээд байна гэж байх юм. Энэ хэрэглээний зээлийн өсөлтийн яг хэдэн хувийг нь тэтгэврийн зээл хамруулж байгаа юм тэрийг хэлчих. Дундаж тэтгэвэр хэдэн төгрөг байдаг юм та нар мэдэх үү? Дундаж тэтгэврээр өмнөх 70:30-ийн харьцаагаар 36 сараар зээл авахад дээд хэмжээ нь хэд юм? Одоо 50:50-аар 12 сараар дээд хэмжээ нь хэд юм, хүнд яг яаж нөлөөлөөд байгаа юм? Энийг эхлээд та бүхэн хариулчих.

Л.Энхнасан: Яг тодорхой асуултууд асуулаа. Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу. 5 дугаар микрофон.

Г.Энхтайван: Болормаа гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн зээлийн хүсэлт цагаан сарын үеэр энэ зохицуулалтыг хийхээс өмнө 50 хувьтай байсан. 50 хувьтай. Энэ зохицуулалт хийсний дараа 13 хувьтай буурсан. Тэгэхээр тэтгэврийн зээлийн өсөлт гэдэг маань өөрөө 2020 оны 1 дүгээр сард тэтгэврийн зээлийг 1 удаа тэглэсэн шүү дээ. Үүнээс хойш 1.8 их наяд төгрөг хүрчхээд байгаа юм. Тэгэхээр мэдээж тэтгэврийн зээлийн өсөлт ердийн бусад зээлийн өсөлтөөс хамаагүй өндөр хувьтай байсан. Нэгд нь.

Хоёрт нь тэтгэврийн зээлийг Төв банк хэрэглээний зээлийн ангилалд хамруулж байна аа гэж. Ер нь урьд нь ч гэсэн хэрэглээний зээл дээр Төв банк төрөл бүрийн л арга хэмжээг авч байсан. Энэ дээр янз янзын л арга хэмжээг олон удаа авсан. Түрүүн гишүүн хэлж байсан 7 удаа авч байсан байсан, 7 удаа авсан. Хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах үүднээс энэ асуудлыг хөндсөн. Гэхдээ ер нь төв банкны зүгээс энэ дээр тэтгэврийн зээлийг хэрэглээний зээлийн

ангиллаас гаргаад арилжааны банканд нь өөрт нь үлдээгээд явах нь зүйтэй юм байна гэж үзлээ.

Тэр хэрэглээний зээлтэй холбоотой, тэтгэврийн зээлтэй холбоотой тоо хэмжээн дээр нь 6 сарын 16-ны өдрийн гаргасан шийдвэрийн дагуу бүрэн тэтгэврийн доод хэмжээ авч байгаа, доод хэмжээ шүү 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүн 4.5 сая төгрөгийн тэтгэвэр авах буюу тэтгэврийн зээл авах боломжтой байгаа. 3 сарын зохицуулалтаар энэ 2.2 сая байсан. Тэгэхээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ авч байгаа хүн 4.5 сая төгрөгийн зээл авах боломжтой. Өмнөх бүүр өмнө тэтгэврийн зээлийн ямар ч зохицуулалт КОВИД-ын хуулийн үеэр өр, орлогын харьцааг байхгүй болгочихсон байсан энэ үед тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 6 сая л байсан. Тэгэхээр бас одоо бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр 4.5 сая авч байгаа гэдэг чинь дундаж чинь 6 сая хүрч байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр буугаад байгаа юм ерөөсөө байхгүй.

Л.Энхнасан: Болормаа гишүүн тодруулга.

Э.Болормаа: Энхтайван Ерөнхийлөгч би танай тайлангаас танд уншиж өгье. Энэ 2025 оны 5 сарын байдлаар нийт хэрэглээний зээлийн өсөлт 23 хувь, 9.9 их наядаас 12.2 их наяд болж ихэссэн. Энэний 72 хувь нь цалингийн зээл. 10 хүрэхгүй 9-хөн хувь нь тэтгэврийн зээлийн өсөлтөөс гарч байгаа. Таны наад хэлээд байгаа Фредерик Эбертийн сан чинь улс төрийн зорилготой, социал демократ үзэл баримтлалыг гаргах гэж явдаг ийм судалгаа хийдэг байгууллага. Эдийн засгийн судалгаа биш.

Гэхдээ наад судалгааны чинь гол агуулга нь тэтгэврийн ахмадууд маань ядуурлын түвшинд оччихсон байна шүү дээ гэдэг энэ л гол агуулгыг хэлж байгаа юм. Эдийн засгийн тооцоо судалгаагаар энэ бүлэгт байгаа хүмүүс инфляцад нөлөөлөөд байдаг бүлэг хүмүүс биш. Англиар хэлбэл прайс сэнсетив/price sensitive/ хүмүүс байдаг. Тийм болохоор та нар энэ инфляцыг бууруулах, хэрэглээний зээлийг бууруулах гэдэг зорилгын чинь 88 дугаар асуудал энэ тэтгэврийн зээл байхгүй юу. Өмнөх 87 асуудлаа шийд

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут.

Э.Болормаа: Өнгөрсөн жил наад хэрэглээний зээл чинь 30 хувь болоод нэмэгдэж байхад эдийн засаг хүнддээд энийгээ шийд ээ гэж байхад та нар өөрсдөө яасан 2 удаа бодлогын арга хэмжээгээ буруу аваад, 2 удаа бодлогын хүүгээ бүр бууруулсан. Та нар бодлогын арга хэмжээнүүдээ бүгдийг нь алдаатай гаргасныхаа горьг өнөөдөр ахмадууд дээр үүрүүлэх гэж байна. Тэгээд бид нар хараат бус юм хийдэг ээ, хараат бус Мөнгөний бодлогын зөвлөл гэж байна. Энэ Мөнгөний бодлогын зөвлөлд чинь хэн санал оруулсан юм? Монголбанк саналаа оруулсан шүү дээ. Та нар өөрсдөө саналаа оруулсан. Хуулиараа өр, орлогын харьцааг хэн шийдвэр гаргадаг юм? Энэ тогтоол чинь Б.Лхагвасүрэн гэсэн ийм гарын үсэгтэй тогтоол гаргаж байгаа. Яахаараа өр нь энэ Засгийн газрын яамны саналыг бариад явж байдаг юм? Та нар эдийн засгийн хувьд ч алдаа гаргасан. Ёс зүйн хувьд ч гэсэн алдаа гаргаж байгаа. Ёс зүйн хувьд та нар нийгмийн хамгийн сул дорой бүлгээ буланд шахаад Монголоо алдсан, хүнээ алдсан ийм шийдвэр гаргаад сууж байгаагаасаа ичих ёстой.

Л.Энхнасан: Үг хэлэх бас боломж байгаа учраас.

Би бас асуултаа асууя. Ахмадын төлөөлөлтэй бол 10 хоног, бараг 14 хоног гадаа жагсаж байгаа төлөөлөлтэй уулзсан. Төлөөлөлтэй уулзахад тодорхой хэд хэдэн асуултуудад асуусан. Энийг бол би бас төлөөллүүд бас өөрсдөө хэлэх байх. Тэгэхдээ би бас зарим хоёрыг нь дурдъя гэж бодож байна. Ялангуяа энэ Монголбанкны танилцуулга дээр ингэсэн байна. 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс хойш тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалан шинээр зээл авч байгаа зээлдэгчид хамаатай юм. Тэрний өмнө өдрөөс тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч нарын хувьд Монголбанкнаас ямар нэгэн зохицуулалт хийгээгүй байна гэсэн байна.

Гэтэл манай ахмадууд болохлоор өмнө нь зээлтэй ахмадууд дахин зээл авах гэхлээр өмнөх зээлээ тэглэж дахин ир ээ гэсэн ийм нөхцөл тавьж байна аа гэж байна. Мөн тэтгэврийн зээлийн хугацааны хувьд тодорхой хязгаарлалт тавиагүй ээ гэж байна. Энэ нь үнэн үү? Яагаад гэвэл 12 сар гээд тавьчихсан байна. Одоо банкин дээр очихлоор ахмадуудыг 12 сараар зээлээ авч болно гэж байна. Ахмадууд болохлоор бас 2 дугаар хүсэлт нь болохлоор зээлийн хугацаа 36 сар хүртэлх сунгаж боломжтой юу? Хэрвээ үнэхээр энэ 50:50-ийг шийдэж чадахгүй бол богино хугацаагаар өндрөөр төлөх нь бол ахмадуудад амьжиргааг бол доройтуулж байна аа гэсэн ийм бас хүсэлт тавьсан байна. Энэ 2 дээр хариулт авъя. Яг тийм Монголбанкнаас шийдвэр гарсан юм уу? Хугацааны хувьд?

5 номер Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна.

Г.Энхтайван: Энхнасан даргын асуултад хариулъя. Төв банкны Мөнгөний бодлогын хороо 2025 оны 6 сард хуралдахдаа тэтгэврийн зээлийн хугацаа дээр ямар ч хязгаарлалт тавиагүй. Энэ дээр арилжааны банк өөрсдийн бодлогоороо хэдий хугацаатай олгох нь нээлттэй байгаа. Тэгэхээр төв банк энэ дээр ямар хязгаарлалт ер нь цаашдаа тавих нь буруу гэж үзэж байгаа. Би түрүүн ч гэсэн хэлсэн. Ер нь цаашдаа төв банк энэ тэтгэврийн зээлтэй холбоотой өр, орлогын харьцаа дээр ч гэсэн ер нь хязгаарлалт тавихгүй. Ерөөсөө зөвхөн арилжааны банк нь өөрөө өөрсдөө бие даагаад шийдвэрлэдэг тухайн зээлдэгчийнхээ өөрийн нөхцөл байдалд тааруулсан зээлдэгч тус бүрд тохируулсан зээлийн бүтээгдэхүүнээ гаргаад явдаг больё. Энэ дээр төв банкны зүгээс ямар нэгэн хэлбэрээр юу гэдэг юм хязгаарлалтыг тавих нь бас зохисгүй юм байна гэдэг тийм л хариулт хэлье дээ.

Л.Энхнасан: Би тэгэхлээр зөв ойлгосон уу? Ямар ч хугацаа дээр бол хязгаарлалт тавиагүй юм байна тээ? Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулна уу.

Г.Энхтайван: 36 сар болгож өгөөч ээ гэж байна. Энэ дээр энэ дээр харин бид бүхэн хязгаарлалт тавихгүй байгаа учраас арилжааны банк нь өөрөө энэ дээр өөрсдийн эрсдэлээ үнэлээд тухайн зээлдэгч тус бүр дээр харилцан адилгүй зээлээ олгоод явсан нь зүйтэй байх. Ер нь мэдээж 60 настай хүн зээл авах, 80 настай хүн зээл авах энэ тэр чинь хугацааны хувьд бас банк тус бүр дээр ялгаатай л байгаа. Тэгэхээр энэ дээр нь төв банк арилжааны банканд нь өөрсдөд нь шийтгэх эрхийг нь олгоод зохицуулалтаа уян хатан болгоё л гэж бодож байна.

Л.Энхнасан: Мөн тэр нөгөө зээл авах гэж байхад өмнөх зээлээ тэглэх ёстой гэсэн тэр дээр тодорхой бас хариулаад өгчих.

Г.Энхтайван: Энэ мэдээж өмнө банкны өөрийн шийдвэрлэх асуудал. Өр, орлогын харьцаа буюу тухайн зээлдэгч маань хэдий хэмжээний зээлтэй байсан

байна, хэдий хэмжээний тэтгэвэр авч байна, зээлээ төлөөд үлдэж байгаа хэсэг нь дахиж зээл авахад хүрч байна уу гэдэг дээр банк өөрийн харьцаагаа бодоод шийдвэрээ гаргадаг. Энэ дээр бас Төв банк ямар нэгэн зохицуулалт ерөөсөө хийгээгүй. Банканд нь нээлттэй орхисон.

Л.Энхнасан: Гишүүд асуулт асууж дууслаа. Ахмадын, иргэдийн төлөөлөл бас саналыг сонсьё. Алтанзул иргэн хэддүгээр 9 дүгээр микрофон уу? Та 9 дүгээр микрофон дээр суучихна уу. 9 дүгээр микрофоныг өгнө үү. Иргэдийн төлөөлөл.

Ц.Алтанзул: Ахмад настуудын төлөөллийн мэдэгдэл.

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, Монголбанк, Мөнгөний бодлогын хороонд 2025 оны 7 сарын 1.

Хүндэт гишүүд ээ, эрхэм шийдвэр гаргагчид аа,

Бид Монгол Улсын олон мянган ахмад настны өмнөөс төлөөлж энэхүү хуралд оролцож байна. Энэ хуралд оролцох боломжийг олгосон Нийгмийн бодлогын хороон дарга Энхнасанд баярлалаа. Талархал илэрхийлж байна.

Төр засаг, төв банкны зүгээс ахмадуудад чиглэсэн бодлого, шийдвэр гаргахдаа амьдралын бодит нөхцөл байдал, тэтгэврийн хүрэлцээг бодитоор үнэлж, хүний эрхийг дээдэлсэн байхыг шаардаж байна.

Монголбанкнаас гаргасан тэтгэврийн зээлийн 50:50 хувиар хасах журам нь ахмадуудад дараах сөрөг нөлөөг үзүүлж байна.

Тэтгэвэр хүрэлцэхгүй болж, өдөр тутмын хэрэгцээ, эм тариандаа ч хүрэлцэхээ байлаа. Урьдчилж авсан зээлүүдийг нь давхар төлүүлэх маягаар арилжааны банкнууд шударга бус нөхцөл үүсгэж, ахмад настны нэр төр, эдийн засгийн эрх чөлөө зөрчигдөж, бухимдал, итгэл алдрал үүсгэж байна. Монголбанк олон нийтэд тодорхой бус, ойлгомжгүй мэдээлэл түгээж байгаа нь төөрөгдөлд хүргэж байна.

Шаардлага

50:50-ийн тэтгэврийн зээлийг хасах шийдвэрийг нэн даруй цуцлах, 100 хувийн зээлийн эрхийг сэргээх.

Хоёрт нь ахмад настны тэтгэврийн зээлийг бүрэн дүүрэн олгох хуучин журмаар нь сэргээх.

3.Монголбанк болон төрийн байгууллагууд олон нийтийн ил тод, ойлгомжтой, хариуцлагатай асуудлыг мэдээлэх.

4.Ахмадын эрх ашиг хөндөгдсөн аливаа бодлого шийдвэрийг гаргахдаа ахмадын төлөөлөл оролцуулдаг тогтолцоог бүрэлдүүлэх.

5.Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах.

6.Зээлийн хугацааг 36 хүртэл сунгах нөхцөлийг бүрдүүлэх.

7.Зээл авахад арилжааны банкнууд өмнөх авсан шигээ зээлээ төлөөд зээл дахин ав гэдэг. Үүнийг болиулах.

Жишээ нь, Монголбанк арилжааны банк мэднэ гээд байна шүү дээ. Арилжааны банкиг тэгвэл хэн мэдэх юм? Банкин дээр хүмүүс уйлаад гарч байгаа шүү. Ахмадууд бидэнд халамж биш шударга хандлага хэрэгтэй. Биднийг биш бидний амьдралыг харж шийдвэрлээрэй.

Хүндэт гишүүд ээ,

Ахмадын амьдрал зөвхөн статистик биш шүү бид нар. Бодит амьдрал, түүхтэй, нийгмийн зүтгэлтэй иргэдийн амьдрал юм. Биднийг үл тоомсорлож, итгэл алдарч нийгмийн шударга ёс алдагдана. Тиймээс өнөөдрийн хурлаар бидний дуу хоолойг сонсож дорвитой шийд гаргахыг хүсье.

Ахмад насны төлөөлөл бид 3. Алтанзул, Гантөмөр.

Би асуумаар байна л даа. Сая Энхтайван Дэд ерөнхийлөгчөөс асууя. Та тоо бодож чаддаггүй юм уу, аль эсвэл байдаг юм уу? Бүрэн тэтгэвэр чинь, хувь тэнцүүлсэн тэтгэвэр чинь 672 мянга байдаг юм шүү дээ. Би жишээ нь 3 сарын зээлийн үлдэгдэлтэй байж байгаад өнгөрсөн 14 хоног тэр 6 сарын 12-ны шийдвэр гарсныг дараа Төрийн модны 2-ын Төрийн банкин дээр очоод дахиад 3 сарын зээл авъя, миний нуруу өвдөөд байгаа учраас 280 мянган төгрөгөөр тариагаа авчихъя гээд очсон.

Тэгтэл Төрийн банк маань 3 сарынхаа үлдэгдэл 1 сая 580 мянгаа төл гэсэн байхгүй юу. Хэрвээ надад сая 1 сая 580 мянган төгрөг байсан бол би танайхаас 50 хувиар 780 мянган төгрөг авах гэж яах гэж ирэх вэ дээ Монголбанк чинь гээд да, да, да гээд гараад явсан. Мөнгө хүүлдэг хүн дээр зээл чөлөөлдөг хүн дээр очоод 1 сая 580 мянган төгрөгийг чөлөөлөөд өгөөч гэсэн чинь 150 мянган төгрөг надад хүүд нь өгнө гэсэн. Ингээд 1 сая 700-гаад мянган төгрөг болж байгаа биз? Эргээд 1 сая 700 хэдэн мянгаа 3 сараар чөлөөлж чөлөөлүүлчхээд 572-ын чинь 50 хувь нь 286 мянга байна. 286 мянгаа 6 сараараа үржүүлэхээр 1 сая 700 хэдэн мянган төгрөг гарч байгаа байхгүй юу. Үүнээс 6 сарын 8.4 хувийг бодохоор 144 мянга. Тэгэхээр 1 сая 500 мянга миний гар дээр ирэх болчихож байна. Тэгэхээр би 200 мянган төгрөгийн өрөнд орж байгаа байхгүй юу. Энийг юу.../минут дуусав./

Л.Энхнасан: 1 минут нэмж өгье.

Ц.Алтанзул: Яг 12 Сараа Төрийн банк 16.8-аар боддог байхгүй юу хүүг нь. Тэгэхээр 6878976 мянга төгрөг болж байна шүү дээ. Ингээд 50 хувиар бодохоор гарт олох нь 4 сая гэж ярилаа. Тэгвэл 3439488 төгрөг болж байгаа байхгүй юу. Би ингэж хэлмээр байна. Тэтгэвэр бол цалин биш юм аа. Тэтгэвэр бол бизнесийн ашиг ч биш, тэтгэвэр бол бизнесийн ашиг олдог орлого ч биш. Тэтгэвэр бол төр, иргэн хоёрын хийсэн гэрээ тийм ээ. Тэгээд одоо хар аа асуудлыг тэр хэн Лхагвасүрэн гэдэг хүн нь байхгүй. Үнэхээр хар аа, үнэхээр манай гэрт тийм үү би өөрийнхөө амьдралыг л ярья. Манай нөхөр ажил хийж яваад хусны хачигт хазуулаад сэтгэцийн асуудалтай унадаг болсон. 1 группийн хүнтэй. Би өөрөө тулгуур эрхтний бэрхшээлтэй, 572 мянга, нөхөр 689 мянга, хүүхэд маань сонсголын бэрхшээлтэй, байнгын асаргаанд амьдардаг.

Тэгвэл яг тэтгэврээр амьдарч байна. Яг нийгмийн тэтгэвр тэтгэмжээр амьдардаг хүн байгаа байхгүй юу. Тэгвэл нэгнийхээ сонсголгүй хүүхдээ сургуульдаа авчрах гэж энд би авчирсан. Түрээсээ өгчихдөг. Нэгнийхээ мөнгөөр эм, тариагаа авдаг, халамжийн мөнгөөр амьдралаа залгуулдаг. Үнэндээ бүсээ чангалаад амьдарч байгаа байхгүй юу. 10 хоног суухад тийм үү над руу 4 эмээ уйлж ярьж байна шүү дээ ямар уу? Та нар хар аа юу билээ Байнгын асаргаатай хүүхдүүдийн мөнгийг эцсийн юуг нь тийм үү, энд уг нь Энх-Амгалан сайд орж ирсэн бол, Энх-Амгалан гишүүн орж ирсэн бол их л хэрэгтэй байсан юм. Яагаад Энх-Амгалан гишүүнд би 3 юманд гомдож явдаг. Би хэлмээр байна. Та нар дамжуулж хэл. Эхнийх нь боловсролын цогц хууль гээд жигтэйхэн сүржин юм ярьж байсан. Сонсголгүй ...хөгжлийн зураглалыг нь гаргаад өгөхөд статусгүй баталсан. Эхний гомдол.

Хоёрдугаарт нь Төрийн ордны гадаа тархины саажилттай хүүхдүүдийн эмийн чанар гээд эхчүүд жагссан. 14 мянган байнгын асаргааны бүх хүүхдүүдийг Монгол Улс өнөөдөр хүнд, хөнгөн гэж ялгаж, 3800 хүүхдийг хүнд гэдэг ангилалд оруулсан. Би өөрөө 2 сар 10 хоног хөлөө чирч явж байж сонсголгүй хүүхдээ хүнд гэдэг ангилалд оруулсан юм шүү. Гуравдугаарт, хоёр дахь гомдол нь энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхсан.

Сая хэллээ шүү дээ 60 настай хүн, 80 настай хүнийг харьцуулаад байхад аа яадаг юм. Эрсдэлтэй зээл гэж юу яриад байгаа юм. Германы тэр байгууллагын 11.7 тэрбум төгрөг гэж байна. Төрийн банк ерөөсөө 6 сараас дээш батлан хамгаалагчтай зээл өгдөг шүү, батлан даагчтай. Тэр хүн талийгаач боллоо тэгвэл хүүхдээс нь тэр хүнээ банк гаргаагүй байхад банкныхан очоод өр, авлагаа нэхдэг байхгүй юу. Тэгэхлээр 11.7 тэрбум энэ энэ тоогоор тайлбарлаад өгөөрэй. Энэ эрсдэлтэй зээл биш шүү.

Л.Энхнасан: Баярлалаа. Үгээ хэлэхдээ та бас. Асуултад нь, баярлалаа. Асуултад нь хариулна уу. 5 дугаар микрофон. Энд бас шинэ сайд маань Аубакир сайд маань сууж байгаа учраас энд бас салбарын хувьд анхаараарай. Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулж өгнө үү.

Г.Энхтайван: Таны асуултад тодруулъя. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянган төгрөг байгаад байгаа. Яг одоогийн байдлаар 6 сарын гаргасан шийдвэрийн дагуу хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572 мянган төгрөгөөр тэтгэвр авч байгаа иргэн 12 сарын хугацаатай авах юм бол 3.8 сая, 24 сарын хугацаатай авах юм бол 7 сая төгрөгийн зээл авах боломжтой байгаад байгаа.

Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689 мянган төгрөг байгаад байгаа. 12 сараар авах юм бол 4.5 сая, 24 саяар авах юм бол 8.4 сая төгрөгийн тэтгэвр авах боломжтой байгаад байгаа.

900 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүний хувьд 12 сараар зээл авах юм бол 6.9 сая, 24 сараар авах юм бол 12.8 сая. Түрүүн би бас эхэнд нь хэллээ хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр бид бүхэн авч байгаа. Доод хэмжээ шүү дээ. 572 мянган төгрөгийн тэтгэвр авч байгаа хүн 24 сараар авахаар 7 сая төгрөгийн зээл авах боломжтой байгаад байгаа. Өмнөх зээлээ үлдэгдэлтэй байгаа тохиолдолд арилжааны банк мэдээж зээлийг үлдэж байгаа зээлийнх нь төлбөрөө төлөөд үлдэж байгаа хэсэгт нь зээл олгох тийм өөрсдийн тийм журамтай байдаг.

Төв банкны зүгээс арилжааны банкиг ямар нөхцөлөөр яаж зээл олгох, хэнд зээл олгох чиглэлээр шууд чиглэл өгдөггүй.

Таны тавьсан асуудлыг бид бүхэн ойлгож байна. Ер нь төв банкны зүгээс энэ арилжааны банкин дээр тэтгэврийн зээлтэй холбоотой аливаа зохицуулалтыг хийхгүй, арилжааны банк өөрөө бие даагаад өөрсдийнхөө нөхцөлөөр олгодог болох нь зүйтэй юм байна гэж үзэж байна. Ер нь тэтгэврийн зээлийн хугацааг бас уртасгах, зээлийн хүүг бууруулах үндсэн арга нь энэ арилжааны банкин дээр энэ Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг байршуулаад тухайн мөнгөнөөс нь тэтгэврийн зээлийг эх үүсвэрийг шийдэж явах нь зүйтэй болов уу гэсэн Төв банкны байр суурьтай байна.

Л.Энхнасан: Асуулт байгаа бол тодотголоо авчихсан. Тэгэхлээр үгээ, үгийг нь түрүүлээд хэлүүлчихье. Та тэгвэл үгээ хэлчих. 9 дүгээр микрофон. Яг минутдаа тааруулж хэлээрэй.

Ц.Алтанзул: Та нарыг аягүй сайхан сонслоо гээд нөгөө дээр үеийн кинонууд дээр ноёдууд нь гарч ирж ярьдаг шиг тэгж сонсогдож байна шүү дээ. Одоо тэгээд яах юм банкин дээр, та нар хар аа та нарын гаргасан 50:50-ийн харьцаа тэр юу чинь явагдаад байгаа шүү дээ банкин дээр 24 сар гээд байгаа байхгүй юу. Энэ зээлийн чинь болзлыг хангах 1 ч ахмад байхгүй. Урьдынхаа зээлийг төлөхгүй, төлж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар яах гээд байгаа юм? Та нарын тэр байгуулсан тэр банк бус санхүү рүү яв гээд хөөгөөд байгаа юм уу? Бид нар тэрийг чинь санхүүжүүлмээргүй байна шүү яг үнэндээ. Энийг яах юм яг энэний гаргалгааг хэлээд өгчих тэгэх үү. Эзэн байхгүй юм уу, арилжааны банкиг хэн хариуцах юм өнөөдөр? Үгүй ээ үгүй юу гэж дээ энэ чинь. Би 3 сарын зээлийн үлдэгдэл байна шүү дээ. Тэгвэл дахиад надаар төлүүлэхгүйгээр миний хүссэн 3 сарын зээлийг л өгчихмөөр байгаа байхгүй юу. Тэр хүүгээ дахиад л боддог юм байгаа биз. Хүүгээс хүү бодоод байгаа шүү дээ. 6 сар дотор батлан даагчгүй зээл өгдөг байхгүй юу. Тэгэхээр би 1 сая 580 мянган төгрөгийг чинь төлж чадахгүй байна аа, чадваргүй байна. Тэгэхээр дахиад надад 3 сарын зээл өгчих тийм эрхийг нээгээд өгчхөөч. Тэгэхгүй бол банк чинь хэзээ ч энэ чинь яахгүй.

Л.Энхнасан: Иргэдэд сайн мэдээллийг нь зөв, ойлгомжтой хэлж өгөхгүй бол ахмадууд Монголбанкны үүдэнд бас нэлээн олон хоног болсон шүү дээ. Хэн ч гарч ирж тайлбар өгөхгүй, саналыг нь сонсохгүй та нар эндээ бас анхаарах хэрэгтэй байхгүй юу.

Энхтайван Дэд ерөнхийлөгч.

Г.Энхтайван: Өмнөх зээлийнхээ үлдэгдлийг дараагийн зээлдээ шилжүүлээд явъя гэж та хүсээд байгаа юм байна шүү дээ? Тийм. Тэгэхээр арилжааны банкин дээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулаад зээлийн гэрээн дээр 1 удаа нөхцөл өөрчлөх эрх нь иргэн хүнд нээлттэй байгаад байгаа юм. Тэгэхээр арилжааны банк тус бүрдээ ялгаатай байгаад байгаа юм. Өөр өөрсдийн бодлоготой. Зарим банк нь нөхцөл өөрчилдөг, зарим нь өөрчилдөггүй. Тэгэхээр нөхцөл өөрчлөөд тухайн өмнөх та зээлийнхээ гэрээ гэсэн үг шүү дээ яг тэр гэрээгээ өөрчлөхгүй, тэр гэрээнийхээ заалтыг өөрчлөөд тэр гэрээ чинь хүчин төгөлдөр үргэлжлээд явах боломжтой байгаад байгаа. Хэрвээ яг энэ дээр бүүр яг таныг яг энэ асуудал дээр бүүр яг энэ дээр ийм асуудал үүсгэсэн.../минут дуусав./

Ц.Алтанзул: 281200 ахмадын өмнөөс бид 3 ингэж орж ирээд сууж байгаа байхгүй юу. Ганц би биш байхгүй юу.

Л.Энхнасан: Энэ хүн болгон үг хэлбэл дэгээ зөрчсөн болно. Тэгэхлээр яг төлөөлөл нь хэлээд боллоо. Одоо гишүүд үгээ хэлнэ. Ер нь ахмадуудын төлөөллийг энэ Монголбанк хүлээж авч Энхтайван Дэд ерөнхийлөгч өө Лхагвасүрэн Ерөнхийлөгч хэзээ ирэх юм? Одоо энэ ахмадуудын төлөөллийг та нар авч уулз аа. Бид нар энд өнөөдөр Байнгын хороод дээр энэ асуудлыг яриад сууж байгаа нь харамсалтай байна шүү дээ. Та нар ахмадуудад ойлгуулаад, энийгээ үе шаттай хийсэн бол ийм нөхцөл байдал үүсэхгүй шүү дээ.

Ингээд үгээ хэлэх гэж байгаа гишүүд нэрсээ өгнө үү.

Харин тийм ингээд Болормаа гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн үгээ хэлнэ үү.

Ц.Идэрбат: Тийм хэдүүлээ нөгөө төр бас төмөр нүүрээ харуулах юм байна, харуулахгүй юм байна. Энэ асуудал бас тийм уян хатан хандах ёстой ийм зүйл. Нэг нь ахмадуудын нөхөр, нэг нь дайсан юм шиг хэдүүлээ ингээд яах вэ. Төрийн чиг үүрэг энэ хүмүүсийн сайн сайхны төлөө л шийдвэр гаргах ёстой. Тэтгэвэр маань хаанаа ч хүрэхгүй байгаа гэдгийг нь та хэд бүлхнээ мэдэж байгаа. Тэрийгээ шийдэхийн тулд зээл хүү авч байна. Янз янзын л хүн байна. Хүний амьдрал юм болохоор. Өнөөдөр гэхэд над руу Бор-Өндөр-өөс, Хэнтийн Бор-Өндөр сумаас 300 гаруй ахмадууд гарын үсэг явуулж байна. Сая яг энэ Алтанцэцэг гэдэг хүнд тохиолдсон шиг нөхрийнхөө, өвгөнийхөө эмчилгээг хийлгэх гээд энэ зээл хүлээгээд зээл нь олигтой юм болж өгөхгүй 2, 3, 4 сар болоод хүнээс мөнгө зээлээд сая төгрөг нь сая 500 мянга болж төлөх болчихоод байна гээд амьдрал хэцүү байна шүү дээ. Энэ зээлийнх нь асуудлыг ингэж хатуурууллаа гээд энэ ахмадуудын өмнө тулгамдаж байгаа асуудал чинь өөрөө алга болчихгүй. Тэгээд л ББСБ, хувь зээлдэг хүмүүс рүү явна.

Тэгэхээр энэ болгон чинь өөрөө маш төвөгтэй байгаа учраас хэдүүлээ энэ дээр Монголбанк ч тэр, яам ч тэр уян хатан хандаад энэ ахмадуудын энэ тэтгэврийн зээлийн асуудал дээр яаж эвтэйхэн шийдэл байх вэ гэдгээ бас сонсоод. Өнөөдрийн энэ үүсээд байгаа маргаан, энэ ахмадуудын бухимдал чинь яг өмнөх тэтгэврийн зээлийн нөхцөлд нь тохируулаад бүх санхүү мөнгөө зохицуулчхаад явж байхад нь гэнэт гэнэт шийдвэр гарсанд л наадах чинь байгаад байгаа байхгүй юу. Энийгээ л хэдүүлээ тэгж байн байн ингэхгүйгээр бүх зүйлээ тодорхой болгоод тэр тэтгэврийнх нь хувийг 50:50 нь 70:30 болох юм уу, хугацаа нь хэд байх юм, ер нь цаашдаа энэ тэтгэврийн зээл гэдэг энэ бүтээгдэхүүнийг яаж байлгах юм? Байлгах юм уу, байлгахгүй юм уу? Хэрвээ байлгахгүй байвал хэдэн жилийн дараанаас энэ нь байхгүй болох юм ч гэдэг юм уу ингэд бүх юмнуудыг нь тодорхой болгоод ярихгүй бол гэнэт гэнэт шийдвэр гаргаад гэнэт гэнэт гарч ирж мэдээлэл хийхдээ ахмадуудыг төөрөгдүүлсэн юм хийгээд үнэхээр энэ чинь асуудал нь цаг, минутаар хэмжигдэж байдаг юм байна лээ шүү дээ. Би над руу өчнөөн хүмүүс мессеж бичиж байна. Өчнөөн хүмүүс залгаж ярьж байна. Амьдрал дээр ийм байна аа гээд.

Тийм учраас би Монголбанк, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, гэр бүлийн яам тэр бичиг өгөөд асуудлаа шийдэж байсан бол одоо саналаа гаргаад ахмадуудынхаа төлөөллүүдтэй уулзаад танайх ч уулзаад, яам ч уулзаад ингээд

энэ асуудлыг их эвтэйхэн шийдэх юм руугаа орохгүй бол хэдүүлээ болохгүй нь ээ гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Дээрээс нь наад зээлийн хүү одоо хугацааг нь сунгасан ч гэсэн зээлийнхээ хүүг 2 функтээр эд нар өсгөөд л тавьчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр зээлийн хүү буулгах гэдэг энэ асуудал дээр Монголбанк би энэ тэтгэврийн зээлээс эхлээч ээ гэдгийг нэлээн хэдэн сарын өмнөөс л яриад байгаа ийм зүйл. Тийм учраас та бүхэн энэ тэтгэврийн зээлийн нөхцөлөө, энэ тэтгэврийн хүүгийнхээ асуудлыг бас эргэж харж, ярьж шийдвэрлэх тал дээр уян хатан хандаарай. Тэр жишээ нь би тэр цэргийн тэтгэврийнхнийг яриад байгаа шүү дээ. 41-тэй залуучууд тэтгэвэрт гарчихсан гэдэг ийм ангилалд ороод өөр ангиллын зээл олгохгүй байна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ мэтийг эд нар 280 мянган хүнийг 1 хайрцагт хийгээд хайрцаглачихна гэхээр чинь наадах чинь болж өгөхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бидэнд нийгмийн ийм бухимдал хэрэггүй байна шүү дээ. Ахмадууд зайлуул юу яах вэ тэтгэвэр нэмээд өгөөч гэхгүй байна. 10 хувь 26 онд нэмэгдэнэ. Тэгэхдээ тэр чинь нэмэгдэл биш инфляц идэгдчихэж байгаа учраас л нэмж байгаа ийм зүйл байгаа шүү дээ. Тэгэхээр би Монголбанканд энэ дээр жоохон уян хатан ханд аа хэдүүлээ ямар 2 тал болж, 3 тал болж муудах биш аль аль эрх ашгаа бодож энэ дээр бас жоохон идэвхтэй ажиллаж өгөөч ээ гэж л би та бүхнээс бас хүсэх гээд байгаа юм.

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут Идэрбат гишүүн өөрөө энэ саналыг бас тавьсан учраас 1 минут нэмж байгаа юм шүү.

Ц.Идэрбат: Баярлалаа. Тэгэхээр Монголбанкныхан минь би бас та бүхний үгээс л арилжааны банк руу бүгдийг нь шийднэ ээ гээд байгаа юм. Тэгэхээр энийг Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоор энэ чинь 19 оноос хойш өчнөөн шийдвэр гаргаад ингэж ингэж яваад хэдүүлээ ийм байдалд орчихсон. Одоо энийгээ уян хатан болгочхоод дараа нь наад асуудлаа яриарай. Тэгэхгүй ингээд бужигнуулж хаячхаад арилжааны банк мэднэ гээд. Арилжааны банкин дээр яг юу болдгийг сая тэр Алтанцэцэг гээд эгч яг ний нуугүй ярьж байна шүү дээ. Бүгдийг нь ярьж байна. Та нар арилжааны банк шийдчихнэ гээд орхичхож би болохгүй шүү. Дэндүү хүнлэг бус юм болно шүү гэдгийг л би бас эцэст нь хэлье. Байнгын хорооноос энэ тал дээр бас тодорхой тэмдэглэлээр үүрэг болгож, холбогдох яам руу нь Монголбанк руу нь Мөнгөний бодлогын хороо зөвлөл нь хараат бус байх Монголбанк руу бас энэ зүйлийг явуулаарай гэж л ингэж би хэлье. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Зулпхар гишүүн үгээ хэлнэ үү.

С.Зулпхар: Та бүхний оройн мэндийг дэвшүүлье. Бид их тал талаасаа байр сууриа илэрхийлж бас уулзаж ярьж сууж байгаа нь их зөв юм байна гэж бүгдээрээ харж байна. Угаасаа ч тийм байх ёстой. Алтанцэцэг гуай өөрийнхөө бас өөр дээрээ тохиолдсон байдлаар энэ тодорхой жишээг ярьж байна. Захиргааны байгууллагууд бол бас нийтлэг байгаа нөхцөл байдалтай уялдсан байдлаар бас шийдвэр гаргах гэж хичээдэг. Энэнтэй уялдсан мэдээллийг ч гэсэн та бүхэн бас сонсож байгаа байх. Энийг бас наанатай, цаанатай, бас та бүхэн ойлгоорой гэж байгаа юм.

Би та бүхэнд ганц, хоёр энд тоонууд дээр тулгуурласан байдлаар зориуд ойлголт өгөх үүднээс ярьж байгаа шүү. Одоо бид бүрэн тэтгэврийн доод хэмжээ зур 689 мянга, нийт тэтгэвэр авагчдын 54 хувь нь бол тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа. Бүрэн болон бүрэн бус тэтгэвэр авч байгаа шүү дээ. Өмнө нь

энэ судалгаа хийгдсэн үнэн. Судалгаа хийгдээд яаж байсан гэхлээр зэрэг сарын орлогынхоо 84 хувийг тэтгэврийнхээ зээлд төлбөрт нь өгчхөөд байна. Цаана нь 16 хувийг өөрсдөө хэрэглэх болохоор зэрэг амьжиргаанд нь хүрэхгүй байна гэдэг ийм л бас асуудал үүссэн. Тоог нь та бүхэнд хэлье. Өнөөдрийгөө бид бид нар тооцох юм бол 571760 төгрөгөө бол тэтгэврийнхээ зээлд өгчхөөд цаана нь 110 мянган төгрөгөө амьжиргаандаа хүргэх гэдэг ийм эрсдэлтэй байдал үүссэн.

Тэгэхээр энэ эрсдэлтэй байдал бол нийтлэг байдлаар энэ тэтгэвэр авч байгаа, тэтгэврийн зээл авч байгаа 60.6 хувь буюу өнөөдрийнхөөр тооцох юм бол 505 мянган хүний 60.6 хувь гэдэг 280-аад мянган хүний асуудал байхгүй юу. Тэр 280-аад мянган хүний асуудлыг буюу нийгмийн эрсдэлийг нь бууруулах чиглэлээр бол захиргааны санал гарсан. Захиргааны саналыг бол Монголбанкн дээр бол хараат бус байдлаар бол шинжилгээ хийгээд эндээс бол шийдэл гаргасан ийм л зүйл байгаа. Тэгэхээр энийг би тал талаас илэн далангүй ярих ёстой.

Нөгөө талдаа яг амьдрал дээр хэрэгжээд эхэлсэн сая Идэрбат гишүүний хэлсэн манай гишүүдийн хэлсэн орон нутгаас ч гэдэг юм уу иргэдийн дундаас янз янзын жишээ нь гарч ирж байна. Үнэхээрийн зээл хэрэгтэй байгаад байдаг тэр хэрэгтэй зээл нь шинэ зохицуулалтаар бас бүр төвөгтэй байдал үүссэн ийм зүйл гарч байгаа бол энийгээ бид бол ярилцах ёстой юм байна аа л гэж байгаа юм.

Сая Энхтайван Дэд ерөнхийлөгч бол зөв л хэлж байна. Бид бол үнийг бол 50:50-ийг нь цаашдаа болиулчихъя, тэгээд арилжааны банк бол энийг зохицуулъя гэдэг хувилбар хэлж байна. Нөгөө талдаа Идэрбат гишүүн бол яаж байна гэхээр зэрэг ямар нэгэн байдлаар нийгмийн хамгаалалттай холбоотой энэ чинь санхүүгийн арга хэрэгсэл шүү дээ. Энэ дээр бид бас уян хатан бас боломжтой шинэ хувилбарууд бодож болох уу гэсэн зүйл хэлж байна. Тэгэхээр энийг бид нар өнөөдөр сууж байгаад эндээс шууд ямар нэгэн шийдвэр гарч чадахгүй. Энийг би дахиад нарийн судалж байж тэр хувилбаруудыг та бүхнээр хэлэлцүүлж байж ахиад л ийм шийдэл байж болох уу гэдэг юм гарна.

Ер нь гэхдээ дунд болон урт хугацаанд санхүүгийн саяын иргэний өөрийнх нь шийдвэр гаргах зүйл дээр бол төр хэт их оролцох юм бол энэ өөрөө зохицуулах боломжгүй зүйл. Энийг бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа тийм ээ. Иргэн өөрийнхөө жишээ нь өөрт нь олгогдсон тэр тэтгэврийн мөнгө гэдэг бол өөрт нь олгогдсон захиран зарцуулах ёстой мөнгө шүү дээ. Тэрийгээ яаж зарцуулах вэ гэдэгтэй холбоотой бол санхүүгийн маш нарийн сахилга баттай шийдвэр гаргахаас өөр аргагүй байдаг.

Нөгөө талдаа мэдээж хэрэг хэрэгцээ нь болсон үед бол эрсдэлээ жишээ нь даагаад ч болтугай шийдвэр гаргамаар гэдэг ийм нөхцөл байдал ч гэсэн үүсэж байна. Тэгэхээр энийг тал талаас нь бид ярих ёстой байх аа гэж бодож байна.

Нөгөөтээгүүр бид олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн орон юм НҮБ-ын. Олон улсын хамтын нийгэмлэгээс жил болгон улс орнуудын нийгмийн хамгааллын тайлан гэж гардаг юм. Энэ тайлангууд дээр бид нар тайлангуудыг ашигладаг. Тайлангууд дээр юу юу харагддаг гэхлээр зэрэг аль болох ахмад настан буюу тэтгэврийн насны бүлэг бол өөрөө амьжиргаа нь 2-3 жилд буцаад инфляцтай уялдсан байдлаар, бас бус зүйлтэй уялдсан байдлаар тэтгэвэр нь хүрэхээ байчихдаг ийм эрсдэлтэй бүлэг учраас энэ эрсдэлтэй бүлгийг ядууралд өртчихгүй байх, амьжиргаанд орчихгүй байх энэ чиглэлийн арга хэрэгслийг та бүхэн байнга бодож олох ёстой шүү гэдэг бас

Л.Энхнасан: Дэгээрээ. Эрдэнэбат гишүүн, Идэрбат гишүүн 2 өөрсдөө санаачилсан учраас 1 минут нэмсэн байгаа. Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ үү.

С.Эрдэнэбат: Өглөөнөөс хойш бид нар 12 цаг хуралдаж байна. Олон асуудал орлоо. Ахмадынхаа асуудлыг бас олон ярилаа. Манай Монголбанк маань аливаа шийдвэрийг гаргахад банк санхүүгийнхээ талаасаа Монголбанк мэддэг юм бол нийгмийн бодлогынхоо асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд ярихаас өөр арга байхгүй. Энийг янз бүрээр хэлээд байх шаардлага байхгүй. Ахмадуудын байгаа асуудлыг нь бид нар дордуулчихаад л өнөөдөр уур бухимдлыг нь хүрээд л халуун наранд гадаа суулгаад л, олон хүн өдөр шөнөгүй мессеж бичээд л байж байна л даа.

Тийм учраас энэ тал дээр тэр Засгийн газраас Гэр бүл, хөдөлмөр хамгааллын яамнаас ямар бичиг ирсэн юм тэр бичгийнх нь дагуу шийдчихлээ л гээд л анхнаасаа л юм яриад байсан. Сүүлдээ Засгийн газар буцаалаа болсон. Эргээд авч үзэхдээ хэвийн болгочихлоо л гээд эхэлсэн. Ерөөсөө учир нь олгогдохгүй ийм л юм болоод байна л даа. Тийм учраас энэ тал дээр Монголбанкны маань удирдлагууд тэр мөнгөний бодлогын хараат бус гишүүд энэ тэр гээд байгаа. Иргэдээсээ хараат байх ёстой шүү. Тэр зээлдэгчээсээ хараат бус байх ёстой шүү.

Тийм учраас энэ тал дээр олон талыг харж 7 хэмжиж 1 огтлох хэрэгтэй. Бид нар ахмадуудынхаа тэтгэврийг олигтой өгч чадахгүй болчихоод л аргаа бараад л энэ хүмүүс маань хэдэн төгрөгийн зээл авч, хойд хормойгоороо урд хормойгоо нөхөөд л явж байгаа. Тийм учраас энэ ахмадын асуудал дээр бид нар шийдэл гаргах ёстой. Зүгээр ингэж ярьж байгаад хаячихаж болохгүй. Би Нийгмийн бодлогын байнгын хорооноос тодорхой чиглэл өгөх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Тийм учраас энийг шаардлагатай Улсын Их Хурлаар хуулийг нь санаачилъя, асуудлын оруулъя гэдэг ийм санал байна.

Банк руу чихээд хаяж болохгүй ээ Энхтайван Ерөнхийлөгч өө. Банкнууд тэгсхийж байгаад нэг нэгээр нь гөлөг төөрүүлж байгаа юм шиг юм болчих вий дээ. Тэгэхээр та хэд маань сэтгэл гаргаад энэ ахмадуудын асуудлыг тодорхой энэ чинь нийгмийн зорилтот бүлэг, нөгөө талаар тэр банкнуудад чинь бас тодорхой хэмжээний энэ хүмүүсийн төлсөн Нийгмийн даатгалын сангийн хөрөнгүүд байж байгаа. Хоорондынх нь гэрээ хэлцлийг манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан хүртэл яриад энэ ийм шилжилтийн гэнэ үү энэ үеийг энэ эвтэйхэн зохицуулах юмыг хийгээч ээ. Ахмадуудад орон сууцын зээл олгодоггүй. 45-тай дөнгөж гарчихсан тэтгэвэртэй гарчихсан хүнийг орон сууцын зээл олгодоггүй, жижиг, дунд, бичил зээл олгодоггүй. Тийм учраас эд нар чинь онцгой бүр энэ тэтгэврийнхээ зээлээс өөр барьцаалах юмгүй бас ийм хүмүүс байна. Тийм учраас энэ тал дээр нь бас харж үзээд шийдэх хэрэгтэй байна гэдэг ийм саналыг хэлмээр байна. Тийм учраас ойрын хугацаанд арилжааны банкнуудтайгаа дуудаж авчирч ирээд тэр 50:50 гэдэг харьцааг дахиад жоохон дээш нь болгоод тэр ядаж 70 хувьд нь олгоод тэр олгож байгаа хугацааг нь 36 хувь нь хэд байна вэ банк өөрөө шийдэг гэдэг. Таны энэ үнэн бол бодит байдал дээрээ хэрэгжих тэр бол болж байна. Тэгэхгүй 600, 700-хан мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн 50 хувьд нь болохоор 300 мянган төгрөгийн тэтгэвэр аваад тэрүүгээрээ юу хийх вэ дээ. Тийм учраас энийг харж үзэж тодорхой шийдэл гарга. Ахмадуудаасаа бас энэ асуудлыг удаасанд бас би уучлал бас хүсмээр байна. Тийм учраас энэ тал дээр.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүн үгээ хэлнэ үү.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ тэтгэвэр гэдэг зүйлээ та хэд маань би түрүүн ч бас хэлсэн. Энэ иргэдийн эдийн засаг нийгмийн хамгааллын баталгааг хангаж байгаа зүйл. Та хэдийн гаргаж байгаа шийдвэрээс болоод баталгаа биш болж хувирч байгаа нэг талдаа. Эдийн засгийн хувьд ч гэсэн энэ аягүй буруу шийдвэр. Би түрүүн хэлсэн Монголбанк яаралтай мөнгөний бодлогын хороогоо хуралдуулах хэрэгтэй. Маш яаралтай. Энэ гаргасан алдаагаа зас. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирсэн бичигтэй холбоотой асуудал дээр Мөнгөний бодлогын хорооны гишүүд хараат бусаар шийдвэр гаргадаг учраас тийм айхтар нөлөөлөөгүй ээ гэж Дэд ерөнхийлөгч өөрөө хэлсэн. Тийм учраас үүн дээр аргацааж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дахин бичиг авъя гэж суулгүйгээр Мөнгөний бодлогын хороо та нар өөрсдөө хуралдаад 50:50 гэдэг шийдвэрээ гаргаад явж байгаагийнхаа хувьд энэ Мөнгөний бодлогын хороогоо нэн яаралтай хуралдуул аа гэдгийг та нар бас шаардаж байна. Үгүй бол бид нар бас бүрэн эрхийнхээ хүрээнд та бүхнээс хариуцлага нэхэх асуудлыг хөндөнө. Хариуцлага нэхэх асуудлыг хөндөнө. Тэр Лхагвасүрэн Ерөнхийлөгчөө яаралтай олж ир. Бүр Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дээр Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ таныг яаралтай олж ир гэдэг энэ асуудлыг их хөндсөн гэдгийг нь өөрт нь хэлээрэй. Та нар ард иргэдийнхээ амьдралаар тоглох гэж Мөнгөний бодлогын хороо байгуулаагүй болов уу гэж бодож байгаа. Тийм учраас энэ Мөнгөний бодлогын хороогоо яаралтай хуралдуулахыг та бүхнээс шаардаж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Саранчулуун гишүүн үгээ хэлнэ үү.

О.Саранчулуун: Зээлтэй холбоотой, тэтгэвэр, групптэй холбоотой асуудал дээр ахмадын асуудлуудыг маш сайн ойлгож байна. Мөн бас мартаж болохгүй бүлэг мэдээж бол манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд халамжийн мөнгө бол өнөөдрийн амьдралаа олж авч байгаа, амьдралдаа залгуулж байгаа ганц орлого байгаа. Манайд маш олон банк санхүүгийн байгууллагууд халамжийн мөнгийг зээлийн баталгаа гэж харахгүй байна. Группт орсон, хугацаагүй группт орсон хүмүүс чинь сар болгон тодорхой группийн мөнгөө аваад тэрүүгээрээ байрны түрээсээ төлөөд, тэрүүгээрээ өөрийнхөө жижиг бизнес хийдэг жоохон ч гэсэн юмнуудаа ингэж болгодог байсан. Энэ тэтгэврийн зээлийн асуудалтай холбоотой энэ өөрчлөлт нь олон хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралд өөрчлөлт нөлөөлсөн юм. Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал дээр энэ санхүүгийнх нь юм нь хүрчихээр давхар тэр хүмүүсийг эрүүл мэндийн эрсдэл рүү бас оруулдаг юм. Энийг бас ойлгоод энэ дээр энэ Монголбанкны мэргэжилтнүүд энэ дээр шийдэл гаргаач ээ гэдэг ийм санал, шаардлага бас хэлмээр байгаа.

Ер нь шийдлээ яаж харах ёстой вэ гэхээр халамж, группийн мөнгө тэд нарт байгаа ганц орлого. Тэгэхдээ энийг зээлийн баталгаа болгож харах ийм хандлага болон бодлогын хувьд бас ийм өөрчлөлт баймаар байна. Нөгөө талдаа ер нь энэ энэ эдийн засгийн зээлийн бүтээгдэхүүн гаргаж байгаа бүх л олон улсын төсөл ч байдаг юм уу, банк бус ч байдаг юм уу, санхүүгийн байгууллагууд халамж, сургалт, зээлтэй хослуулсан ийм багц энэ тэр төсөл хэрэгжүүлмээр байна. Монгол Улс өчнөөн л төсөл хэрэгжүүлэх юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бизнес хийж байгаа хүмүүс дэмжиж байгаа юм алга. Мөнгө өгөөд эргүүлээд нөгөө ачааллыг нь дийлэхгүй, эсвэл юу гэдэг юм эргээд эрсдэлд оруулахаар ямар ч баталгаа байхгүй.

Энийгээ эргээд энэ хүмүүст найдваргүй гээд зээл өгөхгүй байх асуудалтай байгаад байгаа юм. Хэрвээ банк хөгжлийн бэрхшээлтэй хүнд зээл олгох гэж байгаа бол тэр бүтээгдэхүүнээ судалмаар байгаа юм. Бага хэмжээгээр ингэж олгож байгаа бол эргээд заагаад өгье, сургаад өгье гээд. Баяр энэ тэр бол тийм сайхан сэтгэл нь хөдлөхөөр хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр жоохон попрох гээд байдаг юм шиг байгаа юм. Хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүн байна, тэгж дэмжье, ингэж дэмжье гээд л тэгдэг юм. Яг амьдралд нь хэрэгтэй урт хугацааны зүйлийг ерөөсөө хийхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр хүн ямар ч байгууллага бай санхүүгийн байгууллагууд санхүүгийнхээ чиглэлээр нийгмийн хариуцлагатай юм хийе л дээ тэгвэл ядаж. Зээл чинь өөрөө тийм тодорхой зээлийн бүтээгдэхүүн байж болдоггүй юм уу? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан бичил зээл байгаа бол? Дагалдаад сургалтыг нь хийгээд өгчихдөг, заагаад өгчихдөг. Хосолсон маягаар байж болдоггүй юм уу гэдэг юм. Ер нь зорилтот зээлийн ийм бүтээгдэхүүн ганцхан би яриад байгаа ч юм биш, олон улс орон иймэрхүү зохицуулалтыг хийдэг юм байна лээ. Бага хүүтэй байж болж байна, эргэн төлөх хугацааны уян хатан байна, хөгжлийн бэрхшээлтэй хүн бизнес хийж эхлэхээр эхний 3 сарын хөнгөлөлт үзүүлж байгаа асуудлууд байна гэх мэтээр олон хувилбар байгаа байхгүй юу. Захын гүүгл/google/-ээр үзэхэд хиймэл оюунаар асуухад зөндөө хувилбар байна. Манайхан жоохон сэтгэлгүй, хайгаад үзчихгүй, хувилбар байвал ийм байна гээд ярилцчихдаггүй. Заавал Улсын Их Хурлын гишүүнээр яриулж байж, заавал Байнгын хороон дээр дуудуулж байж, заавал ингэж хашхируулж байж юм ингэж үйлдэл хийдэг энэ хандлагаа болимоор байна. Би ч гэсэн бас энэ хашхирахаас бас бас ер нь залхаж байна.

Өнөөдөр мөн адилхан бас би шаардлага хүсэж байна. Мөнгөний бодлогын хороо байдаг санж уу, СЗХ байна уу, Монголбанк байна уу банк санхүүтэй холбоотой иргэдэд нийтийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг бүх л энэ бодлого тодорхойлох субъектүүдээс би шаардмаар байна. Энэ иргэдэд зориулсан бизнес дэмждэггүй юм бол ядаж тэр авч байгаа зээл мөнгөнд нь нөлөөтэй шийдвэрүүд гаргахдаа болгоомжтой байгаач ээ гэдгийг хэлмээр байна. Мөн хувилбарт үйлчилгээнүүдийг хэрэгжүүлээч ээ, санаачлаач ээ гэдгийг бас шаардаж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүн үгээ хэлнэ үү.

Д.Үүрийнтуяа: Бид ч ард иргэдээ үгүй ээ мөн их бухимдуулах юм даа. Тэтгэврийн зээлийн хэмжээ ер нь яагаад нэмэгдээд байгаа юм? Нэг талаас энэ улс төрчдийн хариуцлагагүй мэдэгдэл, худал амлалтууд шууд нөлөөлж байгаа шүү дээ. Яг л жилийн өмнө сонгуулийн шоу хийгээд л тэтгэврийн зээлийг тэглэнэ. Ийм амлалтыг өгөөд л улс төрчид явж байсан. Өнөөдөр энэ тэтгэврийн зээл нэмэгдэхэд бас тодорхой хэмжээгээр үүрэг гүйцэтгэсэн шүү энэ нөхцөл байдал.

Нөгөө талаас тэтгэвэр хүрэлцээтэй биш байгаагийн илрэл шүү дээ энэ бол. Яагаад зээл аваад байгаа юм, тэр орлого нь хүрсэндээ гэдэг юм уу, бизнес хийх гээд тэрийгээ нэмэгдүүлэх гээд байгаадаа биш шүү дээ өнөөдөр. Ер нь тэтгэврийн тогтолцоо энэ тэтгэврийн даатгалын сангийн менежментийг хийхгүйгээр шууд хязгаарлалт хийгээд байгаа нь гэнэтийн шийдвэрийг урьдчилж мэдэгдэхгүйгээр ямар нэг хугацаа өгөлгүйгээр шууд хэрэгжүүлж байгаагаас л ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм Монголбанкны эрхэм дарга нар аа, төр засаг ард иргэдийнхээ амьдралд шууд нөлөө үзүүлдэг ийм шийдвэр гаргахдаа бид нар статистик тоо баримт харахаас гадна амьдрал дээр, хөрсөн дээр бодит нөхцөл байдлыг хардаг,

мэдэрдэг, судалдаг, түүнийгээ уялдуулдаг л баймаар байгаа юм. Ард иргэдийн амьдралд аль болох амьдралын чанарт нь сөрөг нөлөө бага үзүүлэхээр үе шаттайгаар шийдвэрээ авч хэрэгжүүлдэг ийм арга барил өнөөдөр аль ч бодлого шийдвэр гаргаж байгаа энэ төрийн байгууллага төрийн захиргааны төв байгууллагууд манай Монголбанканд ч бас дутагдаад байна л гэдгийн нэг илрэл юм энэ.

Ер нь өнөөдөр тэтгэвэр, тэтгэмж, энэ халамжийн мөнгөөрөө өрхийн орлогын орлогынхоо гол цөмийг бүрдүүлж байгаа өрх олон байна шүү дээ. Ард иргэдийн амьдрал ямар байгааг л энэ харуулаад байгаа юм л даа. Сайнгүй байна гэдгийн илрэл шүү дээ нөгөө талаараа. Энэ орлогоо өдөр тутамдаа юунд зарцуулах вэ гэдгээ төлөвлөчихдөг. Би тэдэн төгрөгийн тэтгэвэр авдаг, тэрийгээ тэтгэврийн зээлдээ тэдийг нь өгнө, дуусаад ирэхээр нь дараагийнхаа асуудлыг шийдэхийн тулд тэтгэврийн зээл тэдэнд дуусна.

Тэгэхээр нь нэмээд тэдэн төгрөгийн зээл авна гэдгээ тооцоод л хүргэж ядаад л амьдарч байгаа амьдрал шүү дээ. Яг ийм нөхцөл байдалд нь өнөөдөр энэ орлогыг нь төлөвлөж байгаа энэ төлөвлөчихсөн энэ нөхцөл байдал руу нь гэнэтийн шийдвэр гаргаад өр төлбөр үүсгэхээр өрхийн амьжиргааны эх үүсвэр нь дутагдаад ирэхээр ард иргэд бухимдаад байгаа байхгүй юу. Огцом шийдвэрүүд ард иргэдийн амьдралд бас хүчтэй цохилтууд болж байгаагийн нэг жишээ. Сүүлийн үед ийм шийдвэрүүд их гардаг боллоо. Нэг жишээ.

Тэгэхээр энэ тэтгэврийн зээлийн зохицуулалтын талаар гаргасан энэ шийдвэрээ Монголбанк эргэж харах хэрэгтэй байх. Эрхэм банкирууд хараат бусаар шийдвэр гаргахдаа бодит амьдрал хууль эрх зүйн нөхцөл байдлаа бас судалж мэдрэмжтэй хандаасай гэж хүсэж байгаа юм. Энхнасан дарга Нийгмийн бодлогын байнгын хороо бид өнөөдөр бас олон асуудлыг авч хэлэлцлээ. Бүхэл бүтэн бараг 12 цаг хуралдаж байна. Бас чухал шийдвэрүүдийг гаргалаа. Их чухал мэдээллүүдийг сонслоо. Би бас өмнө хэлсэн гишүүдтэйгээ санал нэг байна. Яг энэ асуудлаар тэтгэврийн зээлийн зохицуулалт хийсэн асуудлаар Монголбанканд Засгийн газарт тодорхой шаардлага, зохицуулалт хийх үүрэг даалгавруудыг өгсөн тогтоол, шийдвэрийг гаргаж хүргүүлэх нь зүйтэй байх. Шаардлагатай бол Улсын Их Хурлын чуулганаар энэ асуудлыг оруулж хэлэлцүүлэх, нэн шаардлагатай бол ажлын хэсэг гаргаад ажиллах ийм Их Хурлын парламентын зүгээс хийх ёстой ажлаа өнөөдөр Нийгмийн бодлогын байнгын хороо бас ахмадуудынхаа, ард иргэдийнхээ амьдралын төлөө хийх ёстой гэж ингэж харж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Өнөөдөр Төв банкны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монголбанк төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө зээлийн байдлын талаарх Улсын Их Хурлын шаардлагатай тохиолдолд танилцуул гэж заасны дагуу Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өндөр настны тэтгэврийн асуудлаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос 2025 он оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар тэтгэврийн зээлийн өр, орлогын дээд хязгаарыг 50 хүртэлх хувиар тогтоохоор шийдвэрлэсэн 2025 оны 3 дугаар шийдвэр ийн үндэслэлийг сонслоо.

Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн санал, иргэдийн хүсэлтийг тусгаж Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийг Монголбанканд хүргүүлнэ. Мөн энэ

шийдвэрийг дахин харж үзэж ирэх 7 хоногт Мөнгөний бодлогын хорооны хурлыг хуралдуулахыг үүрэг болгож байна.

Өнөөдрийн хуралдааныг дууссаныг мэдэгдье. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

20.46 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР